

ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ МОНГОЛ УЛСАД 15 ЖИЛ

Хүүхдийг Ивээх Сангийн үйл ажиллагааны товч түүх

Улаанбаатар хот
2009 оны 8 сар



АГУУЛГА

Өмнөх үг	3
Талархал	4
Товчилсон үгийн тайлбар	5
Удиртгал	6
1. Хүүхдийг Ивээх Сан Монголд ажиллаж эхэлсэн үеийн нөхцөл байдал	8
2. Бидний баримталсан стратегийн гол асуудлууд	10
• Эмзэг бүлгийн хүүхдүүдэд онцгой анхаарах	
• Ядуурлыг бууруулахад туслах	
• Хүүхэд төвтэй үйлчилгээг хөгжүүлэх	
• Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих	
3. Монголын хүүхдүүдийн сайн сайхны төлөө ХИС–гийн оруулсан хувь нэмэр	12
• Ядуурлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа (1994 –2000)	12
• Нийгмийн ажлын хөгжилд үзүүлсэн дэмжлэг (1994 –2002)	14
• Хараа хяналтгүй болон хөдөлмөр эрхлэгч хүүхдийн хамгаалал ба нөхөн сэргээлт (1994 оноос)	17
• Сургуулийн өмнөх боловсролын хөгжилд оруулсан хувь нэмэр (1994 –2000)	23
• Сургуулийн өмнөх болон бага боловсролыг бэхжүүлэх нь (2000 оноос)	25
• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролыг дэмжсэн алхмууд (1998 оноос)	28
• Үндэсний цөөнхийн хүүхдийн боловсролыг дэмжсэн ажлууд (1998 оноос)	31
• Эрхэд суурилсан боловсролын системийг дэмжих нь (2005 оноос)	32
• Гамшгийн үеийн тусламж	34
• Олон нийтэд түшиглэсэн хүүхдийн хөгжил, хамгааллын механизмыг хөгжүүлэх нь (2003 оноос)	36
• Хүүхэд хамгааллын тогтолцоог хөгжүүлэх нь (2005 оноос)	39
• Хүүхдүүдтэй хамтран ажилласан туршлага (1994 оноос)	41
4. Хүүхдийг Ивээх Сангийн үйл ажиллагааг эргэн дүгнэхүй	46
5. Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь Хөтөлбөрийн талархал	57
6. Манай хандивлагч байгууллагууд (1994–2009)	58
7. Хэвлэн нийтлэсэн номын жагсаалт (2005–2009)	59
8. Хүүхдийг Ивээх Сангийн үйл ажиллагааны он цагийн зураглал ба холбогдох бодлого, хууль эрх зүйн өөрчлөлтүүд (1994–2009)	63
9. Зургийн цомог	

ӨМНӨХ ҮГ

Их Британий Хүүхдийг Ивээх Сангаас Монголын хүүхдүүдийн сайн сайхны төлөө хийсэн ажил, хуримтлуулсан туршлага, хүрсэн амжилт, оруулсан хувь нэмрийг тоймлон харуулсан энэхүү дурсамж номыг уншигч танд хүргэж байгаадаа би туйлын баяртай байна.

Хүүхдийг Ивээх Сан 1994 оноос өнөөдрийг хүртэл эмзэг бүлгийн хүүхдүүдэд чиглэсэн их ажлыг хийсэн билээ. Энэ хооронд янз бүрийн зориулалтаар олон тооны ном, материал хэвлэн гаргаж байсан хэдий ч Монголын хүүхдүүдийн сайн сайхны төлөө хийж гүйцэтгэсэн ажил, хуримтлуулсан туршлагаа тоймлон нэгтгэж ном болгон нийтлэсэн нь үгүй билээ. Иймд энэхүү номыг бэлтгэн гаргаж, Монголд ажилласан 15 жилийн хугацаандаа Хүүхдийг Ивээх Сан хүүхдийн эрхийг хангах талаар юу хийсэн, яаж ажилласан, ямар үр дүнд хүрсэн талаарх мэдээллийг баримтжуулан үлдээж байна.

Бид энэ номондоо Хүүхдийг Ивээх Сан Монголд ажилласан хугацаан дахь улс орны түүхэн болон хөгжлийн нөхцөл байдлыг товчхон тусгаж, зарим үйл ажиллагааныхаа талаарх мэдээллийг гэрэл зургуудаар баяжуулан хүргэж байна. Мөн бидний хийсэн болон дэмжиж ажилласан үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх хувь хүмүүс, байгууллагын талаарх кэйс жишээнүүдийг орууллаа.

Энэхүү номыг яг одоо гаргаж байгаа нь цаг хугацааны хувьд хэд хэдэн учир шалтгаантай юм. Юуны өмнө Хүүхдийг Ивээх Сан Монголд үйл ажиллагаагаа эхэлсний 15 жилийн ой тохиож буйтай холбоотой билээ. Мөн Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь Хөтөлбөрийн үйл ажиллагааг 2009 оны 7 сард хаах шийдвэр гарсантай холбогдуулан бид өнгөрсөн хугацааны үйл ажиллагаагаа баримтжуулан үлдээхээр шийдсэн юм. Түүнчлэн, хүүхдийн эрхийн төлөө Монголд хийж ирсэн ажил үйлсийг маань үргэлжлүүлэн авч явах Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвслийн гишүүн Японы Хүүхдийг Ивээх Сан болон бусад хувь хүмүүс, байгууллагуудад “хүүхдийн эрхийн бамбар”-ыг бид дамжуулан өгч байна.

Энэхүү ном нь та бидний хаана ажиллахаас үл хамааран, хүүхдийн сайн сайхны төлөөх бид бүхний сэтгэл, зүтгэлд, урам зоригийг нэмэх болно гэдэгт итгэж байна.

Мицуаки Тоёода
Их Британий Хүүхдийг Ивээх Сангийн
Монгол дахь захирал



ТАЛАРХАЛ

Энэхүү дурсамж номыг бэлтгэн гаргахад оролцсон бүх хүмүүст Хүүхдийг Ивээх Сан талархал илэрхийлж байна.

Монгол дахь Хөтөлбөрийн 15 жилийн туршлага, амжилт ололтыг нэгтгэн бичих энэ амаргүй ажилд гол үүрэг гүйцэтгэсэн Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь Хөтөлбөрийн захирлаар ажиллаж байсан Чулууны Тунгалагт Хүүхдийг Ивээх Сан талархал илэрхийлж байна. Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь захирлын албыг хашиж байсан үеийнхээ дурсамжаас цаг гарган хуваалцсан ноён Жон Буклер, Марк Лапорт, Карло Пушкарица, Мицуаки Тоёода нарт Хүүхдийг Ивээх Сан мөн талархаж байна.

Мөн энэ ажилд чин сэтгэлийн хувь нэмрээ оруулсан ХИС–гийн үе үеийн ажилтнууд, тухайлбал Доржсамбуугийн Амараа, Цэндийн Ариунтунгалаг, Адилбишийн Батхишиг, Эрдэнэбилэгийн Дуламсүрэн, Лувсаншаравын Дулмаа, Цэгмэдийн Гэрэлтуяа, Чулуунтулгын Жаргал, Бямбажавын Нарантуяа, Санжаагийн Нарантуяа, Доржийн Олончимэг, Рэнцэндоржийн Оюунбилэг, Түмээгийн Цэндсүрэн, Бадрахын Эрдэнэчимэг нарт талархал илэрхийлье.

Энэхүү дурсамж номыг хэвлэн нийтлэхэд санхүүгийн сэтгэл харамгүй туслалцаа үзүүлсэн эрхэмсэг Элчин сайд, хатагтай Торда Аббот Воттод Хүүхдийг Ивээх Сан гүн талархал илэрхийлж байна. Номын англи хэл дээрх эхийг хянасан Жулиана Түллүст талархаж байна.

Мөн өөрсдийн хувийн болон байгууллагын талаарх мэдээллийг энэ номд оруулахыг зөвшөөрч, номын агуулгыг бодит жишээгээр баяжуулахад хувь нэмэр оруулсан хүүхдүүд, хувь хүмүүс, байгууллагуудад гүн талархал илэрхийлье.

Их Британий Хүүхдийг Ивээх Сангийн
Монгол дахь Хөтөлбөр

2009 оны 8 дугаар сар

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БСШУЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам
FDG	Fondation Dufresne et Gauthier /Дюфресне ба Готье Сан
ИБ ХИС	Их Британий Хүүхдийг Ивээх Сан
ЗХЖТ	Зохистой Хөгжлийн Жендэр Төв
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МХЭТ	Монголын Хүүхдийн Эрхийн Төв
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБ ХС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан
НҮБ ХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
НҮБ ХЭК	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Эрхийн Конвенц
НҮБ ХЭХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Эрхийн Хороо
НХТ	Нийгмийн Хөгжлийн Төв
НХХЯ	Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
СӨБХҮХ	Сургуулийн Өмнөх Боловсролыг Хөгжүүлэх Үндэсний Хөтөлбөр
СӨБББЧСТ	Сургуулийн Өмнөх ба Бага Боловсролын Чанарыг Сайжруулах Төсөл
ТББ	Төрийн Бус Байгууллага
ҮБДС	Улсын Багшийн Дээд Сургууль
УИХ	Улсын Их Хурал
ХБХЭЭХ	Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдүүдийн Эцэг, Эхийн Холбоо
ХИС	Хүүхдийг Ивээх Сан
ХТҮТ	Хүүхдийн Төлөө Үндэсний Төв
ХТҮГ/ХТГ	Хүүхдийн Төлөө Үндэсний Газар / Хүүхдийн төлөө Газар
ХЭҮТ	Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв
ЭЗХТЗ	Эдийн Засгийн Харилцан Тусалцах Зөвлөл

УДИРТГАЛ

Их Британий Хүүхдийг Ивээх Сан (ИБ ХИС) нь 1919 онд байгуулагдсан, дэлхийн хүүхдийн эрхийн бие даасан байгууллага юм. Хүүхдийг Ивээх Сан (ХИС)-г үүсгэн байгуулагч хатагтай Еглантин Жебб хүүхдийн эрхийн асуудлыг дэлхийд анх дэвшүүлэн тавьж, хүүхдийн эрхийн тунхагийг анхлан боловсруулж байсан түүхээр ХИС үргэлж бахархдаг билээ. Түүний боловсруулсан хүүхдийн эрхийн тунхаг нь 1924 онд Үндэстнүүдийн Лигээр¹ батлагдсанаар ХИС хүүхдийн эрхийн дэлхийн анхдагч байгууллага болсон түүхтэй. Энэхүү тунхаг нь 1989 онд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Конвенц болж батлагдсан бөгөөд өнөөдөр дэлхий дээр хамгийн олон улс нэгдэн орсон хүний эрхийн конвенц болоод байна. НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Конвенцид тунхагласан зарчим, эрх, үүргүүд нь ХИС-гийн үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлдог билээ.

ХИС 1994 оноос өнөөдрийг хүртэл Монголын хүүхдүүд, тэр дундаа эмзэг бүлгийн болон хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдийн сайн сайхны төлөө цуцалтгүй ажиллаж ирлээ.

1993 оны 8 сард Их Британий эрхэмсэг гүнж Анна Элизабет Алис Луис Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үр дүнд Монгол Улсын Засгийн газар болон ХИС-гийн хамтын ажиллагааны гэрээг үзэглэсэн байдаг. Дараа оны хоёрдугаар сард ХИС-гийн Монгол дахь Хөтөлбөр захирал Жон Буклер болон үндэсний гурван ажилтантай үйл ажиллагаагаа эхэлсэн юм.

Тэр цагаас хойш ХИС-гийн Монгол дахь Хөтөлбөр ихээхэн өргөжиж, нэгэн үе 80 ажилтантай, 2 салбар, олон нийтэд түшиглэсэн Хүүхэд хөгжил, хамгааллын 7 төвөөр дамжуулан үйл ажиллагаа явуулж байв. Энэ арван таван жилд ХИС үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөтгөн, хөтөлбөрийн арга барилаа шинэчлэн хөгжүүлж, боловсон хүчний болон санхүүгийн нөөцөө амжилттай өргөжүүлж ирсэн билээ. Төрийн болон төрийн бус байгууллагууд, олон нийт, хүүхдүүдтэй үр бүтээлтэй хамтран ажилласан олон жилийн хөдөлмөрийн үр дүнд ХИС өнөөдөр Монгол Улсад хүүхдийн эрхийн чиглэлээр олонд танигдсан байгууллага болж чадсан юм.

ХИС-гийн Монголд ажилласан 15 жилийн ажил, хуримтлуулсан туршлага, хүрсэн амжилт, Монголын хүүхдүүдийн сайн сайхны төлөө оруулсан хувь нэмрийг эргэж дүгнэх цаг нэгэнт иржээ. Иймд ХИС өнгөрсөн хугацааныхаа туршлага, ололтоо энэхүү номд нэгтгэн дүгнэж, уншигч танд хүргэж байна.

Хүүхдийг Ивээх Сангийн алсын хараа

Бид
Хүүхэд бүрийг хүндлэн дээдэлдэг,
Хүүхдийг сонсч, хүүхдээс суралцдаг,
Бүх хүүхдэд итгэл найдвар, тэгш
боломжийг олгосон
Дэлхий ертөнцийг бий болгохын төлөө
ажилладаг.

Эрхэм зорилго

Хүүхдийг Ивээх Сан хүүхдийг эрхийн төлөө тэмцэн, хүүхдийн сайн сайхны төлөө эрчимтэй, тогтвортой үйл ажиллагааг дэлхий даяар явуулна.

¹ Үндэстнүүдийн Лиги /1919–1946/ нь НҮБ-ын өмнөх байгууллага бөгөөд “даян дэлхийд энх тайван, аюулгүй байдлыг хангахын төлөө олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх” зорилготой байгууллага байв.

ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САН МОНГОЛД АЖИЛЛАЖ ЭХЭЛСЭН ҮЕИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ



ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САН МОНГОЛД АЖИЛЛАЖ ЭХЭЛСЭН ҮЕИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

ХИС үйл ажиллагаагаа эхлүүлсэн 1990–ээд оны дунд үед² Монгол Улс төвлөрсөн эдийн засгийн системээс зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үеийн нийгэм, эдийн засгийн туйлын хүнд нөхцөлд байсан билээ. Шилжилтийн эхэн үед ЭЗХТЗ³ болон ОХУ–ын тусламж зогсож, Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний гуравны нэгтэй тэнцэж байсан дэмжлэг үгүй болсон нь нийгмийн амьдралд хүндээр туссан юм. Эдийн засгийн үзүүлэлтүүд 1989–1994 онуудад жил дараалан буурч, 1992–1993 онд хүн амын бодит орлого хоёр дахин багасч, 1993 онд дахин гуравны нэгээр буурсан байлаа. Мөнгөний ханш зогсолтгүй унасаар 1993 онд 300%–д хүрсэн байв.

Энэ үед Монгол Улсын Засгийн газар бүтцийн өөрчлөлтийн бодлогыг хэрэгжүүлж, төрийн өмчийг хувьчлах, зах зээлийн чөлөөт үнэд шилжих, төрийн үйлчилгээний татаасыг бууруулах зэрэг ажлыг шат дараалан хэрэгжүүлсэн бөгөөд улс орны нийгмийн бодлогыг тухайн үеийн бүтцийн өөрчлөлт болон санхүүгийн эх үүсвэрийн хомс байдалд зохицуулахаас өөр аргагүй байсан юм.

Монгол Улс зах зээлийн эдийн засагт хөл тавих шилжилтийн үеийн эдийн засаг, санхүүгийн хямралын нийгмийн үр дагавар нь ихээхэн тодорч ирсэн тэр үед ХИС Монголд анх орж ирсэн юм. 1990 оноос өмнө байхгүйд тооцогдож байсан ядуурал, ажилгүйдэл нийгмийн хурц асуудал болж, 1995 он гэхэд хүн амын 36,3% нь ядуу амьдралтай байлаа.⁴ Бүтцийн өөрчлөлтөөс үүдэлтэй ажилгүйдэл ихэсч, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн салбарын хөрөнгө оруулалт, үйлчилгээ эрс хумигдсанаар Монгол Улсын нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүд ихээхэн буурсан юм.

Хот, хөдөөд эрүүл мэндийн систем хямарч, 1991–1993 онд эхийн эндэгдэл хоёр дахин нэмэгдээд байв. Томоохон хотууд, алслагдсан орон нутагт сургууль завсардах, сургуульд сурахгүй байх явдал газар авч эхэлсэн байв.

Сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг төрөөс даах явдал зогссоноор 1989–1992 онд дотуур байранд амьдардаг хүүхдийн тоо 2 дахин буурч, сургууль завсардалт эрс нэмэгдэв. 1990–1995 оны хооронд улсын хэмжээнд нийт цэцэрлэгийн тоо 909 –өөс 660 болтлоо цөөрч, сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын хувь 27,9 % –иас 18,8% хүртэл буурсан байв.⁵



Сургууль, цэцэрлэгийн үйлчилгээний энэ хямралаас шалтгаалан гэр бүлийн амьдралд ихээхэн дарамт учирч, олон тооны эхчүүд ажил эрхлэх боломжгүй болсон юм. Өнчин болон хаягдмал, гэрээсээ дайжиж гудамжинд гарсан хүүхдийн тоо өсч, 1989 оноос өмнө байхгүй байсан “гудамжны хүүхдийн” тоо 1990–ээд оны дунд үе гэхэд 1500–4000 орчимд тооцогдож байлаа. Эрэгтэйчүүдэд ажилгүйдлээс үүдэн ирэх нийгмийн дарамт ихэсч, архидалт, гэр бүлийн хямрал, салалт нэмэгдсэн зэрэг нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл ихсэх бас нэг шалтгаан болж байсан юм.

² ХИС–гийн Монгол дахь Хөтөлбөрийн Стратегийг /1995–2000/ боловсруулах ажлын хүрээнд хийсэн “Нөхцөл байдлын судалгаа”, 1994

³ Эдийн Засгийн Харилцан Тусалцах Зөвлөл (ЭЗХТЗ), 1949–1991

⁴ Дэлхийн Банкны дамжлэгтэйгээр, Монгол улсын Статистикийн Үндэсний Газраас хийсэн “Амьжиргааны түвшин тогтоох судалгаа”, 1995

⁵ “Бүх Нийтийн Боловсрол” үнэлгээ, 2000

БИДНИЙ БАРИМТАЛСАН СТРАТЕГИЙН ГОЛ АСУУДЛУУД



БИДНИЙ БАРИМТАЛСАН СТРАТЕГИЙН ГОЛ АСУУДЛУУД

1993 онд ХИС–гийн бүсийн салбараас Дэлхийн Банкны захиалгаар хийж гүйцэтгэсэн “Монголын эмзэг бүлгийн хүмүүсийн нөхцөл байдлын үнэлгээ” болон 1994 онд хийсэн бусад судалгаа, баримтат үндэслэн ХИС–гийн Монгол дахь Хөтөлбөр стратегийн асуудлуудаа дараах байдлаар тодорхойлсон юм. Үүнд:

Эмзэг бүлгийн хүүхдүүдэд онцгой анхаарах:
Шилжилтийн үеийн хүндрэлүүд нь Монголын нийгмийг бүхэлд нь хамарч байсан ч хүүхдүүдэд хамгийн хүндээр тусч байсан юм. Өмнөх тогтолцооны үеийн хүүхдэд чиглэсэн нийгмийн үйлчилгээ үндсэндээ үгүй болж хүүхдийн төлөөх байгууллагууд санхүүгийн болон арга зүйн хямралд ороод байсан нь хүүхдэд хамааралтай маш олон тулгамдсан асуудал гарч ирэхийн үндэс болсон юм. Иймд ХИС хүүхдийн эдгээр асуудалд онцгой анхаарал хандуулах шаардлагатай гэж үзсэн юм.

Ядуурлыг бууруулахад туслах:

Өрхийн түвшин дэх ядуурал хүүхдэд хүндээр тусч байв. Ядуурлыг бууруулах нь шилжилтийн үед эмзэг бүлгийн хүүхдүүдийн өмнө тулгарч байсан олон асуудлыг бүрэн шийдвэрлэхгүй ч өрхийн түвшинд ядуурлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа нь хүүхдийн нөхцөл байдалд богино хугацаанд бодитой өөрчлөлт хийх зөв арга гэж ХИС үзсэн юм. Иймээс ядуурлыг бууруулах асуудлыг ХИС өөрийн стратегийн нэг хэсэг болгон авсан бөгөөд энэ талаарх ойлголт, хамтын ажиллагааны эхлэл ХИС–гийн харьцангуй давуу тал байлаа.

Хүүхэд төвтэй үйлчилгээг хөгжүүлэх:

Монголын шилжилтийн өмнөх үеийн, хүүхдэд чиглэсэн нийгмийн үйлчилгээнүүд нь олон улсын хэм хэмжээ, зах зээлийн эдийн засагт шилжих Засгийн газрын бодлогод уялдан өөрчлөгдөж чадахгүй байлаа. Иймд боловсрол, нийгмийн тусламжийн үйлчилгээнүүдийн чанарыг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон хүнд нөхцөлд байгаа хүүхдүүд (тухайлбал хараа хяналтгүй болон хөдөлмөр

эрхлэгч хүүхдүүд)–ийн нөхцөл байдлыг сайжруулахын тулд хүүхдийн эрхийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, үйлчилгээнд хүүхэд төвтэй арга зүйг нэвтрүүлэх шаардлагатай байлаа.

Иргэний нийгмийг хөгжлийг дэмжих:

Боловсролын болон нийгмийн халамжийн систем бүхлээрээ хямарсан нь иргэдийн оролцоонд тулгуурласан хөгжлийн шинэ хандлагыг шаардаж байв. Оролцоонд тулгуурласан хөгжлийн шинэ хандлагыг Монголд нэвтрүүлэх нь олон нийтийг хөгжүүлэх, иргэдийг идэвхжүүлэхэд онцгой чухал үүрэг гүйцэтгэнэ гэж ХИС үзсэн юм.



**МОНГОЛЫН ХҮҮХДҮҮДИЙН
САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ
ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН
ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР**





МОНГОЛЫН ХҮҮХДҮҮДИЙН САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

Ядуурлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа (1994–2000)

Ядуурлыг Бууруулах Үндэсний Хөтөлбөрийн (ЯБҮХ, 1996–2000) хүрээнд хүүхдийн эмзэг байдлыг бууруулах, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхэд ХИС чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

ЯБҮХ–ийн үйл ажиллагаанд оролцох нь ХИС–гийн хувьд стратегийн чухал сонголт байсан юм. Учир нь ХИС–гийн тухайн үеийн санхүүгийн хязгаарлагдмал нөөцөөр хүүхдүүдийн өмнө тулгарч байсан шилжилтийн үеийн олон асуудлуудыг шийдэх боломжгүй байсан юм. Ийм нөхцөлд хөрөнгийн илүү чадвартай доноруудын үйл ажиллагааг хүүхдэд чиглүүлэхэд ХИС гол анхаарлаа хандуулсан юм.

ХИС–гийн бүсийн салбарын тусламжтайгаар, ХИС–гийн Монгол дахь хөтөлбөр ЯБҮХ–т оролцох үйл ажиллагаагаа богино хугацаанд эрчимтэй өргөжүүлж чадсан юм. ЯБҮХ–ийг үндэсний болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад ХИС идэвхтэй оролцож, ЯБҮХ–ийн хэрэгжилтэд төвлөрлийг сааруулсан арга зүйг нэвтрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. ЯБҮХ–ийн төслийн баримт бичигт хүүхдийн асуудал бага тусгагдсан байсныг өөрчилж сургуулийн өмнөх боловсролын асуудлыг ЯБҮХ–ийн нэг чухал хэсэг болгон оруулсан юм. ЯБҮХ–ийн Орон Нутгийн Хөгжлийн Сангийн дор сургуулийн

ЯБҮХ–ийн Орон Нутгийн Хөгжлийн Сангийн дор Сургуулийн өмнөх боловсролын дэд сан бий болгон байршуулах гэрээнд 1997 оны 7 сарын 7 өдөр Талууд гарын үсэг зурлаа.



өмнөх боловсролын дэд сан бий болгон байршуулснаар сургуулийн өмнөх боловсрол олгох орон нутгийн үйл ажиллагааг дэмжих боломжийг бүрдүүлсэн билээ.

ХИС–гаас санаачлан хэрэгжүүлсэн нийгмийн хөгжлийн чадавхи бэхжүүлэх сургалтууд нь ЯБҮХ–ийг аймаг, сумын түвшинд хэрэгжүүлэгч ажилтнуудын нийгмийн хөгжлийн талаарх мэдлэг, ажлын арга барилыг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Орон нутгийн байгууллагын чадавхи бэхжүүлэх зорилгоор ХИС–гаас зөвлөх үйл ажиллагаа эрхэлдэг орон нутгийн байгууллагыг дэмжиж ажилласны үр дүнд Төрийн Захиргаа, Удирдлагын Хөгжлийн Институт (ТЗУХИ)–ийн дэргэд Нийгмийн Хөгжлийн Төв (НХТ) үүсгэн байгуулагдсан билээ. НХТ нь улмаар нийгмийн хөгжлийн чадавхи бэхжүүлэх ХИС–гийн үйл ажиллагаанд гол хамтрагч байгууллага болсон юм. ХИС, НХТ–өөс хамтран улсын хэмжээнд явуулсан нийгмийн хөгжлийн чадавхи бэхжүүлэх сургалтууд нь ЯБҮХ–ийн хэрэгжилтийг олон нийтэд тулгуурлах нөхцлийг хангаж, хөтөлбөрийн хэрэгжилт, шийдвэр гаргахад орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлснээрээ тэднийг чадавхижуулсан үйл явц болж чадсан билээ.

Орон нутгийн иргэдийн оролцоонд суурилсан хөгжлийн энэ хандлага нь тухайн үедээ Монгол Улсад шинэ ойлголт байсан юм. Орон нутгийн хөгжлийн асуудлаар шийдвэр гаргахад олон нийтийн оролцоо чухал гэдгийг орон нутгийн удирдлага болон олон нийтэд өөрсдөд нь ойлгуулах, аймаг сумын түвшний ядуурлыг бууруулах үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, хяналтад олон нийтийн оролцоог жинхэнэ утгаар нь хангах арга барилд аймаг, сумын ажилтнуудыг сургах нь хялбар ажил биш байв.

Зүүн гар талаас:
ХИС–гийн хөтөлбөрийн захирал Жон Буклер,
Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жон Дурам,
БСШУ–ны сайд ЧЛХагважав.

Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд Архангай аймагт хэрэгжүүлсэн “Малжуулах төсөл”-д орон нутгийн хэрэгцээг үнэлэх, үйл ажиллагааг төлөвлөх, шийдвэр гаргах олон нийтийн оролцооны аргуудыг амжилттай хэрэгжүүлсэн нь зөвхөн энэ үйл явцад оролцсон олон нийт төдийгүй манай сургагчид, хамтран ажиллагсдад орон нутгийн мэдлэг, чадвар, оролцоонд тулгуурлах итгэлийг бий болгосон юм.

Азийн Хөгжлийн Банкны санхүүгийн тусламжтайгаар ХИС, Нийгмийн Хөгжлийн Төвтэй хамтран ЯБҮХ-ийг бэхжүүлэх техник туслалцааны төслийг хоёр жилийн хугацаанд хэрэгжүүлсэн билээ. Энэ ажлын хүрээнд нэн ядуу иргэдийн эн тэргүүний хэрэгцээг хангахад зориулж санхүүгийн туслалцаа үзүүлэх санг Монгол Улсад анх удаа бий болгож, орон даяар хэрэгжүүлэх ажилтнуудыг сургасан юм. 1994 онд батлагдсан ЯБҮХ-ийн анхны баримт бичигт ийм сан байгуулахаар төлөвлөгдсөн байсан ч 1996 он хүртэл энэхүү санг хэрхэн зохион байгуулах бодлогын баримт бичиг байхгүйгээс хэрэгжих боломжгүй байсан юм.

Мөн энэ техник туслалцааны ажлын хүрээнд ЯБҮХ-ийн оролцооны аргад суурилсан мониторинг, үнэлгээний системийг боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх орон нутгийн чадавхийг бий болгох, холбогдох ажилтнуудыг сургах ажлыг орон даяар зохион байгуулав. Төслийн мониторинг, үнэлгээний асуудал тухайн үед шинэ ойлголт байсан төдийгүй энэ үйл ажиллагааг оролцооны аргаар хийх нь бүр ч шинэлэг зүйл байсан юм. Хоёр жилийн хугацаанд хэрэгжүүлсэн техник туслалцааны энэ төслийн үр дүнд орон нутгийн хөгжилд оролцооны аргыг нэвтрүүлэх арга зүйн суурь амжилттай тавигдсан бөгөөд оролцооны мониторинг, үнэлгээний үндсэн зарчмуудыг ЯБҮХ-ийн дараагийн шатны хөтөлбөр болох “Тогтвортой амьжиргаа” төслийн мониторинг, үнэлгээний системд үргэлжлүүлэн ашиглаж байгаа билээ.

ЯБҮХ-ийн хүрээнд хийж гүйцэтгэсэн дээрх ажлуудаас гадна ХИС тус хөтөлбөрийн хүрээнд дорвитой дэмжигдэх боломжгүй байсан хүн амын зарим бүлгүүд, тухайлбал, өрх толгойлсон, олон хүүхэдтэй эмэгтэйчүүд болон хөдөөгийн малчин өрхүүдийг дэмжих



Нийгмийн Хөгжлийн Төвийн судлаач Р. Гантөмөр орон нутгийн иргэдтэй зөвлөлдөж байна. Архангай аймаг, 1996 он

тусгай төсөл, хөтөлбөрүүдийг санаачлан хэрэгжүүлсэн юм. Тухайлбал, олон хүүхэдтэй өрх толгойлсон 250 эмэгтэйчүүдэд орлогоо нэмэгдүүлэх үйл ажиллагаа эрхлэх, хүүхдийнх нь сургууль, цэцэрлэгт явах боломжийг дэмжсэн жижиг зээлийн төслүүдийг ЯБҮХ-ийн орон нутагт хэрэгжих механизмыг ашиглан Өмнөговь, Сүхбаатар, Дорнод, Дархан-Уул аймагт хэрэгжүүлэв. Мөн Баян-Өлгий, Хөвсгөл, Баянхонгор, Дорнод аймгуудад нийт 450 ядуу малчин өрхийг малжуулах төслийг, тухайн өрхүүд хүүхдээ сургуульд тасралтгүй хамруулах нөхцөлтэйгээр хэрэгжүүлэв. ХИС эдгээр төслүүдийг амжилттай хэрэгжүүлснээр төслийн хэрэгцээг тодорхойлох, боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоо хамгийн чухал гэдгийг амьдрал дээр нотолсон юм. Эдгээр төслүүд нь хөдөөгийн ядуурлыг бууруулахад тодорхой зорилтот бүлгүүдэд чиглэгдсэн төслүүд өндөр ач холбогдолтой, хэрэгцээтэй болохыг бодитой харуулж чадсанаас гадна, ЯБҮХ-ийг орон нутагт хэрэгжүүлж байсан хүмүүст “малжуулах төслийг” хэрхэн зохион байгуулж хэрэгжүүлэх талаар зохих мэдлэг, туршлагыг олгосон юм. Хөдөөгийн ядуу иргэдийн дунд малжуулах төсөл амжилттай хэрэгжих боломжтой гэдгийг харуулсан ХИС-гийн энэ туршлага дээр суурилсан ЯБҮХ-өөс 2000 онд 5 аймгийн 33 суманд хөдөөгийн ядуу малчдыг дэмжсэн малжуулах төсөлд 1,3 сая долларын санхүүжилтийг хуваарилсан билээ.

Нийгмийн ажлын хөгжилд үзүүлсэн дэмжлэг (1994–2002)

ХИС Монголд үйл ажиллагаагаа эхэлсэн цагаасаа Хүүхдийн Төлөө Үндэсний Төв (ХТҮТ)–тэй хамтран ажиллаж ирсэн билээ. ХТҮТ нь Монгол Улсад хүүхдийн эрхийг хэрэгжүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэх боломжтой байсан нь ХИС–гийн сонирхлыг татсан юм. Улс орны нөхцөл байдал, хамтран зүтгэгчдийхээ хүүхдийн сайн сайхны төлөөх хичээл зүтгэлийг илүү сайн ойлгохын хэрээр ХИС ба ХТҮТ–ийн хамтын ажиллагаа илүү урт хугацааны, стратегийн шинж чанартай болж ирсэн юм.

ХИС–гийн бүсийн, нийгмийн хөгжлийн зөвлөхийн 1994 онд хийсэн нөхцөл байдлын судалгаанд үндэслэн ХТҮТ–ийн хүүхдийн ажилтнуудыг олон нийтийн хөгжлийн чиглэлээр ажиллах анхны ажилтнууд болгон сургах нөр их ажлыг ХИС 1994 онд эхлүүлэв. Төрийн бус байгууллагууд цөөн, нийгмийн ажлын мэргэжил огт хөгжөөгүй байсан тэр үед шилжилтийн үеийн нийгмийн асуудлууд, түүний дотор ядуурал, хараа хяналтгүй болон хөдөлмөр эрхлэгч хүүхдийн асуудал зэргийг шийдвэрлэхэд гол үүрэг гүйцэтгэх боломжтой хүмүүс нь хүүхдийн ажилтнууд байлаа.

Шилжилтийн тэр үед шинээр гарч ирж байсан нийгмийн олон асуудалтай тулж ажиллахад Монголын хүүхдийн ажилтнуудад шинэ арга барил, ур чадвар ихээхэн дутагдаж байв. Иймээс ХИС–гаас “Хүүхэд төвтэй хөгжил”



“Хүүхэд төвтэй хөгжил” орон нутгийн сургалт. Ховд аймаг, 1995 он

сургалтын хөтөлбөрийг боловсруулж НҮБ–ын Хүүхдийн Эрхийн Конвенцийг таниулах, орон нутгийн хөгжлийн талаарх оролцооны аргад суурилсан сургалтуудыг орон даяар явуулж эхлэв. ХИС тус сургалтуудын хөтөлбөрийг нийгмийн хөгжлийн асуудлууд болон ХТҮТ ба орон нутгийн хүүхдийн төлөө төвүүдтэй хамтран хэрэгжүүлсэн төслүүдийнхээ туршлага дээр үндэслэн баяжуулан боловсруулж, 1994–1996 онд хүүхдийн болон нийгмийн бодлогын нийт 500 ажилтныг сургаж, мөн сургуулийн арга зүйч нарыг тус сургалтад давхар хамруулсан нь шилжилтийн үед тэдний өмнө тулгарч байсан шинэ үүргээ гүйцэтгэхэд нь чухал дэмжлэг болсон билээ.

Хүүхэдтэй ажиллах ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх сургалтын нэн тэргүүний хэрэгцээг хангахын зэрэгцээ ХИС хүүхдийн өмнө тулгарч байгаа нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх мэргэжлийн боловсон хүчнийг системтэй бэлтгэх байнгын механизмыг бий болгох хэрэгцээ, шаардлагыг тодорхой мэдэрсэний үндсэн дээр нийгмийн ажлын үйлчилгээний хэрэгцээ, нийгмийн ажилтан бэлтгэх сургалтын хувилбаруудыг судлах ажлыг Нийгмийн Хөгжлийн Төв, орон нутгийн судлаачдаар хийж гүйцэтгүүлсэн юм. Энэ судалгааны дүнг 1996–1997 онд зохион байгуулсан орон нутгийн болон олон улсын эрдэмтэн, судлаач, практик ажилтнуудын зөвлөлдөх семинаруудаар нягтлан хэлэлцүүлсэнээр Монгол Улсад хөгжүүлэх нийгмийн ажил нь “хөгжилд чиглэсэн” хандлагатай байх ёстой гэсэн дүгнэлт гарсан юм. ХИС–гийн арга зүйн болон санхүүгийн тусламжтайгаар УБДС (одоогийн Боловсролын Их Сургууль) дээр Нийгмийн Ажлын Сургалт Судалгааны Арга Зүйн Төвийг 1997 онд байгуулсан нь нийгмийн ажлын анхны тэнхим болон өргөжиж, мэргэжлийн нийгмийн ажилтнуудыг бэлтгэх болсон билээ.

Монгол Улсад нийгмийн ажлыг хөгжүүлэх талаар ХИС–гийн баримталсан стратегид орон нутгийн чадавхийг бий болгон хөгжүүлэх, үндэсний сургагч багш нар, практик ажилтнуудыг бэлтгэх, Монголын нөхцөл байдалд тохирсон нийгмийн ажлын төлөө

байдлыг тодорхойлох, боловсрол, нийгмийн халамж, хүүхэд хамгааллын салбарт нийгмийн үйлчилгээний загваруудыг турших, хөгжүүлэх боломжийг нь бүрдүүлэх асуудлууд багтаж байсан юм. 1997 онд ХИС, ХТҮТ–тэй хамтран УБДС дээр нийгмийн ажлын бакалаврын хөтөлбөрийн эхлэлийг тавихын зэрэгцээ Монголын Хүүхдийн Эрхийн Төв (МХЭТ)– тэй хамтран хот болон хөдөө орон нутагт сургууль завсардалтаас урьдчилан сэргийлэх, сургуулийн нийгмийн ажлын туршилтын төслүүдийг хэрэгжүүлж эхэлсэн юм.

БСШУЯ–ны Бага, Дунд Боловсролын Бодлого Зохицуулалтын Газрын дэргэд ХИС, МХЭТ–ийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан Сургуулийн Нийгмийн Ажлын Нэгж нь сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээний загваруудыг бий болгох туршилтын төслүүдийг дэмжих, сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээний талаар олон нийтийн ойлголт, хандлагыг бий болгох ажлыг эхлүүлсэн билээ. 2001 онд анхны нийгмийн ажилтнууд төгсөн гарах тэр үед орон даяар сургууль бүрт сургуулийн нийгмийн ажилтны орон тоог бий болгох Засгийн газрын шийдвэр гарсан байлаа. Мөн тэр үед ХИС–гийн дэмжлэгтэйгээр УБДС–ийн Дорнод аймаг дахь Багшийн коллеж, МУИС–ийн Ховд аймаг дахь салбарт Нийгмийн Ажлын Сургалт Судалгааны Төвүүд байгуулагдаж, УБДС–ийн нийгмийн ажилтны ангийн анхны төгсөгчид тэдгээр төвүүдэд уригдан ажиллаж эхэлсэн юм. Одоо эдгээр төвүүд нь хөдөө орон нутаг дахь анхны нийгмийн ажлын тэнхим болон өргөжиж, орон нутагт нийгмийн ажлын мэдлэг, чадварыг бий болгох асуудлыг шийдэж байна.

Хүүхдийн ажилтнуудыг сургах богино хугацааны сургалтаар эхэлсэн ХИС–гийн энэхүү хүчин чармайлт нь мэргэжлийн нийгмийн ажилтан бэлтгэх дээд боловсролын сургалт болон өргөжсөн нь үнэхээр бахархалтай үйлс байлаа. Нийгмийн ажлын шинэ мэргэжил болон нийгмийн ажилтнуудын үүрэг олон нийтэд нэгэнтээ танигдаж, боловсрол, хүүхэд хамгаалал, халамж болон нийгмийн үйлчилгээний бусад салбар дахь нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээ хуульчлагдан батлагдаад байна. 2009 оны байдлаар 16 их, дээд сургуулиудад нийгмийн ажлын бакалавр, магистр, докторын зэрэгтэй мэргэжилтнүүдийг

бэлтгэж байгаа бөгөөд өнгөрсөн хугацаанд мэргэжлийн нийт 1200 нийгмийн ажилтан бэлтгэгдэж Монгол орны өнцөг булан бүрт тусламж дэмжлэг хэрэгтэй эмзэг бүлгийн хүмүүс, бүлэг, олон нийттэй ажиллаж байна.

ХИС–гийн нийгмийн ажлын төслийн (1997–2002) бие даасан үнэлгээнд (2002 онд) нийгмийн ажлын шинэ мэргэжлийг Монгол Улсад хөгжүүлэх ХИС болон түүний хамтрагч байгууллагуудын хүчин чармайлт онцгой үр дүнтэй болсныг тэмдэглээд бусад улс оронд энэ туршлагыг түгээн дэлгэрүүлэхийг зөвлөмж болгосон байдаг. Ийм амжилтанд хүрэхэд ХИС–гийн хамтран зүтгэгчид болох ХТҮТ, аймаг, хотын хүүхдийн төлөө төвүүд, НХТ, УБДС, Нийгмийн ажлын сургалт судалгааны арга зүйн төв болон түүний хөтөлбөрийн зөвлөл, БСШУЯ, НХХЯ, аймгийн боловсрол, соёлын төвүүд, Улаанбаатар хотын боловсролын газар, Хотын захиргаа, Монголын Хүүхдийн Эрхийн Төв, Монголын Сургуулийн Нийгмийн Ажилтны Нийгэмлэг, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв, түүний орон нутгийн салбарууд, Боловсролын Их Сургуулийн Дорнод аймаг дахь Багшийн Коллеж, МУИС–ийн Ховд аймаг дахь салбар болон сургуулийн нийгмийн ажлын туршилтын төслүүдийг Улаанбаатар, Дорнод, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв аймгуудад амжилттай хэрэгжүүлсэн сургуулийн нийгмийн ажилтнууд чухал хувь нэмэр оруулсан билээ. Энэ бүх үйл явцыг амжилттай болгоход ХИС–ийн захирлууд болон хөтөлбөрийн ажилтнуудын идэвхи санаачлага, хүчин чармайлт мөн чухал үүрэг гүйцэтгэсэн. Өнөөдөр энэ бүхнийг эргэн харахад нийгмийн ажлын орон нутгийн чадавхи нэгэнт бий болж хөгжлийн тодорхой үе шатанд гарсан бөгөөд цаашид эмзэг бүлгийн хүмүүсийн өмнө тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэх болно гэдэгт ХИС итгэл төгс байгаа билээ.



"... ХИС-тай хамтран ажилласан нь бид бүхний чадварыг ихээхэн дээшлүүлсэн билээ. ХИС бидний оролцоо, санаачлагыг ямагт дэмжиж, бидний бага багаар олсон амжилтыг хөхиүлэн ажилладаг байсан юм. ХИС-гийн тусламжтайгаар бид олон улсын зөвлөлтэй бүтэн жилийн хугацаанд хамтран ажилласан төдийгүй АНУ, Англи, Орос, Энэтхэг, Япон, Гонконг зэрэг улс орнуудын нийгмийн ажлын боловсролын хөгжилтэй биечлэн танилцах, суралцах боломжийг ХИС бидэнд олгосон юм. Нийгмийн ажлыг хөгжүүлсэн гадны туршлагаас ийнхүү суралцсан нь үнэхээр бидний "нүдийг нээж", нийгмийн ажлыг өөрийн орны онцлогт тохируулан хөгжүүлэх ёстой гэдгийг бүрэн ойлгоход ихээхэн тус болсон юм. Нийгмийн ажлын сургалт зохион байгуулахын хажуугаар ХИС-гийн олон нийтийн төслүүд дээр ажиллах боломжтой байсан нь бидний хувьд практик туршлага хуримтлуулах чухал ач холбогдолтой байснаас гадна нийгмийн ажлын үйлчилгээний талаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхэд түлхэц болсон нь гарцаагүй.

Манай тэнхим 1997 онд анх байгуулагдсанаас хойш өнөөг хүртэл нийгмийн ажлын бакалаврын зэрэгтэй 190, нийгмийн ажлын магистр цолтой 34 мэргэжлийн нийгмийн ажилтан бэлтгэж гаргаснаас гадна, 1500 орчим практик ажилтнуудыг богино хугацааны сургалтуудаар бэлтгэлээ. Манай төгсөгчид боловсрол, хүүхдийн хамгаалал, халамжийн салбарт төрийн болон төрийн бус байгууллагуудад ажиллаж, нийгмийн ажлын мэргэжлийн нийгэмлэгүүдийг толгойлон ажиллаж байна. Олон хүн их, дээд сургууль, коллежуудад нийгмийн ажлын багшаар ажиллаж байна. Манай нийгмийн ажлын тэнхим эдүгээ Монголдоо төдийгүй хилийн чанадад танигдаж, Нийгмийн ажлын сургуулиудын олон улсын холбооны гишүүн болсон юм.

Монгол Улсад нийгмийн ажлын мэргэжлийг анх үүсгэн, өнөөдрийн төвшинд хүртэл хөгжүүлэхэд ХИС-гийн гүйцэтгэсэн үүргийг үнэлж баршгүй. Хамтын оролцоон дээр тулгуурлан ажилладаг ХИС-гийн арга барилаас суралцаж, сургалт болон нийгмийн үйлчилгээний бүхий л чиглэлийн үйл ажиллагаандаа оролцоог эрхэмлэн ажиллаж чаддаг болсондоо бид баяртай байдаг билээ."

МУБИС, Нийгмийн ажлын тэнхимийн эрхлэгч Т.Цэндсүрэн,

Нийгмийн ажлын тэнхимийн ахлах багш Х. Өлзийтунгалаг



Сургуулийн анхны нийгмийн ажилтнууд (дунд нь ХИС-гийн хөтөлбөрийн ажилтан А.Батхишиг) Улаанбаатар, 1997 он

Хараа хяналтгүй болон хөдөлмөр эрхлэгч хүүхдийн хамгаалал ба нөхөн сэргээлт (1994 оноос)

Шилжилтийн эхэн үед нийгмийн хамгааллын сүлжээ задран унаснаас улбаалсан хүндрэлүүд гэр бүлийн амьдралд хүндээр тусч олон гэр бүл хямралд орсон, гэр бүл салалт эрс ихэссэн цаг үед ХИС Монголд ажиллаж эхэлсэн билээ. Энэ хямралын улмаас олон хүүхэд гэрээсээ дайжиж, гудамжинд хоног төөрүүлэх болж, “гудамжны хүүхэд” гэдэг нэр томъёо бий болов. Олноороо бүлэглэн амьдрах энэ хүүхдүүд Монголын тэсгим хүйтэн өвлийг хотын төвлөрсөн халаалтын системийн траншейд хоргодон өнгөрөөдөг байв. Эдгээр хараа хяналтгүй хүүхдүүд Монголын эмзэг бүлгийн хүүхдүүдийн нэгээхэн хэсэг нь л байсан юм. ХИС-гийн тооцоолсноор, эмзэг бүлгийн нийт хүүхдийн тоо 1995 онд 30 мянга байсан бол 1996 онд НҮБ-ын Хүүхдийн Сангийн тооцоолсноор 60 мянгад хүрсэн юм. Тэднээс 1500 орчим хүүхэд гудамжинд байнга амьдарч, 3500 орчим хүүхэд гудамжинд олон цагаар ажиллаж олсон багахан мөнгөө өгөхөөр гэр орондоо алдаг оног очдог байв. Мөнгө олохын тулд олон хүүхэд орон сууцны хог хаягдлаас шил, лааз, яс түүх, вагонд явж дуу дуулах, гуйлга гуйх, халаас суйлах, биеэ үнэлэх зэрэг янз бүрийн, заримдаа хууль бус үйл ажиллагаанд ч оролцох нь элбэг байлаа.⁶ Ийм нөхцөлд тэдгээр хүүхдүүд рүү чиглэсэн, үр дүнтэй, урьдчилан сэргийлэх болон нөхөн сэргээх арга хэмжээ авахгүй бол гудамжинд амьдарч байгаа хараа хяналтгүй хүүхдийн тоо богино хугацаанд эрс нэмэгдэх эрсдэл өндөр байлаа. Гудамжинд хараа хяналтгүй хүүхэд амьдарч эхэлсэн 1991–1993 оны хооронд зөвхөн Улаанбаатар хотод байсан энэ үзэгдэл 1995 он гэхэд Улаанбаатар хоттой төмөр замаар холбогдсон бусад томоохон хотуудад мөн адил тархах болсон юм. ХТҮТ-ийн болон цагдаагийн байгууллагын мэдээлснээр малчин өрхийн хүүхдүүд ч Улаанбаатарын гудамжинд амьдарч эхэлсэн байв.⁷ Шилжилтийн үед гарч ирсэн энэ асуудлыг урт хугацаанд шийдвэрлэх гол арга зам нь эдийн засгийн өсөлтийг ханган, хүүхдүүдийн эцэг эхийг ажилтай байлгах, нийгмийн хамгааллын сүлжээг оновчтой

хөгжүүлэх явдал байсан боловч ойрын хугацааны, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх үйл ажиллагаа яаралтай шаардагдаж байлаа. Ийм нөхцөлд, 1996 оны 12-р сард Монгол Улсын Шадар сайд олон улсын байгууллагуудад хандан гудамжны хүүхдийн асуудлыг шийдвэрлэхэд туслахыг хүсч уриалга гаргасны хариуд ХИС хараа хяналтгүй хүүхдүүдэд зориулсан төвүүдийг анх байгуулсан билээ. ХИС нь асуудлын хоёр тал буюу урьдчилан сэргийлэх ба нөхөн сэргээх үйл ажиллагааны аль алинд нь анхаарлаа хандуулан ажилласан юм. Гэр бүлээ тэжээхийн тулд олон хүүхэд сургуулиа орхин, янз бүрийн эдийн засгийн үйл ажиллагаанд, заримдаа хүнд, хортой хөдөлмөрт татагдан орж байсан тэр үед буюу 1996 оноос ХИС “Хөдөлмөр эрхлэгч хүүхэд” хөтөлбөр хэрэгжүүлсэн эхэлсэн юм. Хүүхдүүд, ялангуяа хөвгүүд зах дээр хүнд ачаа зөөх, гутал цэвэрлэх, машин угаах, гудамжинд жижиг худалдаа хийх зэргээр мөнгө олохын тулд олон цагаар ажиллаж байв. Энэ чиглэлээр ХИС-гийн хэрэгжүүлсэн олон тооны жижиг төслүүд нь хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийг хүнд, хортой ажлаас хөндийрүүлэх, хөдөлмөрийн багаж зэвсэг олгож тэдний хөдөлмөрийг хөнгөвчлөх, сурах болон хөгжих боломжийг нь нэмэгдүүлэх, хүүхдүүдэд ажил, сургуулиа хослуулах боломжийг олгоход чиглэгдэж байсан юм. Насанд хүрэгчид болон “үе тэнгийн сургагч” нараар дамжуулан хэрэгжүүлсэн ХИС-гийн амьдрах ухааны сургалтууд нь өндөр эрсдэлтэй орчинд ажиллаж, амьдарч байгаа



Зах дээр хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд
Улаанбаатар, 1996 он

⁶ ХИС, “Хараа хяналтгүй хүүхдийн нөхөн сэргээлт” төслийн баримт бичиг, 1996/97

⁷ Дээрхтэй ижил

хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд болон хараа хяналтгүй хүүхдүүдэд бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх мэдлэг, мэдээллийг олгоход онцгойлон анхаарч байсан юм. Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдэд мэргэжлийн чиг баримжаа олгох, ингэснээр тэднийг илүү аюулгүй орчинд, илүү бүтээмжтэй ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд ХИС ихээхэн хүчин чармайлт тависан билээ. ХИС мэргэжлийн боловсролын сургуулиуд болон фермерүүдийн нийгэмлэгтэй хамтран ажилласны үр дүнд хөдөлмөр эрхэлж байсан өсвөр насны нийт 850 хүүхдийг мэргэжлийн үр чадвар олгох сургалтанд хамруулж, төгссөнийх нь дараа төрийн болон хувийн хэвшлийн ажлын байрыг зуучлан олгож өгсөн юм.

Тухайн үед нийгэмд ядуурал, хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн их байснаас олон хүүхэд сургуулиас завсардаж, гэр бүлээ тэжээхийн тулд хөдөлмөр эрхлэх болсон байв. ХИС-гийн “Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд” төсөл тэдгээр хүүхдэд төрөл бүрийн дэмжлэг үзүүлж үзэл бодлоо илэрхийлэх, дуу хоолойгоо нэгтгэх, хамтран ажиллах үр чадвар олоход нь тусалдаг байсан. Энэ төсөл олон хүүхдэд итгэл найдварыг өгсөн. Д. Алтансүх бол тэдний нэг юм. Найман настайгаасаа зах дээр ажил хийж байсан тэр хүү сургуульд огт суралцаж байгаагүй. Манай төсөлд хамрагдсанаар Алтансүх албан бус сургалтыг дүүргэж, видео төсөлд хамрагдан, мөн өөрөө бие даан англи хэл сурсан юм. Хожим нь тэр хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн үүсгэн байгуулсан “Мандах” холбооны тэргүүн болсон. Алтансүх одоо оюутан, Швед улсад суралцахын хажуугаар Шведийн Хүүхдийг Ивээх Сангаас хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдэд туслах хөрөнгө босгох үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог.

Х.Мөнхзул, ХИС-гийн “Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд” төслийн нийгмийн ажилтан (2001–2003)

Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн үүсгэн санаачилсан “Мандах” холбоо (1999) хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдэд хүрч ажиллах, тэдэнд боловсролын болон хөгжлийн шинэ боломжуудыг нээж өгөх, хөдөлмөр эрхэлж байгаа болон хараа, хяналтгүй хүүхдүүдийг амьдрах ухааны арга барилд сургах талаар ХИС-гийн гол хамтрагч байлаа. Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдэд оруулсан ХИС-гийн хөрөнгө оруулалт нь тэдгээр хүүхдүүдэд орлогоо нэмэгдүүлэх, гудамжны амьдралаас хөндийрч, орон гэртээ амьдрахад нь ихээхэн үүрэг гүйцэтгэсэн билээ. ХИС 1996 онд Улаанбаатар хотын захын дүүргүүдэд хараа хяналтгүй хүүхдийн таван төвийг “Хот айл” нэртэйгээр, 125 хүүхэдтэйгээр анх нээсэн нь ХИС-гийн хараа, хяналтгүй хүүхдийг нөхөн сэргээх их ажлын эхлэл болсон юм.

...Тэр үед нийгэмд хараа, хяналтгүй хүүхдүүдийг ялгаварлан гадуурхах үзэл хүчтэй байсан. Тиймээс анх хараа хяналтгүй хүүхдүүдтэй уулзаж харилцаа тогтооход хэцүү байсныг санаж байна. Бид хүүхдүүдтэй байгаа газар нь орон сууцны орц, траншейд очиж уулздаг байсан. Хүүхдүүд биднийг үнэн сэтгэлээсээ хандаж байгаа эсэхийг шалгахын тулд траншейнаасаа хорхой шавьж шидэх, хувцас халтартуулах зэрэг үйлдэл хийдэг байсан хэдий ч бид сайн сэтгэлийн үүднээс ирсэн гэдгээ харуулж, тэдэнд итгэл төрүүлэхийг хичээдэг байсан.

Ж. Лхагвасүрэн, ХИС-гийн, Хараа хяналтгүй хүүхдийн төвийн менежер (1995–2003)

ХИС хараа хяналтгүй хүүхдүүдэд амьдрах байраар хангахаас гадна тэдэнд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж, халуун усанд оруулж, хувцаслаж, вакцинжуулж, сурах боломж олгодог байсан. Мөн хараа хяналтгүй хүүхэдтэй хэрхэн ажиллах талаар мэдлэг олгох арга зүйн сургалтуудыг эцэг эх, багш нар, орон нутгийн удирдлага, төрийн бус байгууллагын идэвхтэн, эмнэлгийн ажилтнуудын дунд явуулж байлаа. 1997–1998 онд орон нутгийн

засаг захиргаанаас гаргасан хүсэлтийн дагуу ХИС Дорнод, Сэлэнгэ, Дархан-Уул аймагт хараа хяналтгүй хүүхдийн таван төвийг нэмж байгуулсан юм. ХИС-гийн эдгээр төвүүд болон өдрийн үйлчилгээний төвүүд, явуулын сургагч нарын үйлчилгээ нь хараа хяналтгүй хүүхдэд үзүүлэх үйлчилгээний загварыг бий болгосон бөгөөд Монголд үйл ажиллагаа шинээр эхэлж байсан олон улсын төрийн бус байгууллагууд энэ загварыг авч ашигласан юм.

Нийгмийн хамгааллын үндэсний хэмжээний үр дүнтэй сүлжээ байхгүй тохиолдолд

ХИС-гаас авч хэрэгжүүлсэн эдгээр арга хэмжээ нь хараа хяналтгүй хүүхдийн асуудлыг бүрмөсөн шийдвэрлэхгүй ч тэдний нэн тэргүүний хэрэгцээг хангах, тэдэнтэй ажиллах боловсон хүчнийг бэлдэх, мөн шилжилтийн үеийн нийгмийн үр дагаврын нэг болсон хараа хяналтгүй хүүхдүүдэд үзүүлэх олон улсын хэмжээнд туршигдсан өртөг багатай үйлчилгээний загварыг бий болгон Засгийн газарт туслах зорилтыг агуулж байсан юм.⁸

ХИС надад шинэ амьдрал бэлэглэсэн

"... Би охин хүү хоёртой. Гэрлэж байгаагүй учраас хүүхдүүдээ ганцаараа өсгөж байсан. Бид ахындаа хамт амьдрахаар нүүж очсон цагаас асуудал үүсч, бэр эгчтэйгээ байнга маргалдаж хэрэлддэг байсны улмаас би ихэнх цагаа гэрээс гадуур өнгөрөөдөг болж, хүүхдүүдээ анхаарахаа больсон. Гэрийн үйлчлэгч болон бусад ажил хийж, шөнөд нь янз бүрийн газар хоног төөрүүлдэг болсон.

Миний хүү ахын гэрээс зугатаж гудамжинд амьдардаг болсныг сонссон тэр үе миний хувьд хамгийн хэцүү үе байсан. Хүүгээ хаана байгааг ч мэдэхгүй, бас дээр нь би гэртээ буцаж очиж болохгүй байсан. Миний охин ахын гэр бүлтэй хамт амьдарч байсан учраас би түүнийг бүх үнэнийг мэдчихвий гэхээс айдаг байсан.

Би энэ замбараагүй байдлаасаа гарах, хүүгээ олох хэрэгтэй байлаа. Эхлээд өөрийнхөө асуудлыг шийдвэрлэж, дараа нь хүүгээ олох хэрэгтэй байсан. Үүнийг би ХИС-гийн зөвлөх үйлчилгээнд хамрагдаж байж л ойлгосон. Манай ах намайг "Гудамжинд амьдрахаа боль" гээд байр хөлсөлж өгсөн. Тэгээд би 17 настай болсон хүүгээ ХИС-гийн "Хүүхэд" төвөөр дамжуулан олсон. Хүүд маань ХИС тусалж байгаа. Хүү маань барилгын мэргэжлээр суралцаж байгаа, удахгүй ажил хийж мөнгө олдог болно. Бидний амьдрал нааштайгаар эргэж л байна. Миний хүү гудамжинд олон жил амьдарсан ч сайн хүү. Ямар ч мөнгө олсон эхлээд надад, бас дүүдээ л зарцуулахыг боддог. Тэр ачаа үүрэх, ногоо ялгаж цэвэрлэх, вагоноос нүүрс буулгах гээд олон янзын ажлыг 12 настайгаасаа л эхлэн хийдэг байсан. Одоо ХИС-гийн тусламжтайгаар мэргэжилтэй болж байгаа учир илүү мөнгө олдог болно. Хүү маань энэ төвийн зөвлөх үйлчилгээнд хамрагдсан, тэрэнд их тус болсон гэж би боддог.

Би хүүхэд хүмүүжүүлэх аргын талаар нэг их юм мэддэггүй байсан. ХИС-гийн төвөөс миний сурсан хамгийн чухал зүйл бол хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга. Уг нь их амархан юм байсан байна лээ. Хүүхдийнхээ ямар зан үйлийг нь дэмжиж байгаагаа л илэрхийлэх хэрэгтэй юм билээ. Хүүхэд чинь гэрийн даалгавраа хийж байвал очоод үнсэхэд л болно. Хүүхэд чинь ямар нэг зүйлийг буруу хийж байвал аятайхан хэл. Хүүхэд чинь юуг сайн хийж, юуг засах хэрэгтэй байгааг нь ойлгуул. Хашгирч, загнаж болохгүй. Зарим хүмүүс хүүхэд нь буруу юм хийвэл хашгирч эхэлдэг, тэгээд тэдний харьцаа эвдэрч, хүүхэд нь үгэнд нь орохоо болиход эцэг эх нь бүр илүү загнаж хашгирна. Муу байсан харьцаа нь бүр дордоно. Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлнэ гэдэг нь үнэхээр сайн арга юм байна. Би хийж үзсэн, сайн болж байгаа."

О., 41 настай, өрх толгойлсон эмэгтэй⁹

⁸ ХИС, "Хараа хяналтгүй хүүхдийн нөхөн сэргээлт" төслийн баримт бичиг, 1996/97

⁹ Мадхури Дассын хийсэн ярилцлага, 2008 оны 11 сар



... Энэ миний хамгийн анхны ажил. Би энэ ажлыг хийгээд одоо 2 жил болж байна. Би ажилдаа дуртай. Хүүхдүүд өөрчлөгдөхийг харах нь миний ажлын хамгийн сайхан зүйл.

Анх ирж байгаа хүүхдүүдтэй ажиллахад их хэцүү. Янз бүрийн зан авир гаргадаг, хэнд ч итгэдэггүй. Гудамжны амьдрал нь тэднийг ийм болгодог. Харин бид тэвчээртэй, уйгагүй ажиллах шаардлагатай. Ер нь тэвчээртэй байх юм бол үр дүнд хүрдэг. Хүүхэд бүртэй байнга нүүр тулж уулзаж ярилцах нь үр дүнтэй байдаг гэж боддог. Би тэднийг нэрээр нь дууддаг. Хүүхдүүдийн итгэлийг олох нь хамгаас чухал. Хүүхдүүд надад нууцаа ярьдаг. Тэдэнд ямар ч асуудал тохиолдсон бид хамтдаа шийдвэрлэнэ гэж би тэдэнд хэлдэг. Бид тэгж ч хийдэг. Хүүхэд гудамжинд байгаа шиг ганцаардахгүй, мөн өөрийнхөө амьдралыг өөрчилж чадна гэдгээ мэдрэх нь хүүхдийн хувьд хамгаас сайхан зүйл.

Би хүүхдэд бүх талаар туслахыг боддог. Тэгээд хүүхэд надад итгэж эхэлсэн цагт би бага багаар ахиулан ажиллаж, тэр хүүхэд өөрөө бие даан юм хийх өөртөө итгэх итгэлийг нь нэмэгдүүлэхийг хичээдэг. Дараа нь тэр хүүхэд гэр бүлтэйгээ эргэж харьцаа тогтоох, сургуульдаа буцаж орох гэх мэт асуудлаар бидэнтэй хамтарч ажиллах сонирхолтой эсэхийг нь мэдэх хэрэгтэй. Заримдаа хүүхэд ингэхийг хүсэхгүй их уддаг. Ийм үед тэднийг байнга сайн сонсож ойлгох, ойлгуулах хэрэгтэй байдаг. Заримдаа хүүхдүүд бидэнд гэр бүлийнхнийхээ тухай мэдээлэл өгч, хурдхан олж өгөөч гэж хүсдэг. Зарим хүүхэд үнэхээр хэцүү байдаг. Тэд үгээсээ буцах, худал ярих, гэрийнхээ хаягийг худал хэлэх, бидэнтэй хамтарч ажиллахыг хүсэхгүй байх явдал ч гардаг.

Гэхдээ, энд ирсэн бүх хүүхдэд өөрчлөлт гардаг. Халуун хоол унд идэх, усанд орох, төвд ирсэн бусад хүүхэдтэй цагийг хамт өнгөрөөх, мөн хэн нэгний анхаарал халамжийг мэдрэх зэрэг нь бүгд тэдэнд сайнаар нөлөөлж, хүүхдүүд бага ч гэсэн жаргалтай болдог.

Г. Сүнжидмаа, ХИС-гийн "Хүүхэд" төв (Хараа хяналтгүй хүүхдэд зориулсан өдрийн үйлчилгээний төв) –ийн нийгмийн ажилтан¹⁰

¹⁰ Мадхури Дассын хийсэн ярилцлага, 2008 оны 11 сар

Хүүхдийн үүсгэл санаачлага, сонирхол дээр тулгуурлан ХИС–гаас хэрэгжүүлсэн “Зуны зуслан”, “Амьдрах ухааны сургалт”, “Видео”, “Нийгэмшүүлэх цирк”, “Хүүхэд ба дуран”, “Радио” зэрэг төслүүд нь хүүхдүүдийн нийгмийн болон харилцааны ур чадвар, шинэлэг, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, өөртөө итгэлтэй болох, үзэл бодлоо илэрхийлж сурахад нь онцгой ач холбогдолтой сургалтууд байлаа.

“...ХИС болон надад итгэдэг хүмүүсийн дэмжлэгтэйгээр Монголын хүүхдүүдтэй ажиллах боломж олдсонд би их баярладаг. Эхний удаад “Нийгэмшүүлэх цирк” төслийн ажлаар Улаанбаатарт очиж ажиллаж байсан бол дараа нь энэ нь миний өөрийн сонголт болсон.

Өнгөрсөн есөн жилийн хугацаанд хамтран ажилласан хүүхдүүд болон багш нар бол миний хувьд их дотно хүмүүс. Би Монголын хүүхдүүдтэй цаашид ч ажиллах болно. Үүний тулд би өөрийн хувийн амьдралдаа зарим зохицуулалтыг хийх шаардлагатай байгаа.”

Сэсил Труфолт, “Нийгэмшүүлэх цирк” төслийн сургагч багш (2000–2005),

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн сэргээх төвийн сайн дурын ажилтан (2006–2007)

ХИС хараа хяналтгүй хүүхдүүдэд үзүүлэх үйлчилгээгээ өргөжүүлэн сайжруулахын зэрэгцээ хараа хяналтгүй болон эмзэг бүлгийн бусад хүүхдүүдтэй нүүр тулан ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагуудын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэхэд байнгын хөрөнгө оруулалт хийсээр ирсэн юм. Сэлэнгэ, Дархан–Уул аймаг дахь төвүүдээ орон нутгийн захиргаа болон төрийн бус байгууллагад шилжүүлэн өгсөн (2001–2002) хэдий ч арга зүйн хувьд үргэлжлүүлэн дэмжсээр байгаа билээ. Түүнчлэн ХИС–гаас хараа хяналтгүй хүүхдүүдийн гэр бүлийг олж тогтоох, харилцаа холбоо тогтоох, гэр бүлийн нөхцөл байдлыг судлах, хүүхэд гэр бүлдээ эргэн нэгдэх боломж, аргыг хайж олох ажлуудаа эрчимжүүлж, хүүхэд болон гэр бүлд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээг нэвтрүүлсэн юм. Энэ олон жилийн ажлын үр дүнд хараа хяналтгүй олон хүүхэд гэр бүлээ олж, холбоо тогтоон, зарим нь гэртээ буцаж очсон юм. Зөвхөн 2003–2008 оны хооронд нийт 180 хүүхэд өөрийн гэр бүлтэйгээ эргэн нэгдсэн билээ.


Мөн түүнчлэн ХИС гэртээ амьдрах боломжгүй, төвд амьдарч байсан хүүхдүүдэд гэр бүлийн нөхцөлд амьдрах боломжийг хангах зорилгоор гэр бүлд суурилсан халамжийн хувилбарт үйлчилгээг нэвтрүүлж, “хуурай аав, ээж” болон хамаатан садных нь асран хамгаалагчийн халамжинд амьдрах боломжийг нийт 18 хүүхдэд олгосон юм.



Хүүхдүүд Гачуурт дахь зуны зуслан дээр (дунд нь “Нийгэмшүүлэх цирк” төслийн сургагч багш Сэсил Труфолт) 2003 он



2000 оноос эхлэн амжилттай хэрэгжиж байгаа “Нийгэмшүүлэх цирк” төсөл олон хүүхдэд авьяасаа нээж хөгжихөд нь тусалсан билээ. Хүүхдүүд циркийн үзүүлбэр бэлтгэж байна. Гачуурт, 2000 он



"Хот айл" төвийн хүүхдүүд, Улаанбаатар, 1996 он

2002 оноос эхлэн хараа хяналтгүй хүүхдэд төвөөр дамжуулан үйлчилгээ үзүүлдэг олон улсын болон орон нутгийн байгууллагуудын тоо нэлээд нэмэгдсэн нөхцөл байдлыг харгалзан ХИС хараа хяналтгүй хүүхдэд үзүүлэх шууд үйлчилгээнийхээ хэмжээг аажмаар багасгав. Мөн олон улсын болон Монгол дахь ажлын туршлагадаа тулгуурлан хүүхдэд үзүүлэх асрамж үйлчилгээний стандартыг анхлан боловсруулж (2006) хүүхдэд үзүүлэх асрамж, халамжийн үйлчилгээнд тавигдах шаардлага, асрамж халамжийн байгууллагад амьдарч байгаа хүүхэдтэй ажиллах хэм хэмжээг тодорхойлох хэрэгсэл, баримт бичигтэй байх хэрэгцээ шаардлагыг таниулах нөлөөллийн ажлаа эхэлсэн юм. Учир нь энэ төрлийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудын үйлчилгээний чанар янз бүр байх магадлал өндөр байв. Энэ стандартын бичиг баримт нь 2008 онд ХТҮГ болон НҮБХС-гийн идэвхтэй оролцоотойгоор Засгийн газрын холбогдох байгууллагаар эцэслэн батлагдаж, улс даяар мөрдөгдөх боломжтой болсон билээ. Мөн ХИС-гаас

ХИС бидэнд бие даан амьдрах боломж олгосон

1997 онд аав маань нас барж, ээж биднийг орхиж явснаар, бид гурав Хүүхдийг Ивээх Сангийн Дорнод аймгийн халамжийн төвд амьдрах болсон юм. Олон жил төв маань бидний гэр, багш нар маань бидний "аав, ээж" байсан. 2006 оноос эхлэн бид гурвуулаа хамт амьдарч эхэлсэн. Хүүхдийг Ивээх Сангаас бидний төлөө хийсэн бүх зүйлд нь бид нар маш их баярладаг. Бидэнд амьдрах жижиг сууц худалдан авч өгсөн, бас хагас жилийн турш хүнс, хичээлийн хэрэгслэлээр хангасан. Бид нар халамжийн төвөөс гарч бие даан амьдраад одоо 2 жил болж байна. Энэ хугацаанд багш нар болон нийгмийн ажилтнууд үргэлж бидэнд тусалж байсан. Одоо бид шинэ нөхцөлдөө дасан зохицож, мөнгөө зарцуулж сурснаас гадна бие даан шийдвэр гаргаж чаддаг болсон. Анх бие даан амьдрахад хэцүү байсан, Одоо ч тийм амар биш. Гэхдээ бид багш нарынхаа тусламжтайгаар их хичээсэн. Би сургуулиа төгсөж, одоо гурвуулаа ажил хийж амьдралаа залгуулах мөнгө олж байгаа. Жилийн өмнө ээж маань бидэн дээр эргэн ирж, бид бүгдээрээ хамт амьдрах болсонд би маш их баяртай байгаа. Өмнө нь ээжийгээ траншейд байхад нь очиж уулзах хүсэл их байдаг байсан боловч хүүхдүүдээс ичээд очдоггүй байсан. Одоо тэр асуудал шийдэгдсэн. Одоо ч гэсэн багш нартайгаа уулздаг, мэдэхгүй зүйлээ асуудаг. Бид нарыг хамгийн сайн ойлгож дэмжиж байдаг багш нартаа маш их баярладаг.

Н. 20 настай, ХИС-гийн Дорнод аймаг дахь халамжийн төвд амьдарч байсан.

гэр бүлд болон олон нийтэд суурилсан хүүхдийн асрамж, халамжийн бодлогоо түгээн дэлгэрүүлэх, хүүхдийг халамжийн байгууллагад амьдруулах хувилбарыг "хамгийн сүүлийн шатанд авч үзэх арга зам" гэдэг байр суурь, бодлогоо (2005) томьёолон гаргасан билээ.

ХИС-гийн төвд 7 жил амьдарсан Э. 1999 оноос холбоо тасарсан байсан ээжтэйгээ уулзсан баярт мөч. Улаанбаатар, 2006 он.



Сургуулийн өмнөх боловсролын хөгжилд оруулсан хувь нэмэр (1994–2000)

1994 онд бага насны хүүхдийн боловсролын салбар дахь цорын ганц гаднын хандивлагч нь ХИС байлаа. ХИС нь хүний хөгжил төлөвшилд бага насны үеийн хөгжил төлөвшил ихээхэн ач холбогдолтойгоос гадна сургуулийн өмнөх боловсролын салбарт хүүхэд төвтэй арга зүйг түгээн дэлгэрүүлэх боломжийг урьдчилан харсны үндсэн дээр тус салбарт хөрөнгө оруулах, сонирхогч талуудтай хамтран ажиллах стратегийн шийдвэрийг гаргасан юм.

ХИС-гийн санаачлагаар БСШУЯ, ХТҮТ-тэй хамтран 1994 онд сургуулийн өмнөх боловсролын нөхцөл байдлын судалгааг үндэсний хэмжээнд зохион байгуулж, сургуулийн өмнөх боловсролын чанар, хүртээмж, ялангуяа эмзэг бүлгийн хүүхдийн боловсролд хамрагдаж буй байдалд дүн шинжилгээ хийсэн юм. Энэхүү судалгааны дүгнэлт, зөвлөмжид үндэслэн “Сургуулийн Өмнөх Боловсролыг Хөгжүүлэх Үндэсний Хөтөлбөр-I (1995–2000)”-боловсрогдсон юм.

“Сургуулийн Өмнөх Боловсролыг Хөгжүүлэх Үндэсний Хөтөлбөр-I”-ийн хэрэгжилтийн бүхий л үе шатанд ХИС Засгийн газрын гол хамтрагч нь байсан бөгөөд сургуулийн өмнөх боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах замаар тус салбарыг өөрчлөн шинэчлэх, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний зардлыг бууруулах, ялангуяа эмзэг бүлгийн хүүхдүүдэд үйлчилгээг хүргэхийн төлөө хамтран ажилласан билээ. ХИС-гаас сургуулийн өмнөх боловсролын салбарын мэргэжилтнүүдийг хүүхэд төвтэй арга зүйн асуудлаарх олон улсын болон үндэсний сургалтуудад үе шаттай хамруулж байсан нь энэ салбар дахь сонирхогч талуудын чадавхийг бэхжүүлэхэд онцгой ач холбогдолтой байв. Сургуулийн өмнөх боловсрол олгох цэцэрлэгийн үйл ажиллагаанд хүүхэд төвтэй арга зүйг нэвтрүүлэх ХИС-гийн туршилтын төсөл 1996 онд Улаанбаатар хотын 2 цэцэрлэг дээр эхэлж, 1998 онд Дархан-Уул, Дундговь, Орхон аймагт өргөжин хэрэгжив. ХИС-гийн дэмжлэгтэйгээр 1996–1998 онд сургуулийн

өмнөх боловсролын салбарын 20 багш, эрхлэгч, мэргэжилтнүүд Сингапур улс дахь Зүүн өмнөд Азийн бүсийн бага насны хүүхдийн боловсролын сургалт судалгааны төвийн хүүхэд төвт арга зүйн 3 долоо хоногоос 6 сар хүртэлх хугацааны сургалтуудад хамрагдсан юм.

ХИС-гаас үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд, БСШУЯ-ны Бодлогын төлөвлөлт зохицуулалтын Нэгж болон Боловсрол судлалын Хүрээлэнгийн сургуулийн өмнөх боловсролын сургалт, судалгааны Төв, Цэцэрлэгийн багшийн коллеж зэрэг байгууллагуудад олон талт дэмжлэг үзүүлж амжилттай хамтран ажилласан билээ. ХИС-гийн арга зүйн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр байгуулсан Сургуулийн өмнөх боловсролын сургалт-судалгааны төв нь салбарын багш, мэргэжилтнүүдэд нэн чухал шаардлагатай байсан арга зүйн дэмжлэгийг үзүүлж, багшлах гарын авлага, сургалтын материалууд боловсруулж нэвтрүүлэх, үндэсний болон орон нутгийн сургалт-семинаруудыг зохион байгуулж сургуулийн өмнөх боловсролын боловсон хүчний чадавхийг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Сургуулийн өмнөх боловсролын салбарыг шинэчлэх өөрчлөлтүүдийг хийхэд орон нутгийн засаг захиргаа, боловсрол соёлын газрууд, мэргэжилтнүүд, эцэг эх, олон нийтийн оролцоо нэн чухал байлаа. Сургуулийн өмнөх боловсролыг бэхжүүлэх орон нутгийн үүсгэл санаачлагыг идэвхжүүлэхийн тулд ХИС жижиг төслийг дэмжих схемийг бий болгосон юм. Энэхүү схемээр дамжуулан алслагдсан орон нутгийн болон эмзэг бүлгийн,

Малчин өрхийн хүүхдүүд ХИС-гийн байгуулсан гэр цэцэрлэгт, Дорнод аймаг, 2007 он



тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгох, орон нутагт цэцэрлэгийн үйл ажиллагаанд эцэг эх, орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, олон нийт болон цэцэрлэгийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зэрэг үүсгэл санаачлагуудыг дэмжсэн нь сургуулийн өмнөх боловсролын салбарт чухал ахиц дэвшлийг авчирсан юм.

ХИС–гийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн дээрх үйл ажиллагаануудын зэрэгцээ тус салбарт үзүүлж буй дэмжлэг туслалцаагаа өргөжүүлэх, үр дүнтэй болгох үүднээс үйл ажиллагааны бусад хэлбэрүүдийг ч идэвхтэй ашиглан ажиллаж байлаа. Тухайлбал, өмнө өгүүлсэн ЯБҮХ–ийн Орон Нутгийн Хөгжлийн Сангийн дор байгуулсан Сургуулийн өмнөх боловсролыг дэмжих дэд сангаар дамжуулан орон нутгийн цэцэрлэгүүдийн үйл ажиллагааг дэмжиж ажилласан юм. Энэ механизмаар дамжуулан Завхан, Говь–Алтай, Булган, Төв, Ховд, Дундговь аймгуудад сургуулийн өмнөх боловсрол олгох олон шинэлэг үйл ажиллагааг дэмжин, цэцэрлэгийн барилгыг засварлах, гэр цэцэрлэг¹¹ болон явуулын цэцэрлэг¹² байгуулах, эмзэг бүлгийн болон алслагдсан орон нутгийн хүүхдүүдэд боловсролын үйлчилгээг хүргэх олон шинэлэг арга, үйл ажиллагааг туршин хийсэн билээ. Мөн хүүхдээ ердийн цэцэрлэгт явуулах эдийн засгийн боломжгүй өрхийн хүүхдүүдэд цагийн, хагас өдрийн сургалтуудыг зохион байгуулах, цэцэрлэгийн хоолны төлбөрт хөнгөлөлт үзүүлэх зэрэг олон төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Эдгээр арга хэмжээг туршиж, хэрэгжүүлэхэд орон нутгийн сайн дурын идэвхтнүүдийн хүчийг амжилттай



дайчилж чадсан юм. Хожим нь сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, ердийн цэцэрлэгээс бусад хэлбэрээр бага насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох дээрх шинэлэг арга хэлбэрүүд нь үндэсний хэмжээнд туршигдан хэрэгжиж, “сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалт” гэж нэрлэгдэх болсон билээ.

Сургуулийн Өмнөх Боловсролыг Хөгжүүлэх Үндэсний Хөтөлбөрийн ололт амжилтыг энэ салбарт оруулсан ХИС–гийн хөрөнгө оруулалт, хүчин зүтгэлтэй зүй ёсоор холбож үздэг. Хөтөлбөрийн үр дүнд сургуулийн өмнөх боловсролын ач холбогдлын талаарх олон нийтийн ойлголт бүх шатанд нэмэгдэж, сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт үндэсний хэмжээнд 13,5 хувиар өссөн юм. Энэхүү өсөлтийн үндсэн шалтгаан нь ХИС–гаас санаачлан нэвтрүүлсэн сургуулийн өмнөх боловсрол олгох хувилбарт сургалтуудын үр дүн байсан билээ.

Сургуулийн өмнөх боловсролын салбарын хамгийн хүнд үед буюу 1990–ээд оны дундуур ХИС тус салбарт ажиллах болсон нь Монгол Улсын хөгжилд үнэлж баршгүй хувь нэмэр болсон. Тухайн үед ХИС бага насны хүүхдийн боловсролын чиглэлийг сонгож ажиллаагүйсэн бол хожим нь биднээс хувь хүний болоод улс орны хөгжил, дэвшилд онцгой чухал үүрэгтэй сургуулийн өмнөх боловсролын салбарыг дахин сэргээхэд маш их цаг хугацаа, хөрөнгө, хүчин чармайлт шаардагдах байсан.

Т.Цэндсүрэн, ХИС–гийн боловсролын хөтөлбөрийн ажилтан (1997–2006)

Гэр цэцэрлэг. Хөвсгөл аймаг

¹¹ Монгол гэрт үйл ажиллагаа явуулдаг цэцэрлэг

¹² Малчин өрхийн хүүхдүүдийг цэцэрлэгт хамруулахын тулд гэр цэцэрлэгүүд нь малчдад ойр байрлаж, явуулын үйл ажиллагаагаа явуулдаг.

Сургуулийн өмнөх болон бага боловсролыг бэхжүүлэх нь (2000 оноос)

2000 он гэхэд Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал сайжирч шилжилтийн үеийн хямралт байдлаас нэгэнт гарсан үе байв. Хэдийгээр ядуурлын түвшин буураагүй ч 1999 он гэхэд Монголын хүний хөгжлийн үзүүлэлтүүд сайжирч, 1990 оны түвшнээс давж гарсан байлаа. Сургуулийн өмнөх боловсрол бүрэн сэргэж, Сургуулийн Өмнөх Боловсролыг Хөгжүүлэх Үндэсний Хөтөлбөр–2 хэрэгжиж эхэлсэн юм. Сургуулийн өмнөх боловсролын салбарт олон улсын бусад байгууллага, хандивлагчид ч анхаарлаа хандуулж эхэлсэн байлаа.

2000 онд батлагдсан ХИС–гийн Монгол дахь хөтөлбөрийн шинэ стратегийн хүрээнд ХИС үндэсний түвшинд сургуулийн өмнөх боловсролын салбарын чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийн зэрэгцээ бүх аймагт хүрч ажиллах биш харин тухайлан сонгосон цөөн аймаг, орон нутаг төвлөрч ажиллах болсон юм. Энэ нь тухайн сонгогдсон орон нутаг дахь сургуулийн өмнөх боловсролын асуудлыг цогц байдлаар дэмжих боломжийг бүрдүүлсэн билээ.

2000–2005 онуудад ХИС–гийн орон нутагт үзүүлэх тусламж нь Ховд, Дорнод, Баян–Өлгий, Баянхонгор, Дундговь аймгууд болон Улаанбаатар хотын зарим дүүрэгт төвлөрч байлаа. Энэ үед ХИС нь хүүхэд төвтэй арга зүйг нэвтрүүлэх, орон нутгийн чадавхийг бэхжүүлэх, хүүхдийн сурч хөгжих нөхцлийг сайжруулахад анхаарч ажилласан юм. Хүүхдийн нас сэтгэхүй, хөгжлийн онцлогт тохирсон тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүний хангамжийг сайжруулж, дөрвөн аймгийн Боловсрол Соёлын Газар дээр сургуулийн өмнөх боловсролын арга зүйн төвүүдийг нээн ажиллуулав.

2002–2008 онуудад ХИС олон улсын болон орон нутгийн санхүүгийн нөөцийг амжилттай дайчлах замаар нийт 14 цэцэрлэгийн барилгыг шинээр барьж, олон нийтэд суурилсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг

нөхөн сэргээх 5 төвийг 4 аймаг болон Улаанбаатар хотод байгуулсан юм.

ХИС алслагдсан орон нутгийн хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах зорилгоор орон нутагт хувилбарт сургалтуудыг дэмжин ажилласнаар зөвхөн 2004 онд 5200 хүүхэд хувилбарт сургалтын хүрээнд сургуулийн өмнөх боловсролд хамрагджээ.

ХИС сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтын чанарыг сайжруулах зорилгоор гэр цэцэрлэгийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжүүлэх асуудлаар сонирхогч талуудтай идэвхтэй хамтран ажилласан юм. Энэ ажлын хүрээнд холимог бүлгийн сургалтын болон явуулын багшийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах үйл ажиллагааг өргөжүүлж, дэд төслүүдийг хэрэгжүүлэхдээ олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагууд, тухайлбал Сургуулийн Өмнөх Боловсролын Сургууль, Удирдлагын Хөгжлийн Академи, Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг, Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхэдтэй Эцэг Эхийн Холбоо зэрэг байгууллагуудтай нягт хамтран ажиллав.

Сургуулийн өмнөх болон бага боловсролын залгамж холбооны ач холбогдол болон хүүхдүүд сургуулийн бага ангиас завсардах, анги улирах нь нийтлэг байгааг харгалзан ХИС боловсролын хөтөлбөрийн үйл ажиллагаагаа сургуулийн өмнөх боловсролын салбараас гадагшлан өргөжүүлсэн юм.



Малчин хүүхдийн боловсрол

"2003 онд ХИС орон нутгийн засаг захиргаатай хамтран малчин хүүхдүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулснаар ХИС-гийн "Малчин хүүхдийн боловсрол"(2003–2006) төслийн эхлэл тавигдсан юм. Хөдөөд бага ангиас сургууль завсардах нь элбэг, мөн сургуульд огт явж үзээгүй хүүхэд ч олон байсан нь үнэхээр анхаарал татсан асуудал байлаа. Эдгээр хүүхэд айлын мал маллаж гэр бүлийнхээ амьжиргаанд нэмэр болох, өөрийнхөө хоол хүнс, хувцасны хэрэгцээг хангаж байлаа. Чуулга уулзалтанд оролцсон хүүхдүүдийн хамгийн нэн тэргүүний асуудал нь тэдний боловсролын асуудал гэж хүүхдүүд өөрсдөө тодорхойллоо. Ингээд ХИС 2004 онд, хамгийн олон хүүхэд сургуулиас завсардсан Дорнодын Цагаан-Овоо, Матад сумдыг сонгон авч төсөл хэрэгжүүлэх болсон юм. Сургуулийн улирлын амралтын үеэр суларсан анги танхим болон дотуур байрыг ашиглан 10 хоногийн албан бус боловсролын сургалтыг 3 шатлалтайгаар зохион байгууллаа. Сургалт эхлэхийн өмнө ХИС болон орон нутгийн засаг захиргааны хамтарсан урилгыг сургалтын хөтөлбөрийн хамт хүүхэд нэг бүрт хүргүүлсэн. Эхний сургалтанд уригдсан нийт хүүхдүүдийн 90 хувь нь сургалтанд хүрэлцэн ирснийг харахад үнэхээр сайхан байсан.

Сургалтанд хамрагдах хугацаанд нь хүүхдүүдийг сумын Засаг дарга хүлээн авч, сумын хэмжээнд ажиллаж байгаа бүх байгууллагуудын үйл ажиллагаатай танилцуулж, тэдний сонирхлыг татсан уралдаан тэмцээн зохион байгуулав. Үе тэнгийн сургагч бэлтгэх ажлаа ч бид мөн давхар хийж байлаа. Эхний жилийн энэ туршлага дээр үндэслэн 2004–2006 онд, орон нутгийн боловсролын байгууллагууд төслийн үйл ажиллагааг нийт 7 суманд өргөжүүлэн хэрэгжүүлсэн юм. Эдгээр сургалтын үр дүнд, сургуулиас завсардсан болон огт сургуульд сурч байгаагүй нийт 400 гаруй малчин хүүхэд суурь боловсролтой болж, дийлэнх нь албан бус боловсролын сургалтаас ерөнхий боловсролын сургуульд шилжин суралцсан юм. Энэ төсөл нь эдгээр хүүхдүүдийн сурч, боловсрол эзэмших боломжийг нэмэгдүүлсэн төдийгүй сургуулийн гадна үлдсэн хүүхдүүдэд боловсрол эзэмшүүлэхэд орон нутаг, сургуулийн удирдлагын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлж чадсан билээ."

Б. Эрдэнэчимэг, ХИС-гийн Дорнод аймаг дахь орон нутгийн салбарын зохицуулагч (2003–2007)

ХИС-гийн "Сургуулийн Өмнөх ба Бага Боловсролын Чанарыг Сайжруулах Төсөл" (СӨББЧСТ) нь (2006–2009) Монгол Улс ерөнхий боловсролын 12 жилийн тогтолцоонд шилжих цаг хугацаанд амжилттай хэрэгжиж дууслаа. Сургуульд элсэн орох насыг 2005–2006 оны хичээлийн жилээс эхлэн хоёр үе шаттай бууруулснаар 2008–2009 оны хичээлийн жилээс эхлэн 6 настнууд анх удаа сургуульд элсэн суралцаж байна. Сургуульд элсэн суралцах насыг ийнхүү урагшуулсан нь эцэг эх, цэцэрлэгийн болон бага ангийн багш нараас шинэ үүрэг хариуцлага, ур чадварыг шаардаж байгаа юм. "Чанартай суурь боловсрол" төсөл нь боловсролын салбарын шинэчлэлийг дэмжин сургуулийн өмнөх болон бага боловсролын чанарыг сайжруулах, ялангуяа эмзэг бүлгийн хүүхдүүдийн боловсролд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх, эцэг эх, олон нийт, иргэний нийгмийн оролцоог боловсролын үйлчилгээ, менежментэд нэвтрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж чадлаа.



ХИС-гийн дэмжлэгтэйгээр сургуулийн өмнөх боловсролын сургалтын материал, хүүхдийн нас, хөгжлийн онцлогт тохирсон тоглоом болон бусад сурах хэрэгслийн хангамж сайжирлаа. 2007 он.

ХИС–гийн тус төсөл нь сургуулийн өмнөх ба бага боловсролын хүртээмж, чанарыг дээшлүүлэх үндэсний болон орон нутгийн чадавхийг бэхжүүлэхэд зориулж нийт 1,3 сая еврогийн хөрөнгө оруулалт хийсэн томоохон төсөл байсан юм. ХИС энэ төслийн хүрээнд Баянхонгор, Завхан, Ховд, Хөвсгөл, Сэлэнгэ, Дорнод, Сүхбаатар 7 аймаг болон Улаанбаатар хотын Чингэлтэй, Хан–Уул дүүргийн цэцэрлэг, сургуулийн хөгжлийг дэмжихийн зэрэгцээ үндэсний түвшинд боловсролын төлөвлөлт, удирдлагын чадавхи бэхжүүлэх ажлыг дэмжин ажиллав. 2008 онд батлагдсан Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг боловсруулах ажлыг дэмжиж сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтын стандартыг боловсруулаад байна. Энэхүү стандартыг баталж, хэрэгжүүлж эхэлснээр сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтын чанарт мэдэгдэхүйц өөрчлөлт гарах юм. Мөн сургуулийн өмнөх боловсролыг хувилбарт сургалтаар дамжуулан олгоход төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломжтой болж байгаа нь энэ төслийн бас нэгэн чухал хувь нэмэр билээ.

Төслийн хэрэгжилтийн хугацаанд явуулын багш нарт зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж 3, 4, 5 настай хүүхдэд боловсрол олгох явуулын багшийн сургалтаар 2 жилийн хугацаанд 2000 малчны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олголоо. ХИС–гийн дэмжлэгтэй барьж, байгуулсан цэцэрлэгүүдэд жилдээ 500 хүүхэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна.

Сургуулийн өмнөх боловсрол болон бага боловсролын залгамж холбоо, мөн I ба II ангийн сурах бичгийн үнэлгээ, хүүхэд төвтэй заах арга зүйн асуудлуудад тусгайлан анхаарсан судалгааны ажлуудыг ХИС–гаас санаачлан хийлгэсэн нь нь сургуулийн өмнөх болон бага боловсролын бодлогыг боловсронгуй болгоход тодорхой хувь нэмэр оруулсан юм. Төслийн хүрээнд нийт 131,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хүүхдийн нас, хөгжлийн онцлогт тохирсон тоглоом, сургалтын хэрэгслийн хангамжийг сайжруулахад зориулснаар сургуулийн өмнөх насны хүүхдийн сурах орчин сайжирч, нийт 96 цэцэрлэгийн 7000 гаруй хүүхэд үр шимийг нь хүртэж байна.



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролыг дэмжсэн алхмууд (1998 оноос)

1997 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох 2 тусгай цэцэрлэг, 5 сургуулийг эс тооцвол Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах боломж хязгаарлагдмал байлаа. 1998 оноос эхлэн хэрэгжүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах үйл ажиллагааг бүх хүүхдийг боловсролд тэгш хамруулах бодлого, туршлагыг Монгол Улсад хэрэгжүүлэхэд чиглэсэн ХИС-гийн их ажлын суурь тавигдсан билээ. Хожим нь ХИС сургуулийн өмнөх боловсролын салбарт хуримтлуулсан туршлага дээрээ тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд тэгш хамруулан сургах төслүүдээ эхлүүлсэн юм.

Архангай, Булган аймаг болон Улаанбаатар хотод 1998 онд туршилтын төслөөр эхэлж байсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах үйл ажиллагаа нь ХИС-гийн боловсролын хөтөлбөрийн томоохон хэсэг болон өргөжсөн юм. 2002–2006 оны хооронд 4 жилийн хугацаанд, ХИС-гийн дэмжлэгтэйгээр боловсролын үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо 1000–аас 8000 болтлоо өссөн юм. Өмнө нь ДАНИДА байгууллагаас энэ чиглэлээр зарим орон нутагт хэрэгжүүлсэн ажил нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах ХИС-гийн ажилд таатай хөрсийг бий болгосон байлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролыг сайжруулах чиглэлээр ХИС-гаас хэрэгжүүлсэн гол ажлууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулах талаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, багшлах боловсон хүчнийг бэлдэх, олон нийтэд суурилсан нөхөн сэргээх үйлчилгээг бий болгох, хууль эрх зүйн болон бодлогын шинэчлэлийг хийхэд чиглэгдэж байлаа. ХИС-гийн тусламжтайгаар олон эцэг эх, орон нутгийн хүмүүс болон сургууль, цэцэрлэгүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ялгаварлан гадуурхдаг үзэгдлийг бууруулах, арилгах, энэ талаар олон нийтийн

ойлголтыг сайжруулах ажилд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг олон төслүүдийг амжилттай хэрэгжүүлсэн. Мөн холбогдох байгууллага, мэргэжилтнүүд болон эцэг эхчүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулах талаар бусад орны туршлагаас суралцахад дэмжлэг үзүүлж, бусад улсын туршлага судлах аялал, олон улсын семинар зохион байгуулах зэрэг ажлуудыг хийсэн нь ихээхэн үр дүнтэй болсон юм. Цэцэрлэгийн багш, эрхлэгч нарт зориулсан сургалтуудыг үе шаттай зохион байгуулсны зэрэгцээ холбогдох ном, гарын авлага, сургалтын загваруудыг бий болгох, дэлгэрүүлэх ажлуудыг дэмжин ажилласан билээ.

ХИС-гийн арга зүйн болон санхүүгийн тусламжтайгаар БСШУЯ –нд “Тэгш хамруулан сургах нэгж” –ийг байгуулсан нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролыг дэмжих бодлогыг тодруулах, холбогдох бодлогын баримт бичигт тухайн асуудлыг тусгах, Засгийн газрын бодлогод нөлөөлөх боломжийг нэмэгдүүлсэн юм.



2003 оны 12-р сард “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах хөтөлбөр” батлагдсанаар энэ асуудал Засгийн газрын албан ёсны бодлого болсон юм. Ийм бодлогын баримт бичигтэй болсон явдал нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах зарчмыг амьдралд хэрэгжүүлэх нэг чухал алхам болсон билээ. ХИС-гаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд олгосон сонсголын аппарат, туслах хэрэгсэл болон бусад тусламж дэмжлэг нь олон зуун хүүхдийн нийгэмших, боловсролын үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлсэн юм. Дорнод, Ховд, Баянхонгор, Баян-Өлгий аймаг болон Улаанбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нөхөн сэргээх төвүүдийг байгуулсан нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний гэр бүл, олон нийтэд ихээхэн тустай үйл хэрэг болсон билээ. Улаанбаатар хотын

10-р цэцэрлэгийг түшиглэсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нөхөн сэргээх үндэсний төв ч мөн ийм зорилготой байгуулагдсан юм. Улсын хэмжээнд 69 сургууль, 13 цэцэрлэгийн хаалга шатыг тэргэнцэртэй хүүхэд орох, гарахад тохиромжтой болгон засварлах ажлыг ХИС төслүүдийнхээ хүрээнд мөн дэмжсэн юм. Мөн ХИС хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдтэй хамтран ажиллаж тэднийг зохион байгуулалтад орж өөрсдийн нийгэмлэг байгуулах (2002 он) үйл ажиллагааг дэмжсэн юм. Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдүүдийн Эцэг, Эхийн Холбоог дэмжиж, хамтран ажилласнаар энэ нийгэмлэг өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалах иргэний нийгмийн идэвхитэй байгууллага болж чадсан бөгөөд орон нутагт 11 салбар, 4000 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

5 настай А. охин, ХИС-гийн олон нийтэд түшиглэсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нөхөн сэргээх төвөөр бараг жил орчим үйлчлүүлж байгаа. Төвд ирэхээсээ өмнө явж чаддаггүй байсан. Одоо А бусад хүүхдийн нэг адил явж, гүйж чаддаг болсон. Мөн ХИС-гаас түүний эцэг эхийг дэмжин, А болон түүний ахыг цэцэрлэгт хамрагдахад нь тусалсан юм.



Г, 14 настай, хөлийнхөө хуруугаар юм барьж чаддаг. Түүний багш нь өдөр тутмын амьдралдаа болон хичээлээ хийхдээ хөлөө хэрхэн ашиглахыг зааж өгсөн юм. Тэр одоо хөлөөрөө бичиж, зурж, хөгжим тоглож чаддаг. Бас өвөө, эмээ нь ажилдаа явсан хойгуур гэртээ биеэ дааж үлдэж чаддаг болсон. Түүний багш нь орон нутагт байгаа хөгжлийн бэрхшээлтэй 15 хүүхэдтэй гэрээр нь очиж ажиллаж, мөн өөр 2 багшийг дагалдуулан сургасан бөгөөд үүнийг ХИС-гийн Дорнод аймаг дахь салбар дэмжиж ажилласан юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн сэргээх үйлчилгээ

2003 оны үед Дорнод аймагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх статистикийн найдвартай тоо баримт байхгүй байлаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн оролцоотойгоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг олж тогтоох, мэдээлэл цуглуулах ажлыг ХИС эхэлж, зөвхөн аймгийн төвд 900 гаруй хүүхэд байгааг тогтоосон нь эдгээр хүүхдүүдэд зориулсан нөхөн сэргээх үйлчилгээний асар их хэрэгцээ байгааг харуулсан юм. ХИС болон орон нутгийн засаг захиргаа, эцэг эхчүүдийн хичээл зүтгэл, хүчин чармайлтын үндсэн дээр, бүсийн оношлогоо эмчилгээний төвийг түшиглэсэн Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдүүдийг Нөхөн Сэргээх Төвийг 2003 оны 5 сард ашиглалтад орууллаа. Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдүүдийн Эцэг Эхийн Холбоо (ХБХЭЭХ) ч энэ төв дээр байрлах болсноор хүүхдүүд, тэдний эцэг эх, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй ойр ажиллах боломж нэмэгдлээ. Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдүүдийг эмчилгээ, үйлчилгээнд хамруулж эхэлснээс хойш хагас жилийн дараагаас эхний үр дүнгүүд гарч эхэллээ. Огт явж чаддаггүй, хайрцганд суудаг байсан гурван настай хүүхэд анх удаагаа алхлаа. Тус төвөөр зөвхөн аймгийн төвийн төдийгүй сумын хүүхдүүд ч ирж үйлчлүүлдэг боллоо. Хүүхдээ авчирч төвийн үйлчилгээнд хамруулах боломжгүй айлын хүүхдүүдэд хүрч үйлчлэх "гэрийн сургагч" нарыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ээж нарын дундаас бэлтгэлээ. Сургагчаар бэлтгэгдсэн 15 ээж, нөхөн сэргээх төвийн эмч сувилагч нартай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй айлуудаар явж эцэг эхчүүдэд хүүхдээ гэрийн нөхцөлд хэрхэн асарч сувилах, нөхөн сэргээх дасгалыг хэрхэн хийх аргуудыг зааж зөвлөх ажлуудыг хийж эхэллээ. Энэ ажлын сургаар, сургуульд явах боломжгүй оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүд бидэнд хандаж хүүхдүүдээ хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг хүссэн юм. Бид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байсан гадлага туршлагатай 5 багшийг сонгон "Гэрийн багш" болгон бэлтгэсэн юм. Багш нар маань гэртээ байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн гэрээр нь очиж, хүүхэд нэг бүрийн хөгжлийн түвшин, хэрэгцээнд тохирсон сургалтуудыг явуулахаас гадна нөхөн сэргээх төвөөр үйлчлүүлж байгаа, сургуульд явдаггүй хүүхдүүдэд зориулсан сургалтуудыг явуулж эхэлсэн юм. Энэ бүх үйл ажиллагааг амжилттай болоход орон нутгийн удирдлагын байнгын дэмжлэг чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Нөхөн сэргээх төв нь одоо хүүхдүүд төдийгүй, тэдний эцэг эхчүүдийн ирэх дуртай газар нэгэнт болжээ. Төв дээр хүүхдүүд нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдахаас гадна нийгэмших, тоглох, сурч хөгжих боломжоор хангагддаг. Нөхөн сэргээх төв нь анх үйлчилгээ үзүүлж эхэлсэн өдрөөс хойш өнгөрсөн зургаан жилийн хугацаанд нийт 605 хүүхдэд хүрч үйлчилснээр тэдгээр хүүхдүүдийн амьдралыг илүү гэгээтэй, баяр баясгалантай болгосон билээ. Бидний дэмжиж эхлүүлсэн ажил орон нутгийн удирдлага, иргэдийн санаачлага, хүчин чармалтаар ийнхүү тогтвортой үргэлжилж байгааг харахад их бахархалтай байдаг.

Б. Эрдэнэчимэг, ХИС-гийн Дорнод аймаг дахь орон нутгийн салбарын зохицуулагч (2003–2007)



Үндэсний цөөнхийн хүүхдийн боловсролыг дэмжсэн ажлууд (1998 оноос)

Монголын нийт хүүхдийн таван хувийг эзэлдэг казах хүүхдийн боловсролын асуудалд ХИС онцгой анхаарал хандуулсаар ирсэн юм. Казах хүн ам оршин суудаг Баян-Өлгий аймаг нь боловсролын үзүүлэлтээрээ улсад доогуур ордог бөгөөд сургууль завсардалтын түвшин хамгийн өндөр байдаг.

1998–2000 онуудад Баян-Өлгий аймагт хэрэгжүүлсэн ХИС-гийн олон нийтэд түшиглэсэн төслүүд нь олон хүүхэдтэй ядуу өрхийн орлого нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжин, тэдний хүүхдийн сургууль, цэцэрлэгт хамрагдах боломжийг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байлаа. Баян-Өлгий аймгийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын хувь улсын хэмжээнд хамгийн бага байгааг анхаарч, Баян-Өлгий аймгийн цэцэрлэгийн багш нарын чадавхи бэхжүүлэх үйл ажиллагааг тусгайлан зохион байгуулж, Улаанбаатар хотын тэргүүний цэцэрлэгүүдийн туршлагаас судлуулах ажлыг зохион байгуулж, зөвхөн 2002 онд 30 гэр цэцэрлэгийг тус аймагт байгуулж ажиллуулсан билээ. Мөн казах цагаан толгойн сурах бичгийг 2003 онд боловсруулж хэвлүүлсэн нь Монголд анх удаа казах хүүхэд өөрийн эх хэл дээр цагаан толгойн үсгийг сурах боломжийг бий болгосон юм.

Хос хэлээр сурах боловсролын тогтолцоо Монгол Улсад байхгүй байгаа нь казах хүүхдийн сурах үйл явцад сөргөөр нөлөөлж байна гэсэн дүгнэлтийг казах хүүхдийн боловсролын байдалд дүн шинжилгээ хийсэн ХИС-гийн 2006 оны судалгаагаар хийсэн юм. Судалгааны дүгнэлтэд үндэслэн ХИС-гаас казах хүүхдийн сургуулийн өмнөх болон бага боловсролыг дэмжих хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж, казах хүүхдүүдэд зориулсан монгол хэлний 2, 3 ба 5-р ангийн сурах бичгүүдийг 2007 онд анх боловсруулж, нийт 9900 ширхгийг хэвлэн казах хүүхдүүдийн боловсролыг дэмжсэн билээ.

Дээр дурдсан судалгааны ажил нь мөн НҮБ-ын Арьс Өнгөөр Ялгаварлан Гадуурхахын Эсрэг

Хороонд гаргасан Монгол Улсын Засгийн газрын тайланг дагалдах сүүдэр тайлангийн үүрэг гүйцэтгэсэн юм. Үүний үр дүнд тус хорооноос 2006 онд Засгийн газарт өгсөн дүгнэлт зөвлөмжинд “...Үндэсний цөөнхийн хүүхдүүдэд өөрсдийн эх хэлээр сурах боломжоос гадна улсын албан ёсны хэлийг сурах боломжийг бүрдүүлж, хос хэлээр сурах тогтолцоог бий болгон хөгжүүлэхийг” онцлон зөвлөсөн билээ. ХИС-гийн арга зүйн дэмжлэгтэйгээр боловсруулсан “Казах хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөр”-ийг (2008–2012) БСШУЯ-наас батлан хэрэгжүүлж эхлээд байна. Уг хөтөлбөрийн хүрээнд казах хэлээр сургалт явуулдаг сургуулийн сургалтын төлөвлөгөө, агуулга, хөтөлбөрийг шинжлэх ухааны үндэстэй судлан тогтоох, казах хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцсэн хос хэлээр сурах, сургах арга зүйг хөгжүүлэх, сурах бичиг, сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнийг казах хүүхдийн эрэлт хэрэгцээнд тохиромжтой, хүртээмжтэй болгох, казах хүүхдүүдэд тэгш, тохиромжтой байдлаар боловсролын үйлчилгээг хүргэх менежментийг боловсронгуй болгох зорилтуудыг дэвшүүлэн тавьсан юм.



Казах хүүхдүүд цэцэрлэг дээрээ, Баян-өлгий аймаг

Эрхэд суурилсан боловсролын системийг дэмжих нь (2005 оноос)

Чанартай боловсролын талаарх ХИС–гийн ойлголт, арга барил нь цаг хугацааны явцад баяжин, хүүхдийн хөгжлийг дэмжих боловсрол, аюулгүй, хамгаалагдсан сурах орчныг бий болгоход онцгой анхаарал хандуулах болсон юм. Судалгаанаас харахад сургууль, цэцэрлэгүүдэд хүүхдийг ялгаварлан гадуурхах, хүчирхийлэл дарамтанд өртүүлэх, сэтгэл санааны болон эдийн засгийн дарамт учруулах явдал элбэг байна. Дөрвөн хүүхэд тутмын нэг нь сургууль дээрээ багш нарын хүчирхийлэл, дарамтанд өртөж байгаагаас гадна сургууль дээр янз бүрийн хууль бус татвар, мөнгө татдаг үзэгдэл элбэг байна.¹³

ХИС–гаас 2005 онд Боловсролын тухай хуулинд хүүхдийн эрхийн үүднээс хийсэн дүн шинжилгээгээр боловсролын систем нь хүүхэд бүрийн сурах эрхийг хүндэтгэх, хүчирхийлэл дарамтаас ангид байх аюулгүй сурах орчныг бий болгох, боловсролын үйл ажиллагаанд хүүхдийн болон иргэний нийгэм, орон нутгийн засаг захиргааны оролцоог нэмэгдүүлэх, хүүхдэд чанартай боловсрол олгох үүрэг хүлээгчдийн эрх, үүргийг олон нийтэд тодорхой болгох шаардлагатай байгаа нь харагдсан юм. Тиймээс ХИС Боловсролын тухай хуулинд холбогдох өөрчлөлтүүдийг оруулах нөлөөллийн кампанит ажлыг жил илүү хугацаанд өрнүүлэн, олон улсын ба орон нутгийн 21 байгууллагын бүрэлдэхүүнтэй байгуулагдсан “Хүүхдийн эрх ба боловсрол” нэртэй эвслийг манлайлан ажилласан билээ. ХИС болон эвслээс санал болгосон нийт 20 гаруй зүйлийн өөрчлөлтийг 2006 оны 12–р сард УИХ батлан гаргаснаар боловсролын системийн орчинд бүх төрлийн хүчирхийлэл, дарамтыг хориглож, сургууль дээр хууль бус мөнгө хураадаг практикийг устгаж хориглох, багш нарын мэргэжлийн ёс зүйн дүрмийг бий болгон мөрдөх, хүүхдийн дуу хоолойг сонсох, оролцоог дэмжих заалтууд хуульчлагдсан юм. Мөн орон нутгийн засаг захиргаа болон боловсролын байгууллагууд өөрсдийн нутаг дэвсгэр дээрх бүх хүүхдэд боловсрол олгох

ажлыг хариуцах, үндэсний цөөнх хүүхдийн сурах боломжийг хангах үүргийг хуульчилсан. Хуулинд оруулсан өөрчлөлтөөр бага, дунд боловсролын албан бус сургалтанд суралцагчдын тооноос хамааран хувьсах зардлыг төсвөөс хуваарилах болсон нь албан боловсролд хамрагдах боломжгүй байгаа эмзэг бүлгийн хүүхдүүдийн боловсролд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх өндөр ач холбогдолтой болсон билээ.

Боловсролын тухай хуулинд хүүхдийн эрхэд суурилсан өөрчлөлтүүдийг оруулах ажлыг амжилтанд хүрэхэд “Хүүхдийн эрх ба боловсрол” эвсэл, УИХ дахь хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих лобби бүлэг, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд, эцэг эх, олон нийт чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Мөн өөрсдийн санаа бодлыг илэрхийлж, манай судалгаа болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр явуулсан хэлэлцүүлэг, маргаанд идэвхтэй оролцож, зохион бичлэгийн уралдаанд амжилттай оролцсон хүүхдүүдийн үүрэг оролцоо чухал үүрэгтэй байсан билээ. Уг ажлыг амжилттай болгохын төлөө ХИС–гийн бүх ажилтнууд онцгой хүчин чармайлт гаргасан юм.

Боловсролын тухай хуулинд оруулах өөрчлөлтийн талаарх ХИС–гийн саналыг Монгол Улсын Шадар сайдад танилцуулах уулзалт. Төрийн Ордон, 2006 он.



(баруун гар талаас) Шадар сайд М. Энхсайхан, Шадар сайдын зөвлөх Б. Жавзанхүү, (зүүн гар талаас) ИБХИС–гийн Монгол дахь захирал, хөтөлбөрийн ажилтан Д. Амраа, хуульч Х.Тэмүүжин

¹³ “Хүүхдийн бие махбод, сэтгэл санааны эсрэг шийтгэл: Хүүхдийн үзэл бодол” Хүүхдэд үйлчилдэг зарим байгууллагад хийсэн судалгаа, 2005, ХИС,ЗХЖТ

2007 онд батлагдсан шинэ төлөвлөгөөний дагуу ХИС–гийн боловсролын хөтөлбөр нь Боловсролын тухай хуульд орсон дээрх өөрчлөлтүүдийг амьдралд хэрэгжүүлэх, боловсролын системийг хүүхдийн эрхэд нийцүүлэн хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахыг зорин ажиллаж байна. Боловсролын хүртээмж, чанарыг дээшлүүлэх, хос хэлээр сургах арга зүйг боловсруулах, нэвтрүүлэх, хүүхэд төвтэй сургалтын арга зүйг бататгах, хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхдэд ээлтэй боловсролын орчныг бүрдүүлэх, багш нарт хүмүүжлийн эерэг аргыг эзэмшүүлэх зэрэгт ХИС онцгойлон анхаарч байгаа билээ. Мөн хуулинд орсон өөрчлөлтүүдийн талаарх олон нийтийн ойлголтыг гүнзгийрүүлэх, хуулийн хэрэгжилтийг хянахад иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна.

ХИС–гийн одоо хэрэгжүүлж буй боловсролын төслүүд нь боловсролын орчныг хүчирхийлэл, дарамтаас ангид байлгах, хүчирхийллийн бус

хүмүүжлийн аргыг дэлгэрүүлэхэд чиглэгдэж байна. ХИС олон нийтэд болон боловсролын байгууллагын ажилтнуудад (сургуулийн захирал, багш нар) чиглэсэн ойлголт нэмэгдүүлэх ажлыг хийн, хүүхдийг хүчирхийллийн бус аргаар хүмүүжүүлэх арга зүйд сургах, сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх, хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх ажлуудыг дэмжиж байна.

Багш нарыг бэлтгэх сургалтын хөтөлбөрт хүчирхийллийн бус хүмүүжлийн эерэг арга зүйг нэвтрүүлэх, боловсрол, эрүүл мэндийн мэргэжлийн хяналтын ажилтнуудад сургуулийн үйл ажиллагааг хянах зохистой мэдлэг чадварыг эзэмшүүлэхийг дэмжих ажлуудыг мөн хийж байна.

ХИС–гаас санаачлан хэрэгжүүлсэн боловсролын салбарын бодлого, хууль эрх зүйн хүрээнд хийсэн дээрх өөрчлөлтүүд нь Монголын бүх хүүхдүүдийн амьдралд урт хугацааны, эерэг өөрчлөлтүүдийг авчирна гэдэгт ХИС итгэл төгс байдаг.



Гамшгийн үеийн тусламж

ХИС анх 1919 онд, дэлхийн нэгдүгээр дайны дараа дайнд нэрвэгдсэн Европын хүүхэд, залууст туслах зорилгоор байгуулагдаж байсан билээ. Тийм ч учраас байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гамшигт нэрвэгдсэн хүн амд туслах нь ХИС-гийн дэлхий даяарх үйл ажиллагааны нэг чухал хэсэг байсаар ирсэн юм. ХИС-гийн Монгол дахь Хөтөлбөрийн тухайд гамшгийн үеийн тусламж үзүүлэх нь хөтөлбөрийн байнгын үйл ажиллагааны нэг хэсэг биш боловч гамшгийн байдал үүссэн хүнд нөхцөлд гамшигт нэрвэгдсэн орон нутагт тусламжийн гараа сунган ажиллаж байсан билээ.

2000–2001 оны өвөл Монголд 2 жил дараалан зуд¹⁴ болж нийт 450 мянган малчин (хүн амын тавны нэг) гамшигт нэрвэгдэж, 3 сая мал (нийт малын аравны нэг) хорогдсон тэр хүнд үед¹⁵ ХИС гурван удаагийн тусламжийн төсөл хэрэгжүүлсэн юм.

2001 оны 4–р сард Баянхонгор аймгийн эмэгтэйчүүд, хүүхдүүдийн дунд хоол тэжээлийн судалгаа хийсний үндсэн дээр зудад хамгийн ихээр нэрвэгдсэн зургаан сумын хүн амд 187 сая төгрөгийн хүнсний тусламж үзүүлэх төслийг дөрвөн сарын хугацаанд хэрэгжүүлэв. Европын Холбооны Хүмүүнлэгийн Тусламжийн Байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр 420 өрхөд хүнс, таваас доош насны 3000 хүүхэд,

2000 жирэмсэн эмэгтэйд хоолны нэмэгдэл тэжээл болон витамин, сумын сургуулийн дотуур байр, цэцэрлэг, эмнэлэгт хүнс, ногооны үр, ногоо тарих хүлэмж барих хөрөнгө хандивласан юм.¹⁶

2001 онд Ховд аймгийн гурван суманд хэрэгжүүлсэн гамшгийн тусламжийн хөтөлбөрийн хүрээнд малын тэжээл болон хүнс, мөн сургууль, цэцэрлэг, эмнэлэгт шаардлагатай бусад зүйлээр тусалж байлаа. Мөн өмнөх жилийн гамшгийн үеэр тусламжийн сургамждаа тулгуурлан малын тэжээлийг зудад нэрвэгдсэн малчдад цаг алдалгүй шуурхай хүргэснээр олон зуун мянган мал хорогдохоос сэргийлж чадсан билээ. Олон Улсын Хөгжлийн Нийгэмлэг болон Английн Бруки эмнэлгийн санхүүгийн дэмжлэгтэйгээр нийт 115 тн малын тэжээлийг 856 өрхөд, 227 тн хүнсийг 699 ядуу өрхөд хүргэж, мөн 14 тн хүнс, 76 машин нүүрс, түлээ, 1540 ширхэг дулаан хөнжил, гудас, матрасыг 12 цэцэрлэг, эмнэлэг, сургуулийн дотуур байранд тусламж болгон өгч байсан юм.¹⁷

2001 онд Дорнод аймагт гар, хөл, амны өвчин гарч хорио цээр тогтоосон үед ХИС-гаас 10,3 сая төгрөгийн тусламж дэмжлэгийг орон нутгийн байгууллагуудад үзүүлсэн юм. Нийт 310 ядуу өрх болон сургуулийн дотуур байрыг хүнс,



Зудын үеийн малчин өрх, Дундговь аймаг, 2003 он

¹⁴ Зуд

¹⁵ Монгол Улсын Засгийн газар болон НҮБХХ-өөс хамтран олон улсын байгууллагуудад хандан гаргасан, зудад нэрвэгдсэн орон нутагт тусламж үзүүлэхийг хүссэн уриалга, 2001 оны I сар

¹⁶ Баянхонгор аймагт хэрэгжүүлсэн гамшгийн тусламжийн төслийн баримт бичиг, ХИС, 2000

¹⁷ Ховд аймагт хэрэгжүүлсэн гамшгийн тусламжийн төслийн баримт бичиг, ХИС, 2001

950 өрхийг халдваргүйжүүлэлт, ариутгалын бодисоор хангаж, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр энэ өвчний талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх кампанит ажил хийж байлаа. Мөн хараа хяналтгүй 40 хүүхдэд амьдрах байр болон бусад шаардлагатай тусламж үзүүлсэн юм.¹⁸

2003 онд Дундговь аймгийн Адаацаг, Эрдэнэдалай сумын зудад нэрвэгдсэн иргэдэд 31 сая төгрөгийн туслалцаа үзүүлсний дотор 36 тн хүнсний бүтээгдэхүүнийг гурав ба түүнээс дээш хүүхэдтэй 370 ядуу өрхөд хүргэж, 530 өрхийг малын тэжээлээр ханган, цэцэрлэг, дотуур байр, эмнэлэгт түлээ, нүүрс, дулаан хөнжил гудас, хүнсний бүтээгдэхүүн олгосон юм.¹⁹

Гамшгийн үеийн тусламжийн төслүүдийн хяналт, үнэлгээний тайланд дурдсанаар ХИС дээрх орон нутгуудад тусламжийг цаг алдалгүй хүргэснээр малын хорогдлыг эрс бууруулж чадсан гэж орон нутгийн удирдлага, иргэд үнэлсэн байдаг. Амьдрал, аж ахуй нь малаас хамааралтай хөдөөгийн малчин өрхийн малын хорогдлыг багасгаснаар олон зуун өрхийг нэн ядуу болохоос сэргийлж чадсан юм. Мөн эдгээр тусламж нь гамшгийн үед болон гамшгийн дараа хүүхдэд тусах сэтгэл зүйн сөрөг үр дагаврыг багасгах, сургуулиас завсардах болон бусад сөрөг үр дагаврыг бууруулахад зохих үүрэг гүйцэтгэсэн гэж ХИС үздэг. Сургуулийн дотуур байр, цэцэрлэг, эмнэлэгт үзүүлсэн тусламжууд нь гамшгийн үед эдгээр байгууллагуудын үйл ажиллагаа тасралтгүй

явагдах нөхцлийг хангасан байдаг.

Гамшгийн үед хүүхдийн эмзэг байдал, онцлог хэрэгцээг онцгойлон анхаарах нь ХИС-гийн гамшгийн үеийн үйл ажиллагааны нэг онцлог байдаг. ХИС-гийн олон улсын болон Монгол дахь туршлага дээр үндэслэн 2006 онд “Гамшгийн тусламжийн үйл ажиллагаанд хүүхдийн асуудлыг анхаарах нь” сэдэвт сургалтыг Онцгой Байдлын Ерөнхий Газар болон бусад төрийн ба төрийн бус байгууллагуудыг хамруулан зохион байгуулсан юм. Туршлагаас харахад гамшгийн үе болон түүний дараа малчин өрхийн эмзэг байдал, ялангуяа тэдний хүүхдийн эмзэг байдал эрс нэмэгддэг. Малчин өрх хэд хэд хуваагдахад хүрдэг. Өрхийн тэргүүн болон эхнэр нь малаа зудад нэрвэгдээгүй газруудаар оторлон хэдэн сараар нүүдэллэж, хөгшчүүл нь гэрээ харан сум, багийн төв дээр үлдэж, хүүхдүүд нь сургуулийн дотуур байранд гэр орноосоо хэдэн сараар чимээ сонсохгүй байх нь элбэг. Мөн зарим тохиолдолд хүүхдүүдийг хамаатан бус танил айлд ч үлдээсэн байдаг. Гамшгийн үед цас их орсноор зам хаагдаж, зарим сум, багуудад хүрч очих боломжгүй болж, сургуулийн дотуур байр, эмнэлэг, бусад байгууллагуудын хүнсний болон бусад хангамжууд хугацаа саатах явдал гардаг. Эдгээр олон хүчин зүйлийн улмаас гамшгийн үе болон дараа нь хүүхдүүд өндөр эрсдэлтэй нөхцөлд байдаг тул тэдний эмзэг байдал болон тусгай хэрэгцээг онцгой анхаарах шаардлагатай байдаг.

ХИС зудад нэрвэгдсэн хүн амд тусламж үзүүллээ. Дундговь аймаг, Адаацаг сум, 2003 он



¹⁸ Дорнод аймагт хэрэгжүүлсэн гамшгийн тусламжийн төслийн баримт бичиг, ХИС, 2001

¹⁹ Дундговь аймагт хэрэгжүүлсэн гамшгийн тусламжийн төслийн баримт бичиг, ХИС, 2003

Олон нийтэд түшиглэн хүүхдийн хөгжил, хамгааллын механизмыг хөгжүүлэх нь (2003 оноос)

ХИС 2003 онд олон нийтэд түшиглэсэн хүүхдийн хөгжил, хамгааллын төвүүдийг орон нутгийн түвшинд байгуулж эхэлснээр эмзэг бүлгийн хүүхдүүд, тэдний гэр бүлд дэмжлэг, үйлчилгээ хүргэх загварыг туршин, хөгжүүлж ирлээ. Орон нутгийн иргэд, олон нийттэй ойрхон ажиллах боломж давуу талыг ашиглан (тухайлбал, сургууль, эмнэлэг, орон нутгийн удирдлага) ХИС-гийн төвийн нийгмийн ажилтнууд олон нийтийн түвшинд хүүхдийн хөгжил, хамгааллын тулгамдаж байгаа асуудлуудыг илрүүлэх, сэргийлэх, шийдвэрлэх буюу хариу арга хэмжээ авах тал дээр хамтарсан багаар амжилттай ажиллаж байна. Эдгээр төвүүд тухайн олон нийтийн түвшинд ажилладаг, холбогдох мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааны төв болж чаддаг нь олны талархлыг хүлээдэг юм.

Эдгээр төвүүд нь хүүхдэд чиглэсэн боловсролын болон хөгжлийн олон талт үйл ажиллагаагаар дамжуулан хүүхдийн оролцоо, үүсгэл санаачлагыг жинхэнэ ёсоор нь дэмжин хөгжүүлдэг билээ. Мөн эцэг эхчүүдэд чиглэсэн олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд түүний дотор “Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх нь” сэдвээр тусгайлан боловсруулсан хөтөлбөрийн дагуу үе шаттай сургалтуудыг тогтмол зохион байгуулдаг юм.

Монгол Улсын нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичигт томъёолсон, олон нийтэд түшиглэсэн нийгмийн үйлчилгээний үр ашигтай загварыг ХИС 2003 оноос бий болгон хөгжүүлж байгаа бөгөөд ийм үйлчилгээний хүүхэд, олон нийтэд үзүүлэх үр нөлөөг харгалзан цаашид өргөжүүлэн нэвтрүүлэх боломжтой гэж үздэг.

Мөн олон нийтэд түшиглэсэн нийгмийн үйлчилгээг хөгжүүлэх Засгийн газрын бодлогыг дэмжих бусад алхмуудыг ч хийсэн юм. Нийгмийн халамжийн тухай хуулинд заасан нийгмийн үйлчилгээг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх заалтыг хэрэгжүүлэх ажлыг бодитой болгоход хувь нэмэр оруулах зорилгоор НХХЯ-ны

хүсэлтийн дагуу энэ асуудлаар олон улсын зөвлөхийн үйлчилгээг (2007) үзүүлсэн билээ. Зөвлөх үйлчилгээний үр дүнд бий болсон заавар, зөвлөмжийг НХХЯ үр дүнтэй ашиглан, нийгмийн үйлчилгээг гэрээлэх үйл ажиллагааг бодитой болгоно гэдэгт ХИС итгэж байна.

“... Энэ төв дээр ирээд би өөрийгөө таньж мэдсэн. Өмнө нь би гэрээс гардаггүй, олон нийтийн ажилд оролцдоггүй байсан. Гэвч энд ирснээс хойш бусдыг ойлгодог, хүндэлдэг хүн болсон. Энэ бол миний хувьд маш том өөрчлөлт.”

16 настай хүү

“... Хөвгүүдийг дэмжих бүлэгт элссэнээс хойш хүүхдүүдтэй хэрүүл, зодоон хийх маань багассан. Урд нь би хэрүүл зодоон өдөөдөг байсан бол одоо маш их өөрчлөгдсөн. Хүүхдүүдтэй сайн харилцаатай болсон. Тэд ч надтай муухай харьцахаа больсон. Багш нартайгаа хүртэл таагүй харилцаатай байсан бол одоо тийм биш. Би маш их баяртай байна.”

15 настай хүү



“.. Би олон найзтай, ихэнхтэй нь Хүүхдийг Ивээх Сангийн клубт танилцсан. Би “Хамгаалал” гэдэг нэртэй хүүхдийн клубын гишүүн. Бид нар Хүүхдийг Ивээх Сан дээр эсвэл заримдаа өөр газар уулздаг. Клубт орсноор хүүхдийн эрхийн талаар сайн ойлголттой болсон. Бид олон үйл ажиллагаа явуулдаг. Сургууль дээр хүүхдүүдийн эрх хэр их зөрчигддөг талаар бид судалгаа хийж, тэр судалгаанд 180 хүүхэд хамрагдсан юм. Багш нар муухай харьцдаг тухай, бас ядуу айлын хүүхэд сургуульд сурахад хэцүү байдаг талаар хүүхдүүд бидэнд ярьж байсан. Архи бас гол асуудал байдаг. Ажилгүй хүмүүс архи уудаг, ар гэрийнхэн нь их зовдог. Бид нар энэ мэдээллүүдээ тайланд²⁰ бичсэн. Хүмүүс хүүхдүүд эрхтэй, тэдний эрхийг зөрчих нь буруу гэдгийг мэдэх хэрэгтэй. Бид цуглаад хүүхдийн эрхийн зөрчлийг арилгах талаар өөр юу хийж болох вэ гэдгээ ярьж шийддэг. Үүнээс өмнө би 2007 онд хүүхдүүдийн зохион байгуулсан хэвлэлийн бага хуралд оролцож байсан. Тэр үед бид хүүхдүүдийг зодож шийтгэсэн багш нарын тухай ярьж, хүүхдийг зодож шийтгэхээ зогсоохыг уриалж байсан.”

С, 9 дүгээр ангийн сурагч



“Хамгаалал” клубын гишүүн хүүхдүүд “Хүүхдийн шийтгэлийг таслан зогсоох олон улсын өдөр” –ийг 3 дахь жилдээ тэмдэглэж нөлөөллийн үйл ажиллагаа явуулав. Улаанбаатар, 2009.4.30



Олон нийтэд түшиглэсэн Хүүхэд хөгжил, хамгааллын Төв дээр хүүхдүүд төрөл бүрийн сургалтад хамрагддаг. Улаанбаатар, 2005 он

²⁰ “Хамгаалал” клубын хүүхдүүдийн НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд явуулсан “Хүүхэд Хамгаалал: Өнөөдөр” тайлан, 2008



ХЭҮТ-ийн Хүүхэд Хамгааллын Нэгжийн тухай

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжих үед бий болсон нийгэм, эдийн засгийн өөрчлөлтүүдээс улбаатай ажилгүйдэл, ядуурал, архидалт, эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийлэл ихэссэн тэр үед эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний төрийн бус байгууллага Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв (1995 онд) байгуулагдсан билээ.

1997 он гэхэд ХЭҮТ нь хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд үзүүлдэг байсан үйлчилгээний хүрээгээ тэлж, гэр бүлийн хүчирхийллийн үр дагавартай нүүр тулан ажилладаг цагдаагийн ажилтнууд, багш, сургуулиудад хүрч ажиллаж эхэлсэн юм. ХЭҮТ-ийн үйлчилгээ өргөжин хүчирхийллийн асуудлаархи олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлж гэгээрүүлэх, цагдаа, хүүхдийн хорих, хуульч эмэгтэйчүүдийн холбоо болон эмэгтэйчүүдийн бусад байгууллагууд, хүүхдийн төлөө төвүүдийн ажилтнуудыг сургах, сургалтын материал, гарын авлага бэлдэх зэрэгт ХИС-гийн арга зүйн болон санхүүгийн туслалцаа чухал үүрэг гүйцэтгэсэн билээ.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо эрс нэмэгдэж байсантай уялдуулан ХЭҮТ-ийн дэргэд 2001 онд ХИС-гийн арга зүйн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр "Хүүхэд хамгааллын нэгж" анх байгуулагдсан юм. Тэр цагаас хойш ХИС нь ХЭҮТ-ийн Хүүхэд Хамгааллын Нэгжийн гол хамтрагч байж, нэгжийн мэргэжлийн чадавхийг бэхжүүлэх, үйлчилгээг хөгжүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлсээр ирсэн билээ. Нэгжийн мэргэжилтнүүдэд хүүхэд хамгааллын талаар олон улсын туршлагаас сурах боломжийг олгон, хилийн чанадад танилцах аялал болон сургалт семинарт хамрагдах боломжийг бүрдүүлж өгсөнөөр ХИС хүүхэд хамгааллын Монголын анхны мэргэшсэн байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

2003 оноос Хүүхэд Хамгааллын Нэгж нь олон нийтийн түвшинд хүүхдийг хүчирхийлэл, дарамтаас хамгаалах хамтарсан багийн үйлчилгээний загварыг ХИС-гийн олон нийтэд түшиглэсэн төвүүдтэй хамтран Улаанбаатар хот болон Дорнод аймагт туршилтын журмаар хэрэгжүүлж эхэлсэн билээ. Одоо энэ загвар нь Засгийн газрын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөж, олон улсын бусад байгууллагуудын дэмжлэгтэйгээр олон газар хэрэгжиж байна.

Хүүхэд хамгааллын нэгжийн үйлчилгээ нь Засгийн газар, олон улсын болон орон нутгийн байгууллагууд, олон нийтэд нэгэнт танигдан тэдний дэмжлэгийг авах боллоо. 2008 онд ХЭҮТ хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн түр байрлах байрыг нээсэн нь Хүүхэд Хамгааллын Нэгжийн үйлчилгээний гол төв болоод байна. Мөн ХЭҮТ нь төрөөс санхүүжилтийн дэмжлэг авдаг цөөхөн төрийн бус байгууллагуудын нэг боллоо.

Хүүхэд Хамгааллын Нэгж нь анх байгуулагдсан цагаасаа хойш гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон 600 хүүхдэд зөвлөгөө өгч нөхөн сэргээх, хуулийн туслалцаа үзүүлэх зэрэг бусад дэмжлэгийг үзүүлээд байна. Энэ хугацаанд нийт 135 хүүхдийг түр байранд байрлуулж эрүүл мэнд, амь насыг нь хамгаалж чадлаа. Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээний гишүүн Хүүхэд Хамгааллын Нэгж нь хүчирхийлэлд өртсөн хүүхэд, тэдний гэр бүлд хэрэгцээтэй үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ хууль эрх зүйн болон бодлогын өөрчлөлтөд хувь нэмрээ оруулж байна.



**Монгол Улсын Хүүхэд
хамгааллын тогтолцоог
хөгжүүлье!**



Хүүхэд хамгааллын тогтолцоог хөгжүүлэх нь (2005 оноос)

Хүүхэд хамгаалал нь ХИС–гийн Монгол дахь Хөтөлбөр анх үүсгэн байгуулагдсан тэр цагаас эхлэн хөтөлбөрийн гол асуудлын нэг байсаар ирсэн билээ. Хүүхэд ямар ч үед хүчирхийлэл, дарамт, үл хайхрах байдал, мөлжлөгт өртөх эрсдэлтэй байдаг ч, шилжилтийн үеийн болон түүний дараах улс орны нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал Монголын хүүхдийн эмзэг байдлыг эрс нэмэгдүүлсэн юм. Тухайлбал, хүүхдүүд шилжилт хөдөлгөөнөөс улбаатай эдийн засгийн мөлжлөгт өртөх, орон гэргүй болох, сургууль завсардах, гудамжинд хараа хяналтгүй амьдрах, амьдарч буй орчиндоо хүчирхийлэл, дарамтад өртөх эрсдэл нэмэгдсэн юм.

ХИС эхний жилүүдэд тухайн үеийн нийгмийн зайлшгүй шаардлага хэрэгцээнд тулгуурлан хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүд буюу хараа хяналтгүй болон хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн хамгаалал, нөхөн сэргээх асуудалд голлон чиглэж ажилласан билээ. Хожим нь олон нийтэд түшиглэсэн хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний загварыг бий болгосноор ХИС–гийн хүүхэд хамгааллын үйлчилгээ өргөжин гэр бүлийн хүчирхийлэл, дарамтад өртсөн хүүхдүүдэд хүрэх болсон. Нийгмийн ажлын мэргэжлийг хөгжүүлэх, нийгмийн ажлын үйлчилгээний загваруудыг бий болгон хөгжүүлэх ХИС–гийн хүчин чармайлт нь хүүхэд хамгааллын тогтолцоонд зайлшгүй шаардлагатай мэргэжлийн чадавхийг бий болгох баттай суурийг тавьсан юм. ХИС, НХТ–тэй хамтран нийгмийн ажилтны ёс зүйн хэм хэмжээг анхлан боловсруулснаас (2006)

гадна сургуулийн нийгмийн ажлын болон сум, хорооны түвшин дэх нийгмийн ажлын бодлого, практикийн байдалд үнэлгээ хийж (2006–2007), Монгол Улсад мэргэжлийн нийгмийн ажлыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой дүгнэлт, зөвлөмжүүдийг гаргасан билээ. Мөн БСШУЯ–тай хамтран боловсруулсан сургуулийн нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолт, үлгэрчилсэн дүрэм зэрэг баримт бичгүүд нь сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээг шинэ шатанд гаргаж, хүүхдийг хүчирхийлэл, дарамт, ялгаварлан гадуурхах болон үл хайхрах явдлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, хүүхдэд ээлтэй боловсролын орчин бүрдүүлэхэд чиглэсэн байх боломжийг нээж өгч байна.

2005 он гэхэд ХИС хүүхэд хамгааллын чиглэлээр бусад оронд болон Монгол Улсад ажилласан туршлага дээрээ тулгуурлан хүүхэд хамгааллыг илүү цогц систем болгон хөгжүүлэх зорилтыг дэвшүүлэн тавихад бэлэн болсон байлаа. Улс орны хөгжлийн түвшин, нөхцөл байдал болон хүүхэд хамгааллын чиглэлээр нэгэнт бий болсон хөрс суурь нь хүүхэд хамгааллын асуудлыг илүү өргөн хүрээнд дэвшүүлж гаргах боломжийг ХИС–д олгосон юм. Хүнд нөхцөл дэх хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх, хүүхэд хамгааллын асуудлаар үндэсний болон орон нутгийн, мөн байгууллагын чадавхи бэхжүүлэх чиглэлд хийсэн ХИС болон бусад талуудын олон жилийн хүчин чармайлтын үр дүнд Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцооны баттай суурь нэгэнт тавигдсан билээ.

ХИС–гаас 2006 онд “Монгол Улс дахь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо” судалгааг хийсний үндсэн дээр хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог хөгжүүлэх зайлшгүй шаардлагатайг онцлон дүгнэсэн юм. ХИС 2006 оны 5 сард УИХ–ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Нийгмийн Бодлогын Байнгын Хороо болон НХХЯ–тай хамтран энэ судалгааны тайлангийн нээлтийг хийсэн нь хүүхэд хамгааллын тогтолцооны талаарх нийгмийн



ойлголтыг шинэ шатанд гаргах чухал алхам болсон билээ. Хүүхэд хамгааллын тухайлсан асуудлуудад анхаарч байсан үе шатнаас хүүхэд хамгааллын цогц, системтэй арга барилд шилжих цаг нь нэгэнт болсон байлаа.

Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хүүхэд хамгааллын ойлголтыг Монголд нэвтрүүлж, хүүхэд хамгааллын үндэсний тогтолцооны хэрэгцээ шаардлагыг нийгэмд ойлгуулахад ХИС анхдагч байснаараа бахархдаг. Хүүхэд хамгааллын тогтолцоог хөгжүүлэх тухай асуудал нь аль нэгэн байгууллага дангаараа хийх боломжтой ажил биш учраас Засгийн газар, олон улсын байгууллагууд болон үндэсний төрийн бус байгууллагуудтай бүх шатанд хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд ХИС онцгой анхаарал хандуулж ирсэн. Энэ үйл явцад ХИС-гаас өнөөг хүртэл гүйцэтгэж ирсэн гол үүрэг нь хүүхэд хамгааллын тогтолцоог хөгжүүлэхийн төлөө нөлөөллийн ажилд төрийн бус байгууллагуудыг идэвхжүүлэх, үйл явцыг ялангуяа эхний шатанд чиглүүлэх, манлайлах, Засгийн газрын болон төрийн бус байгууллагуудын ажлын хэсэгт арга зүйн туслалцаа үзүүлэх явдлууд байлаа. ХИС энэ үйл явцын бүх шатанд төрийн байгууллагуудын үүрэг оролцоог дэмжиж, дээшлүүлэхэд онцгой анхааран ажиллав.

Олон улсын болон орон нутгийн байгууллагуудын хүүхэд хамгааллын талаарх ойлголт, хандлага, арга барил ялгаатай байсан учраас ХИС 2006 оноос эхлэн хүүхэд хамгааллын нэгдсэн ойлголтыг Монгол Улсад бий болгохын төлөө шургуу ажиллав. Хүүхдийн Төлөө Үндэсний Газар, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв, НХХЯ, Хүүхдийг Хүчирхийллээс Хамгаалах Төв зэрэг байгууллагуудтай хамтран хүүхэд хамгаалал болон хүүхэд хамгааллын тогтолцооны тухай үзэл баримтлалыг 2007 онд анх боловсруулж төрийн холбогдох байгууллагад өргөн барьсан юм. Мөн олон нийт болон бодлого боловсруулагчдад чиглэсэн, хүүхэд хамгааллын асуудлаар тэдний ойлголтыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэв. Хүчирхийлэл, дарамтад өртсөн хүүхдүүдийн бодит кейсүүд дээр үндэслэн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон тооны баримтат кино, нэвтрүүлэг, мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэж, “Хүүхдийн

эсрэг хүчирхийллийг нэн даруй зогсооё!” фото зургийн үзэсгэлэн гаргасан зэрэг нь хүүхэд хамгааллын асуудлаарх нийгмийн ойлголтыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. 2008 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажлын үеэр бодлого боловсруулагчдад чиглэсэн нөлөөллийн ажлын хэсэг болгож ХИС-гаас хүүхэд хамгааллын эвслийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан нээлттэй хэлэлцүүлэгт улс төрийн 11 нам, иргэний нийгмийн 22 байгууллага оролцож санал солилцсон нь хүүхэд хамгааллын асуудлыг төрийн бодлогын түвшинд авч үзэхэд чиглэгдсэн бас нэгэн том алхам болов.

ХИС болон бусад байгууллагууд, ялангуяа олон улсын болон орон нутгийн хүүхдийн байгууллагууд, мэргэжилтнүүдийн хүчин чармайлтын үр дүнд хүүхэд хамгааллын асуудлаар тодорхой ахиц дэвшил гарч байна. ХИС хүүхэд хамгааллын тогтолцооны асуудлыг анх хөндөж гаргасан 2006 оноос өнөөдрийг хүртэлх хугацаанд хүүхдийг бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах байдлаас хамгаалах, хүүхдийн хамгаалагдах эрхийн талаархи ойлголт нийгэмд бий болжээ.

Хүүхэд хамгааллын тогтолцоог хөгжүүлэхийн төлөөх нөлөөллийн ажилд Монгол Улсын Шадар сайдын ажлын алба, НХХЯ, ХТГ болон бусад төрийн ба төрийн бус байгууллагууд тухайлбал, хүүхэд хамгааллын эвсэл (25 байгууллага), хүүхэд хамгааллын үндэсний сүлжээний байгууллагуудын оролцоо, хувь нэмэр их байлаа. Өмнө дурдагдсан хүүхэд хамгааллын тогтолцооны тухай үзэл баримтлал дээр тулгуурлан “Монгол Улсын хүүхэд хамгааллыг бэхжүүлэх дунд хугацааны стратег (2009 – 2014)”-ийг боловсруулах ажлыг ХТГ зохион байгуулж байгаа ба НҮБ-ын Хүүхдийн Сан дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна. ХИС нь тус баримт бичгийн төсөлд санал, арга зүйн зөвлөмж өгч энэ үйл явцыг илүү үр дүнтэй болгоход тодорхой хувь нэмэр оруулж байна.

Энэхүү стратегийн баримт бичиг батлагдан гарснаар Монгол Улс дахь хүүхэд хамгааллын тогтолцоог зүй зохистой хөгжүүлэх ажилд томоохон дэвшил гарч, Монголын хүүхдийн амьдралд бодит өөрчлөлтийг авчрах түлхэц болно гэдэгт ХИС эргэлзэхгүй байна.

Хүүхдүүдтэй хамтран ажилласан туршлага (1994 оноос)

Хүүхдийн эрхийг бодитоор хангахын төлөө ХИС хүүхдүүдтэй хамтран ажилладагаараа үнэхээр бахархдаг. Хүүхдүүд ХИС-гийн хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт, бодлогын болон нөлөөллийн ажилд цаг ямагт идэвхтэй оролцож ирсэн бөгөөд өөрсдөө ч бие даан олон талын үйл ажиллагаа явуулдаг билээ.

Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд

"...2000 онд бид хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдтэй хамтран нэгэн судалгаа хийсэн юм. Хүүхдүүд Улаанбаатар хотын худалдааны захууд болон тэдгээрийн орчимд хүүхдүүд ямар ямар ажил хийдгийг судалж, ийм ажил хийж байгаа хүүхдүүдийн тоог анх удаа гаргасан юм. Хүүхдүүдийн гуйлга гуйх, бага насны хүүхдүүдийн тамхи татах, хулгай хийх, өвлийн хүйтэнд дулаан хувцасгүй ажиллах болон томчууд хүүхдүүдэд дээрэнгүй ханддаг зэрэг нь манай судлаач хүүхдүүдийн сэтгэлийг хамгийн их эмзэглүүлж байсныг би тод санаж байна. Улаанбаатар хотын план зураг дээр өнгийн цаасаар хүүхдийн хөдөлмөрийн хэлбэрүүдийг янз бүрийн дүрсээр төлөөлүүлэн хайчлан нааж тэмдэглэх нь хүүхдүүдэд их сонирхолтой байж билээ.

Хүүхдүүдийн хийсэн энэ судалгааны ажлын үр дүнтэй танилцсан ХИС-гийн ажилтнууд, түүний дотор тухайн үед ХИС-гийн захирал байсан Марк маш өндөр сэтгэгдэлтэй байсан. Мөн тэр үед Монголд Английн элчин сайд байсан хатагтай Кей Кумбс хүүхдүүдийг гэртээ урьж хийсэн судалгаатай нь танилцан, өөрийн гараар хийсэн бялуугаар дайлсан нь хүүхдүүдэд мартагдашгүй дурсамж болж байсан юм. Тэр хүүхдүүд дараа нь ХИС-тай олон жил холбоотой байсан. Судалгаа хийсэн хүүхдүүдээс Даваа гэдэг хүү ХИС-гийн захиалгаар мэргэжлийн байгууллагын хийсэн судалгааны багт орж ажилласан бөгөөд анхных нь цалингаас бид 50.000 төгрөгийн хадгаламжийг түүнд нээж өгч байсан..."

Ц. Баттуяа, ХИС-гийн "Хөдөлмөр эрхлэгч хүүхэд" төслийн ажилтан (1998–2002)

ХИС, гэрэл зургаар дамжуулан хүүхдийн бүтээлч сэтгэлгээ, өөртөө итгэлтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх чадварыг хөгжүүлэх зорилго бүхий "Хүүхэд ба Дуран" төслийг Монголын Урлагийн Зөвлөлтэй хамтран 2005 оноос хэрэгжүүлж байна. Д. Давааням (эхний эгнээнд, баруун гар талаас нэгдүгээрт) энэ төсөлд анх хамрагдаж эхлэхдээ 9 дүгээр ангийн зурагч байсан юм. С.Туяа багшийн удирдсан энэ сургалтад оролцсон энэ хүү фото зурагт чин сэтгэлээсээ татагдан, улмаар мэргэжлийн зураглаач болохоор шийдсэн юм. Түүний авьяас, уйгагүй хөлөлмөр ч үр дүнгээ өглөө.



Өнгөрсөн жилүүдэд Д.Давааням гэрэл зургийн хэд хэдэн уралдаанд амжилттай оролцсоноос гадна бие даасан хоёр ч үзэсгэлэнгээ гаргаад байна. Одоо Д. Давааням ХИС-гийн байнгын хамтран ажиллагсдын нэг бөгөөд ХИС-гаас хэвлүүлсэн олон номын зурагчнаар ажилласан төдийгүй хүүхдийн эрхийн асуудлаар хэд хэдэн баримтат кино хийсэн билээ. Мөн ХИС-тай хамтарч "Хүүхдийн эсрэг хүчирхийллийг нэн даруй зогсооё!" гэрэл зургийн үзэсгэлэнг 2008 онд гаргасан юм.

“Монголд анх удаа хүүхэд удирдан хийсэн “Хүнд нөхцөл дэх хүүхдүүд” судалгааг ХИС дэмжиж ажиллалаа. Судалгааг өмнө нь гудамжинд болон халамжийн төвүүдэд амьдарч байсан 19 хүүхэд гардан хийсэн юм. Хүүхдүүд хамтран ажиллаж, судалгааныхаа зорилго, арга зүйг тодорхойлж, судалгааны асуултуудаа боловсруулсан. Бид бие даан судалгааны мэдээллээ цуглуулж боловсруулан, дүн шинжилгээ хийж тайлангаа бэлдсэн. Судалгааныхаа дүнг ч мөн өөрсдөө танилцуулсан.

Хүүхэд удирдсан энэ судалгааны явцад судлаач хүүхдүүд шинэ мэдлэг эзэмшиж, шинэ найзуудтай болж, багаар ажиллаж, хамтын шийдвэр гаргаж байсан нь хүүхдүүд өөрсдийн чадвараа өсөн нэмэгдүүлэх том алхам болсон.

Хамгийн их таалагдсан зүйл гэвэл хүүхдүүд надад итгэж, амьдралаа ярьж судалгаанд оролцсон явдал байсан. Яагаад гэвэл ямар ч хүн танихгүй хүнд тэгж амьдралаа ярьдаггүй.”

Э. Энхсүвд, судлаач, 18 настай

“... Судалгаа хийх надад их таалагдсан. Хүүхдүүд судалгааны бүх ажлыг бие даан хийсэн. Судалгаа авсан хүүхдүүдээс нэг хүүхдийн яриа миний сэтгэлээс ер гарахгүй байгаа. Намайг гэрт нь очиход тэр хүүхэд гэрээ цэвэрлэчихсэн, дүүгээ хараад сууж байсан. Удалгүй аав нь орж ирээд загнаж байгаад унтаад өгсөн. Нэлээд байж байгаад ээж нь ирээд өнөө хүүхдийг загнаж, бас цохисон. Ээж аав хоёр намайг гэдэг боловч миний сэтгэлийг ойлгодоггүй, надтай бараг ярьдаггүй гэж тэр охин хэлсэн.”

Б. Ариунзаяа, судлаач, 18 настай



Байгууллагын шийдвэр гаргах үйл явцад хүүхдийн оролцоог хангах зорилгоор Их Британий Хүүхдийг Ивээх Сан “Дэлхийн Хүүхдийн Төлөө Зөвлөл”-ийг байгуулсан билээ. 2009 онд Лондонд болсон энэ зөвлөлийн хуралдаанд Монголын хүүхдүүдийг төлөөлөн З. Өлзийхүү (18 настай) хоёр дахь удаагаа оролцож Монголын хүүхдүүдийн нөхцөл байдал, асуудлуудын талаар танилцуулга хийсэн юм.

Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог илүү боловсронгуй болгон хөгжүүлэхэд хүүхдүүд өөрсдийн зүгээс маш их хувь нэмэр оруулж байна. Хүүхдүүд бодлого боловсруулагчид болон холбогдох байгууллага, хүмүүстэй уулзалт, ярилцлага зохион байгуулж, улс төрчдөд захидал илгээж,

хэвлэл мэдээллийн хэрэгслээр санал бодлоо илэрхийлж, хүүхдийн эрхийн асуудлаар шаардлага тавьж, өөрсдийн уран бүтээлээр дамжуулан үзэл бодлоо нийтэд хүргэх зэрэг олон хэлбэрийн үйл ажиллагааг бие даан зохион байгуулж байна.




2007 оны 11 сард Монголд анх удаа хүүхдүүд хэвлэлийн бага хурал зохион байгуулсан юм. Сургуулийн багш ангийнхаа гурван сурагчийг зодож шийтгэсэн асуудал гарсныг эсэргүүцэн хүүхдүүд хэвлэлийн бага хурал хийж байр сууриа илэрхийлэн, хүүхдийн эсрэг хүчирхийллийг зогсоохыг багш нар, эцэг эхчүүдэд уриалав.

2008 онд, ХИС-гийн олон нийтэлд түшиглэсэн төвүүдээр үйлчлүүлэгч хүүхдүүд болон хүүхдийн оролцооны бусад байгууллагуудын төлөөлөл болсон 27 хүүхэд “Хүүхэд хамгаалал-Өнөөдөр” тайлан бичиж НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд илгэлээ. Дөрвөн сарын хугацаанд хамтран ажиллаж судалгаа хийж, тайлан бичсэн энэ хүүхдүүд “Хамгаалал” нэртэй хүүхдийн оролцооны клуб байгуулан хүүхдийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа явуулж эхэлсэн юм. Клубынхан хүүхдийн эрх ашгийн төлөө улам ихийг хийх хүсэл зорилгоор 2009 оны 6 сард “Хүүхэд хүүхдийн төлөө” ТББ байгууллаа. Тэдний ахлагч Б.Цоггэрэл “Бид, томчууд болон бодлого боловсруулагчдыг хүүхдийн эрх, тэр дундаа хүүхдийн хамгаалуулах эрхийг мэддэг, хүндэтгэдэг болгохын төлөө тууштай ажиллана” гэж итгэл төгс хэлж байна.



Хүүхдийг Ивээх Сантай хамтран ажилладаг хүүхдүүдийн бүтээлээс:



ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРГЭН ДҮГНЭХҮЙ



ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРГЭН ДҮГНЭХҮЙ

ХИС–гийн Монголын хөтөлбөрийн өнгөрсөн 15 жилийн хугацаанд хийсэн ажил, хуримтлуулсан туршлагыг нэгтгэн ном болгох энэ ажил нь бидний хувьд Монголын хөтөлбөр анх яаж байгуулагдсан, цаг хугацааны явцад хэрхэн хөгжиж ирсэн, бид хэрхэн яаж ажилласнаа эргэж дүгнэж цэгнэх боломжийг олгосон чухал ач холбогдолтой үйл явдал байлаа. ХИС–гийн Монгол дахь үйл ажиллагааны үндсэн чиглэл нь НҮБ–ын ХЭЖ –оор батал–гаажуулсан эрх, үүрэг, хариуцлагын хүрээгээр ямагт тодорхойлогдож байсан бөгөөд улс орны хувьсан өөрчлөгдөж буй нийгэм, эдийн засгийн байдал, хүүхдүүдийн нөхцөл байдлаас шалтгаалан шалтгаалан манай хөтөлбөрийн бодлого, арга барил өөрчлөгдөн шинэчлэгдэж байсан юм. Эмзэг бүлгийн хүүхдүүд цаг ямагт манай хөтөлбөрийн онцгой анхааралд байсаар ирлээ. Хүүхдүүдийн эмзэг, эрсдэлтэй нөхцөл байдал, тэдний өмнө тулгарч байгаа бэрхшээлтэй асуудлууд болон боломжуудын талаарх бидний ойлголт ХИС–гийн болон бусад байгууллагуудын хийсэн судалгаа, дүн шинжилгээний үр дүнд байнга шинэчлэгдэн баяжиж ирсэн. Хүүхдийн боловсрол, хамгаалал, сайн сайхны төлөө хүүхдийн амьдралд шууд үр дүнгээ өгөх практик алхмуудыг хийхийн зэрэгцээ холбогдох бодлого, механизмыг боловсронгуй болгон бэхжүүлэх, хүүхдийн төлөө бидний хийх өөрчлөлтийг дэмжих хамтрагчдынхаа цар хүрээг байнга өргөжүүлэн ажиллаж ирлээ.

ХИС нь төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн түншлэгчид, хүүхдүүдтэй хамтран ажиллаж хуримтлуулсан мэдлэг, туршлага, сургамжаа үндэсний болон орон нутгийн түвшний бодлого, практикт нөлөөлөх ажилдаа ашиглаж Монголын хүүхдүүдийн сайн сайхны төлөө Монгол Улсын Засгийн газрын бодлогыг дэмжин ажиллаж ирсэн. Холбогдох байгууллага, мэргэжилтнүүдийн чадавхийг дээшлүүлэх, бодлогын болон хууль эрх зүйн шинэчлэлээр дамжуулан өөрчлөлтийн цар хүрээг өргөтгөх,

үр өгөөжийг нэмэгдүүлэхээр Засгийн газартай хамтран ажиллахын зэрэгцээ Засгийн газраас тодорхой асуудлаар авч хэрэгжүүлж байгаа алхам, арга барил нь хүүхдийн эрхийн зарчимтай нийцэхгүй тохиолдолд байр сууриа тодорхой илэрхийлсээр ирсэн юм. (Тухайлбал 2001 онд хараа хяналтгүй хүүхдүүдэд зориулсан цэргийн сургууль байгуулах тухай Засгийн газрын санал дээр ХИС эсрэг байр суурьтай байсан билээ.) Монгол Улсын Засгийн газрын бодлогод хүүхдийн асуудал ямагт чухал байр суурь эзэлдэг учир ХИС Монгол Улсад үйл ажиллагаа амжилттай явуулах таатай орчин хангагдсан байсан билээ. Монгол Улсын Засгийн газар ХИС–гийн Монгол дахь үйл ажиллагааг байнга дэмжиж, хамтран ажилладаг юм.

ХИС төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын болон орон нутгийн холбогдох байгууллага, эрдэмтэн судлаачид, хуульчид, мэргэжилтнүүд болон хэвлэл мэдээллийнхэн зэрэг бусад сонирхогч талуудтай хамтын ажиллагаа, харилцаа холбоогоо хөгжүүлэхэд онцгой анхаарч ажилладаг. ХИС хамтын ажиллагааныхаа зөвхөн үр дүнд нь төдийгүй үйл явцад нь ихээхэн ач холбогдол өгч энэ үйл явц нь оролцогч бүх талуудын хувьд харилцан суралцах, хөгжих боломжийг олгодог байхад анхаардаг.

ХИС олон талт хамтын ажиллагааныхаа хүрээнд хамтран ажилласан хүүхдүүд, эцэг эхчүүд, олон нийт, иргэний нийгмийн бүлгүүдийн чадавхийг бэхжүүлэхэд тодорхой үүрэг гүйцэтгэж чадсан гэж үздэг. Хүүхдүүд ХИС–гийн байнгын хамтрагчид байсаар ирсэн. Иргэний нийгмийн байгууллагуудтай ажилласан ХИС–гийн олон жилийн хамтын ажиллагаа нь Монгол Улсын иргэний нийгмийн хөгжил, төлөвшилд тодорхой хувь нэмрийг оруулсан. ХИС–гийн өөрийн бодит үйл ажиллагаагаар дамжуулан түгээн дэлгэрүүлж байсан “Хүүхдийн эрхэд суурилсан арга зүй” нь бусад сонирхогч талуудтай хэрхэн хамтран, нөлөөлж ажиллахад онцгой үр дүнтэй арга

хэрэгсэл болж байлаа. Чухамдаа, хүүхдийн эрхэд суурилсан арга зүй нь ХИС-гаас Монгол Улсад өвлөн үлдээж байгаа хамгийн чухал үнэт зүйл юм. ХИС Монгол Улсад ажиллаж эхэлсэн цагаасаа л иргэний нийгмийн хөгжлийг дэмжиж, өөрийн үйл ажиллагааг дэмжигч, хамтрагчдын цар хүрээг өргөтгөх нь үр дүнд хүрэх нэг гол нөхцөл хэмээн үзэж, энэ зарчмын дагуу ажилласаар ирсэн билээ. Энэ нь зөв байсныг амьдрал мөн баталж байна. Хүүхэд, эцэг эх, олон нийт, иргэний нийгмийн оролцоог хөгжүүлэх, хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаар үүрэг хүлээгчдийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь ХИС-гийн үйл ажиллагааны амаргүй боловч урамтай үр дүнд хүрсэн ажил байлаа.

ХИС-гаас иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран, дэмжиж ажиллаж байсан нь хүүхдийн асуудалд төвлөрөн ажилладаг ТББ-ууд идэвхижиж, хүчтэй болоход тодорхой үүрэг гүйцэтгэсэн гэж ХИС үздэг. 2004 онд ХИС-гийн дэмжлэгтэйгээр Монголын төрийн бус байгууллагууд анх удаа НҮБ-ын ХЭК-ийн хэрэгжилтийн талаар сүүдэр илтгэл бичиж НҮБ-ын ХЭХ-нд явуулж, тус хорооны хурлаар Монгол Улсын Засгийн газрын илтгэлийг хэлэлцэхэд биечлэн оролцсон билээ. ТББ-уудын ийм идэвхитэй оролцооны үр дүнд НҮБ-ын ХЭХ-оос Монгол Улсад өгсөн дүгнэлт, зөвлөмжинд (2005) Монголын хүүхдүүдийн нөхцөл байдлыг сайжруулах олон чухал заалтууд орсон юм. Энэхүү дүгнэлт зөвлөмжийг

хэрэгжүүлэх асуудлаар орон даяар хэлэлцүүлэг өрнөж, Хүүхдийн Хөгжил Хамгааллыг Сайжруулах Үндэсний Хөтөлбөрийн хоёр дахь шатны (2005–2007) үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөөг Засгийн газраас батлан гаргасан билээ. Энэ бүгд нь ТББ-ууд төдийгүй, оролцогч бүх талуудын хувьд үйл явцаас суралцах боломжийг олгож байсан юм. 2008 онд ТББ-ууд ХИС-гийн багахан дэмжлэгтэйгээр, НҮБ-ын ХЭК-ийн хэрэгжилтийн талаарх хоёр дахь удаагийн хөндлөнгийн илтгэлээ бэлдэж НҮБ-ын ХЭХ-нд явууллаа. Мөн энэ асуудлаар НҮБ-ын ХЭХ-нд хүүхдүүдийн хөндлөнгийн илтгэл бичих үйл явцыг ХИС дэмжиж ажиллалаа.

Хүүхдийн эрхэд суурилсан арга зүйг илүү сайн эзэмшсэнээр Монголын иргэний нийгмийн байгууллагууд хүүхдийн эрхийн төлөө тэмцлийг манлайлах болно. Ийм байгууллагуудын тэргүүн эгнээнд Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдүүдийн Эцэг, Эхийн Холбоо, “Хүүхдийн Эрх ба Боловсрол” эвсэл, Хүүхэд Хамгааллын Сүлжээний байгууллагууд явж байна. Ийнхүү, хүүхдийн эрхийн төлөө тэмцэл Монгол Улсад нэгэнт бодит зүйл болж чадлаа.

ХИС-гийн Монголд ажилласан туршлага, хүрсэн амжилтын үнэ цэнэ нь зөвхөн хүүхдийн сайн сайхны төлөө хийсэн өөрчлөлтүүд төдийгүй, өргөн утгаараа нийгэмд үзүүлсэн нөлөө, хүний эрхийг дээдэлсэн ардчилсан нийгмийг цогцлооход оруулсан хувь нэмэрт оршино.





Жон Буклер

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь захирал /1994–1999 он/

Хүүхдийг Ивээх Сангийн хөтөлбөрийн газрыг байгуулахаар 1994 оны цагаан сарын өмнөхөн би Монголд ирж байлаа. Багахан хэмжээний нэгээс хоёр жижиг хөтөлбөр хэрэгжүүлэх хэмжээний хөрөнгийн боломжтой, түүнээс цааших ажилд шаардагдах хөрөнгийг нэмж бүрдүүлэх шаардлагатай байлаа. Тухайн үед хэрэгжүүлж эхлээд байсан Монголын эдийн засгийн шинэчлэлийн үр дүн удахгүй гарч, 1990 онд олсон иргэний эрх чөлөөг бататгана гэж олон хүн үзэж байсан тул шилжин орж байгаа зах зээлийн эдийн засгийн шинэ нөхцөл байдалд дасан зохицох богино хугацаанд л дэмжлэг хэрэгтэй гэсэн байр суурь хүчтэй байсан юм.

Гэвч эдийн засгийн шинэчлэлийн бодлогын нийгмийн сөрөг үр дагавар асар их байлаа. Төрийн өмч хувьчлалын явцад хөдөө аж ахуйн нэгдлүүд үгүй болж, хот суурин газар руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн үүсч, хотод ажилгүй хүмүүсийн бөөгнөрөл бий болсон. Үйлдвэр аж ахуйн газруудын үйл ажиллагаа зогсолтонд орж нийтийг хамарсан ажилгүйдэл бий болж, өмнө нь байхгүйд тооцогддог байсан ядуурал хүн амын гуравны нэгийг хамарч, нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж эрс доголдсон юм.

ХИС хүүхдийн байгууллагуудтай ойр ажиллаж байснаараа хүүхдүүдийн амьдрал хэр хүнд байгааг цаг алдалгүй мэдрэх боломжтой байсан юм. Хүүхдийн Төлөө Үндэсний Төвтэй (ХТҮТ) хамтран хийсэн бидний анхны ажил бол хүүхдийн ажилтнуудад Хүүхдийн эрхийн конвенцийг танилцуулах, хүүхэд, олон нийттэй ажиллах оролцооны арга барил эзэмшүүлэх сургалтууд байлаа. Хожим нь энэ сургалт дээд сургуулийн нийгмийн ажлын хөтөлбөр болон өргөжиж, нийгмийн ажлын тэнхим сургуулийн нийгмийн ажилтнуудыг мэргэшүүлэн сургаж эхэлсэн юм. Энэ тэнхмээр бэлтгэгдсэн олон мэргэжилтнүүд хожим нь ТББ-уудад ажиллаж хүүхдийн өмнө тулгараад байсан нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд гар бие оролцож байсны дотор ХИС-гийн “Хот айл” төвүүдэд сайн дурын ажилтнуудаар ажиллаж байсан билээ. Гэр хорооллын жирийн айлуудын жишгээр зохион байгуулагдсан “Хот айл” төвүүдэд эцэг эхийн хараа хяналтгүй гудамжинд амьдарч байсан хүүхдүүд нийлж амьдарсан бөгөөд төвийнхөө үйл ажиллагааг өөрсдөө зохицуулдаг байсан. Эдгээр төвүүд нь өнчин хүүхдийн асрах газрын оронд бий болгосон үйлчилгээний шинэ хувилбар байсан билээ.

1994 онд Дэлхийн Банкны санхүүжилттэйгээр Ядуурлыг Бууруулах Үндэсний Хөтөлбөр (ЯБҮХ) эхлэхэд хүүхдүүд энэ хөтөлбөрийн гадна үлдэх ёсгүй гэж ХИС үзсэн юм. Тэд үед бидний хамгийн том зорилго тухайн үеийн Боловсролын яамтай хамтран, Сургуулийн Өмнөх Боловсролыг Хөгжүүлэх Үндэсний Хөтөлбөрийг (СӨБХҮХ) хэрэгжүүлэх замаар сургуулийн

өмнөх боловсролыг хямралаас хамгаалж үлдэх асуудал байсан юм. ХИС хүүхдийн хөгжилд сургуулийн өмнөх боловсролын гүйцэтгэж буй амин чухал үүргийг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ энэ үйлчилгээний гадна орхигдож байгаа ядуу, хөгжлийн бэрхшээлтэй болон малчдын хүүхдийн боловсролын асуудалд ихээхэн санаа зовниж байсан юм. НҮБХХ –ийн хүчин чармайлтын үрээр СӨБХҮХ нь Нидерланд Улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжих завшаан тохиож, ЯБҮХ–ийн хэрэгжилтийн механизмыг СӨБХҮХ–ийг хэрэгжүүлэхэд ашиглах боломжтой болсонд ХИС туйлын их баяртай байсан билээ.

Хамтран ажиллагсдын хувьд ХИС үргэлж азтай байсан. Тухайн үед улс төрийн намын харьяаллаар Засгийн газрын хамтрагчид ойр ойрхон солигдож байсан нь Засгийн газрын байгууллагууд үр дүнтэй ажиллахад ихээхэн саад болж байсан билээ. Гэхдээ ХТҮГ, Улаанбаатар хотын Хүүхдийн Төлөө Төв, ЯБҮХ, ШУБЯ–ны сургуулийн өмнөх боловсролыг хариуцсан хэлтэс зэрэг манай хамтрагч байгууллагуудын удирдлагууд үнэхээр гайхалтай, шилдэг эмэгтэйчүүд байсан.

Иргэний нийгмийн салбарт ч ХИС хамтын ажиллагаагаа хөгжүүлж эхэлсэн. Зайсан дахь төрийн Захиргаа, Удирдлагын Хөгжлийн Институт дээр залуу судлаач багш нарын байгуулсан Нийгмийн Хөгжлийн Төв (НХТ) нь ХИС–гийн хамтран ажиллаж ирсэн иргэний нийгмийн байгууллагын гол хамтрагч байсан билээ. ХИС 1990–ээд оны сүүлээр Английн Элчин сайдын яамнаас олгодог санхүүгийн тусламжтайгаар НХТ–д үйл ажиллагаагаа эхлэх гарааны санхүүжилтийг олгосон нь хожим нь ихээхэн үр дүн авчирсан юм. НХТ нийгмийн чиглэлээр мэргэшин ажиллаж, ялангуяа ЯБҮХ–ийн хэрэгжилтэнд хяналт тавих ажлыг амжилттай хийж байсныг нь харахад сайхан байдаг. НХТ–өөс 2006 онд оролцооны аргаар хийсэн ядуурлын судалгаа нь Монголын хүүхэд залуучууд, тэдний эцэг эхчүүд өөрсдийн нөхцөл байдлын талаар ямар бодол саналтай явдаг дүр зургийг тодорхой гаргаж чадсан билээ.

ХИС эхнээсээ л хөтөлбөрийн болон санхүүгийн шилдэг ажилтнуудыг авч ажиллуулсан. Тэдний дундаас хэд хэдэн хүн олон улсын хэмжээний ажилд дэвшин ажиллаж, НХТ–ийн судлаач нарын нэг нь хожим ХИС–гийн Монгол дахь захирлын хүндтэй албыг хашсан билээ. ХИС–д ажиллаж байсан олон хүмүүс НҮБХС болон бусад олон улсын байгуулагад хариуцлагатай ажлуудыг хийж байна. ХИС–тай хамтран ажиллаж, олон нийтийг зохион байгуулж байсан хүүхдийн ажилтнууд нь Монгол Улсын шилдэг ажилтнууд байсан бөгөөд тэдний нэг нь ТББ байгуулан амжилттай ажиллаж байна.

Хүүхдийн төлөөх Монголын энэ их авьяас, зүтгэл Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвслийн бие даасан гишүүн болж хөгжөөгүй нь харамсалтай. Энэ чиглэлд ажиллах боломжтой байсан үедээ Монголын ХИС–г үүсгэн байгуулах чиглэлийг сайн бодолцоогүйдээ би үнэхээр харамсдаг. Монголд ХИС–гийн хэрэгцээ



их хэвээрээ байгаа, өнөөдрийн хэрэгцээ 1994 онд байснаас ч их байж магад. 1990—ээд оны үеэс улбаатай шийдвэрлэгдэж амжаагүй байгаа олон асуудлуудаас гадна дэлхийн эдийн засгийн хямралын үр дагавартай Монгол Улс одоо нүүр тулах болж байна.

ХИС Монголд үйл ажиллагаагаа зогсоосны дараа түүний орон зайг хэн нөхөж, улс орны одоо ба ирээдүй болсон хүүхдүүдийн төлөө ХИС—гийн дуу хоолойг хэн үргэлжлүүлэх вэ? Монгол Улс газрын дорх ашигт малтмалаа олборлон экспортлоход бүх найдвараа тавиад байгаа энэ цаг үед байгалийн баялгаасаа “болоод” ядуу хүмүүсээр дүүрэн “баян” улс болохыг юу зогсоох бол?

Бусад улс орон хоёр гараа дэлгэн авахыг хүсэхүйц тийм ихийг нэгэнт бий болгосон Монгол шиг улс нэгэнт бий болгосон хүний нөөцийн болон бусад үнэт капиталгаа яагаад алдах ёстой гэдэг нь Латин Америк, Африк болон Зүүн Өмнөд Азид 20 гаруй жил ажилласны дараа Монголд ирсэн хөгжлийн ажилтны хувьд надад ойлгомжгүй хэвээр байгаа юм.

Англи, 2009 оны 5 сар



Марк Лапорт

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь захирал /1999–2003 он/

ХИС 2009 оны 7 сараас Монголд үйл ажиллагаагаа зогсоох шийдвэр гаргасныг анх сонсоход ХИС–гийн Монгол дахь хөтөлбөртэй сэтгэл зүрхээрээ холбогдсон бусад хүмүүсийн нэгэн адил надад хэцүү байсан. Энэ хөтөлбөрийг удирдан ажиллаж байсан 1999–2003 оны үеийнхээ дурсамжаас хуваалцахыг Тунгалаг надаас хүсэхэд ХИС–гийн төвүүдээр гэрээ хийсэн олон хүүхдүүдийн царай миний өмнө харагдах шиг болсон. Тэдгээр хүүхдүүд ХИС–гийн төвд амьдарснаар сургуульд сурч, боловсрол эзэмшин, бие даан амьдрах болсон билээ. Хожмын нэг өдөр тэр хүүхдүүд гэр бүл хэрэгтэй болсон хэн нэгэн хүүхдэд тийм орчныг бүрдүүлж өгч ч магад. Амьдралдаа анх удаа сургуульд явж үзээд инээмсэглэж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, хүүхдүүдийнхээ эрхийг хамгаалахын төлөө нэгдэж холбоо байгуулсан тэдний эцэг эхчүүдийн царай ч нүдэнд минь харагдах шиг болсон. Мөн боловсролын салбарын дэд бүтцийг хөгжүүлэх, хөтөлбөрийг боловсронгуй болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх, багш нарыг сургахад ХИС, түүний ажилтнууд ихээхэн хүчин чармайлт гаргаж, ихээхэн амжилтанд хүрсэн билээ.

Эргээд санахад, ХИС–гийн Монгол дахь үйл ажиллагааны хамгийн гол онцлох зүйл нь тэнд ажиллаж байсан хүмүүс юм гэж бодогддог. Тэдэнтэй ажиллахаас өмнө хүүхдийн төлөө зүрх сэтгэлээ бүрэн зориулсан, чин эрмэлзэлтэй, тийм чадварлаг хүмүүстэй ажиллах завшаан надад ховор тохиолдож байсан. Тиймээс ч 2008 оны 10 сард Монголд дахин очиход, миний үед ХИС–д ажиллаж байсан олон ажилтнууд НҮБ, олон улсын болон орон нутгийн төрийн бус байгууллагуудад удирдах ажил хийж байсанд би огтхон ч гайхаагүй ээ.

ХИС Монголын хүүхдүүдийн сайн сайхны төлөө ихээхэн хувь нэмэр оруулсан хэдий ч, Монгол дахь хөтөлбөрийн үйл ажиллагаагааг залгамжлан, цаашид үргэлжлүүлэх бүрэн чадвартай иргэний нийгмийн байгууллагуудыг хөгжүүлж, төлөвшүүлэхийн төлөө бүхнийг хийж амжсан эсэхийг би сайн мэдэхгүй байна.

Монголын хөтөлбөрийг хааж байгаа нь эдийн засгийн хямралын энэ үед тохиож байгаа нь бүр ч харамсалтай. Одоогоос 15 жилийн өмнө олон улсын төрийн бус байгууллага Монгол Улсад тэр улсын хэрэгцээ шаардлагад тулгуурлан хөтөлбөрөө нээж байсан бол одоо ямар хүчин зүйлийн улмаас хааж байгаа нь тийм ч ойлгомжтой биш байгаа юм.

Энэ завшааныг ашиглаад ХИС–гийн хамт олны бүрэлдэхүүнд багтан ажиллаж, өнгөрсөн 15 жилийн хугацаанд Монголын хүүхдүүдийн амьдралыг сайжруулахын төлөөх их үйлсэд өөрийн хувь нэмрээ оруулсан бүх хүмүүст чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Канад, 2009 оны 5 сар



Карло Пушкарица

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь захирал /2003–2004 он/
ХИС–гийн Монгол дахь хөтөлбөрийн хамгийн гол амжилт нь хүүхдийн эрхийн төлөө бусад оролцогч талуудыг уриалан нэгтгэхэд чухал хувь нэмэр оруулж чадсан явдал гэж би боддог. Төрийн байгууллагууд, ажилтнууд, олон улсын болон орон нутгийн төрийн бус байгууллагууд, эцэг эх, цагдаа, НҮБ–ын байгууллагууд, сургууль, цэцэрлэг, багш нар болон бусад олон хүн Монголын хүүхдийн амьдралыг сайжруулахын төлөө туйлын идэвхитэй ажилласан билээ. Мөн хүүхдүүд үргэлж бидний идэвхитэй хамтрагчид байсан.

ХИС–гийн Монголын хөтөлбөрийн хамт олонтой хамтран ажиллах боломж олдсонд би үргэлж баярладаг. Монголд ажилласан 2 жилийн хугацаанд манай хамт олны хүрсэн амжилтаар би бахархдаг. Манай хамтрагчид болон ажилтнууд ч үүгээрээ бахархдаг гэдэгт би итгэлтэй байна.

Косово, 2009 оны 5 сар



Чулууны Тунгалаг

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь захирал /2005–2007 он/
1996 оноос хойш өнөөг хүртэл олон жил Хүүхдийг Ивээх Сантай ойр ажиллах аз надад тохиосон юм.

Анх би 2002 онд ХИС–д хөтөлбөрийн дэд захирлаар ажиллаж эхлэх тэр үед надад хамгийн их өндөр сэтгэгдэл төрүүлсэн зүйл бол хүүхдийн эрхийн төлөө ХИС–гийн үйл ажиллагаа, хичээл зүтгэлийн цар хүрээ, эцэг эцэг эх, олон нийт, үндэсний болон орон нутгийн түвшний төрийн байгууллагуудтай тогтоосон харилцаа холбоо, хамтын ажиллагаа байсан. Тэр үед хүүхэд хамгааллын болон боловсролын чиглэлээр олон шинэлэг ажлуудаас гадна ХИС–гийн хийсэн өөр нэг чухал ажил бол НҮБХС болон Дэлхийн Зөн олон улсын байгууллагуудтай хамтран Хүүхдийн Төлөө Үндэсний Газрын дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулах үйл явцыг бүх талаар дэмжин ажилласан явдал байсан. Энэ төслийн хүрээнд ХТҮГ өөрийн чиг үүргийг илүү тодорхой, оновчтой болгох, стратеги боловсруулах асуудлаар бүх аймаг орон нутагт хэлэлцүүлэг зохион байгуулсан билээ. Хоёр жил үргэлжилсэн энэ ажлын үр дүнд 2004 онд ХТҮГ–ийн шинэчилсэн чиг үүрэг болон дунд хугацааны стратегийг Засгийн газраас баталснаар, ХТҮГ нь Монгол Улсын Шадар сайдын шууд удирдлага доор, хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх, хянах Засгийн газрын гол байгууллагын үүрэг гүйцэтгэж эхэлсэн юм.

ХИС–гийн Монгол дахь захирлын албыг хаших хүндтэй үүрэг надад ирсэн жилүүд нь /2005–2007/ зөвхөн Монголын

хөтөлбөрийн хувьд төдийгүй байгууллагын бүх түвшин дэх их өөрчлөлтийн жилүүд байсан юм. Энэ бол ХИС дэлхий даяар өлсгөлөн, ядуурал, хүчирхийлэл дарамтад өртсөн, эрүүл мэнд болон боловсролын үйлчилгээний гадна орхигдсон, байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гамшигт нэрвэгдсэн олон сая хүүхдүүдийн амьдралд нааштай өөрчлөлтүүдийг авчрахын тулд үйл ажиллагааныхаа тэргүүлэх чиглэлүүд, ажиллах арга замаа эргэн харж, тодотгох их өөрчлөлт шинэчлэлийн жилүүд байсан. Мөн өмнө нь ХИС–гийн Лондон дахь төв болон бүсийн түвшинд байсан олон үүрэг, хариуцлагыг анх удаа улс орны хөтөлбөрийн түвшинд шилжүүлсэн жилүүд байлаа.

Монгол Улсын хувьд эдгээр он жилүүд нь зах зээлийн эдийн засагт шилжсэн үеэс хойш улсын эдийн засгийн байдал хамгийн сайн байсан үе байлаа. Монгол Улс өмнөх жилүүдээс хол илүү нөөцтэй, Монголын хүүхдүүдийн нөхцөл байдлыг сайжруулах илүү боломжтой болсон байсан. Хүүхдийн эрхийн төлөө тэмцэх иргэний нийгмийн байгууллагууд ч идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг болсон байв.

Ийм нөхцөлд ХИС–гийн Монгол дахь хөтөлбөр хүүхдийн эрхэд суурилсан арга зүйг бүрэн утгаар нь ашиглах, хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаар үүрэг хүлээгчдээс тэдний үүрэг хариуцлагыг шаардах чиглэлд үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажилласан юм. Өмнө жилүүдийн туршлага дээрээ тулгуурлан хүүхдэд үзүүлэх хөтөлбөрийн үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор хөтөлбөрийн үйл ажиллагаагаа судалгаа болон бодлого, нөлөөллийн ажлуудаар баяжуулах, баталгаажуулах цаг нь ирсэн байсан юм. Бидний шинээр эхлүүлсэн бодлогын түвшний болон нөлөөллийн ажлуудын ар талд чанарын өндөр түвшинд хийгдсэн судалгааны ажлууд, ХИС–гийн бусад улс оронд болон Монголд туршиж хэрэгжүүлсэн бодит ажлын туршлага байлаа. Төрийн болон төрийн бус олон тооны хамтрагчидтай хүчээ нэгтгэж, бидний хийх өөрчлөлтийг дэмжигч байгууллагуудын хүрээг өргөжүүлэн ажилласнаар бид бүгд хамтдаа их зүйлийг хийж чадсан.

ХИС–гийн Монгол дахь хөтөлбөрийн авьяаслаг, чадварлаг хүмүүстэй хамт ажиллаж байсандаа би маш их баярладаг. Энэ хамт олны нэг гишүүн байх нь үргэлж урам зориг нэмсэн, онцгой сайхан туршлага болж байдаг. ХИС–гийн хамгийн гол гайхамшигтай зүйл нь тэнд ажилласан хүн бүр, ямар ч албан тушаалд байлаа гэлээ маш их хөгждөг гэж би боддог. Өнгөрсөн 15 жилд энэ байгууллагад ажиллаж байсан хүн нэг бүрээс ийм өөрчлөлтийг бид харж бахардаг.

Энэ боломжийг ашиглан ХИС–гийн бүх ажилтнууд, хамтран зүтгэгчдэд Монголын хүүхдүүдийн сайн сайхны төлөө хийсэн нөр их ажил, зориулсан сэтгэл зүтгэлийнх нь төлөө чин сэтгэлийн талархал дэвшүүлж, хамгийн сайн сайхныг хүсье.

Улаанбаатар, 2009 оны 6 сар



Мицуаки Тоёода

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь захирал /2007–2009 он/
Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөртэй ажилласан энэ хоёр жилийн хугацаанд надад мартагдашгүй сайхан сэтгэгдэл төрүүлсэн олон үйл явдал болж өнгөрсөн. Захирлын хувьд би ажилтнуудаа уриалан дуудаж, урам зоригийг нь дэвжээж байх үүрэгтэй ч манай ажилтнууд болон хамтрагчид Монголын хүүхдүүдийн төлөө, ялангуяа эмзэг бүлгийн хүүхдүүдийн төлөө чин сэтгэлийн зүтгэл нь намайг байнга урамшуулж байлаа. ХИС–д ажилласан энэ богинохон хугацаанд надад тохиолдсон хамгийн дурсамжтай зарим үйл явдлуудаас та бүхэнтэй хуваалцахыг хүсч байна.

Нэг өглөө би Улаанбаатар хотын хүүхдийн халамж үйлчилгээний төвөөр орж үзэхээр шийдсэн юм. Хараа хяналтгүй хүүхдэд үйлчилдэг энэ төв нь нэг удаад 56 хүүхэд түр байрлуулах хүчин чадалтай бөгөөд хүүхдүүдийн нэр хаягийг тогтоох, эцэг эх нь ирж авах хүртэл тэнд нь байлгаж үйлчилдэг. Энэ төвийн талаар би өмнө нь ажилтнуудаасаа олон удаа сонссон байсан. Тэр өглөө надад бага зэрэг цаг гарсан учраас би нэг ажилтантайгаа тэнд очиж үзэхийг хүссэн юм.

Хэдийгээр бид урьдчилан цаг аваагүй боловч тэнд ажиллаж байсан ажилтан биднийг төвд орж үзэхийг зөвшөөрсөн. Ерөнхийдөө хүүхдийн хорих маягтай харагдаж байсан ч төвийн ерөнхий байдал нь миний төсөөлж байснаас илүү дээр байлаа. Хүүхдүүд тэнд 24 цагийн хяналтан доор байдаг бөгөөд биднийг очиход 3–16 насны хүүхдүүд байрлаж байсны гуравны нэг орчим нь охид байсан.

Хонгилоор явж байхад хажуу өрөөнөөс хүүхдүүдийн ярих чимээ гарахаар нь би сониуч зандаа хөтлөгдөн хаалганд гаргасан жижиг цонхоор тэнд юу болж байгааг харсан юм. Гайхалтай нь тэнд манай нэг ажилтан хүүхдүүдтэй ажиллаж байлаа. Харамсалтай нь ХИС төвд байгаа хүүхдүүдэд амьдрах ухааны долоо хоног тутмын сургалт зохион байгуулаад хэдэн сар болж байсныг би тэгэхэд мэдээгүй байсан юм. Тэр сургалтынх нь үеэр би тэнд санамсаргүй очсон байжээ.

Би хэдэн минут тэнд чимээгүй зогсоод манай ажилтан хүүхдүүдтэй хэрхэн ажиллаж байгааг нь ажигласан юм. Тэр намайг тэнд өөрийг нь ажиглаад зогсож байгааг мэдээгүй, ажлаа үргэжлүүлж байсан. Хүүхдүүдтэй хэрхэн чин сэтгэлээсээ, бас ямар чадварлаг ажиллаж байгааг нь хараад надад үнэхээр хүчтэй сэтгэгдэл төрсөн. Өөрсдийнх нь хамгийн дотно хүмүүсийнхээ зүгээс хүчирхийлэл, дарамтанд өртсөн, тэдэндээ ад шоо үзэгдсэн эдгээр хүүхдүүдийн амьдралыг илүү гэрэл гэгээтэй болгохын төлөө тэр өөртөө ноогдсон үүргээ ингэж чин сэтгэлээсээ хийж байхыг хараад би үнэхээр баярлаж, бахархсан.

ХИС–гийн Монгол дахь захирлын хувьд би Засгийн газраас хүүхдийн асуудлаар зохион байгуулсан бодлогын хэлэлцүүлэг,

семинар зэрэг олон арга хэмжээнд оролцдог. 2008 оны эхээр хүүхэд хамгаалын асуудлаар зохион байгуулсан үндэсний семинарт би дэд захирлынхаа хамт очиж оролцсоноо санаж байна. Хэлэлцүүлэгт олон улсын болон орон нутгийн 120 гаруй байгууллага оролцсон юм. Үндсэн илтгэлүүдийн дараагаар, асуулт хариултын цагаар манай дэд захирал төр засгийн зүгээс анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай байгаа хүүхэд хамгааллын асуудлуудын талаар ярьсан юм. Тэрээр хэлэлцүүлэгт оролцсон улс төрчдөөс сонгуулийн үед амласан зүйлүүдээ хэрэгжүүлэх, хүчирхийлэл, дарамтаас хамгаалагдах хүүхдийн эрхийг хангахыг уриалсан юм. Тэр тэнд байсан хүмүүс ойлгохгүй, хүлээж авахгүй байхын аргагүйгээр, хүүхэд хамгааллын тогтолцоог хөгжүүлэх нь зайлшгүй шаардлагатай болохыг маш оновчтой, тодорхой байдлаар туйлын чадварлагаар ойлгуулж чадсан юм.

ХИС–гийн Дорнод аймагт хэрэгжүүлж байгаа боловсролын болон хүүхэд хамгааллын төслүүдийн хэрэгжитийн байдалтай танилцахаар очсон юм. Тэнд ХИС–гийн дэмжлэгтэйгээр 2003 онд байгуулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн сэргээх төвөөр орж үзсэн. Аймгийн эмнэлгийн байрны 3 өрөөнд байрладаг энэ төв нь нэг зэрэг 2–3 хүүхдэд нөхөн сэргээх үйлчилгээ хийх боломжтой бөгөөд аймгийн хэмжээнд байгаа хөгжлийн бэрхшээлтэй 900 гаруй хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлж байгаа цорын ганц байгууллага юм. Төвийг эмнэлэг болон Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдүүдийн Эцэг Эхийн Холбоо /ХБХЭЭХ/ хамтран ажиллуулдаг.

Хэдийгээр хүчин чадал бага, үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг хангах санхүүгийн нөөцийн хүндрэлтэй ч эмнэлэг болон ХБХЭЭХ хамтран энэхүү төвийн үйл ажиллагааг тасралтгүй явуулж байгааг хараад надад их өндөр сэтгэгдэл төрсөн. Эцэг эхчүүд төв дээр ирж хүссэн зөвлөгөөгөө авч, хүүхдүүд нь нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдах боломжтойгоос гадна хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ойлгодог, тэдний төлөө санаа тавьдаг, эрхийг нь хамгаалдаг хүмүүсийн тоо орон нутагт нэмэгдэж байгааг хараад тийм сэтгэгдэл төрсөн юм. Зөвхөн Дорнодод ч биш, улсын хэмжээнд ийм үйлчилгээ өмнө нь байхгүй байсантай харьцуулахад энэ бол маш том амжилт, ахиц дэвшил юм.

Эдгээр жишээнүүд нь Монголын хүүхдүүдийн сайн сайхны төлөө ХИС–гийн хийж ирсэн олон талт үйл ажиллагааны ердөө нэгээхэн хэсэг. Ийм практик ажлууд, бодлогын нөлөөллийн ажлууд болон дэмжигч хамтрагч багаа бүрдүүлэх, энэ бүгд хүүхдийн амьдралыг сайжруулахад биднийг чиглүүлж байдаг. Тэгэхдээ миний хувьд ХИС–д ажилласан энэ хугацаанд ХИС–гийн тодорхой стратеги, арга барил гэхээсээ илүүтэйгээр энд ажиллаж байгаа хүмүүс надад хамгийн их сэтгэгдэл төрүүлсэн. ХИС–д надтай хамт ажиллаж байгаа хүн бүр өөр өөр мэдлэг боловсрол, туршлагатай, өөрийн гэсэн давуу талуудтай, зан чанарын хувьд ч өөр өөр хүмүүс. Гэхдээ бүгд хүүхдийн төлөө гэсэн чин сэтгэлтэй, нэг зорилгын дор нэгдсэн, Монгол Улсынхаа хөгжилд



тодорхой хувь нэмрийг оруулж байгаа хүмүүс. Би хүүхдийн төлөө гэсэн чин сэтгэлтэй, чиглэсэн зорилготой ХИС–гийн ажилтнууд болон ХИС–тай хамтран ажиллаж байгаа бусад хүмүүсээс маш их зүйлийг сурч мэдсэн.

Өнгөрсөн 15 жилд хүүхдийн эрхийг Монголд бодитойгоор хэрэгжүүлэхийн төлөө Их Британийн ХИС–гийн хийсэн болон хийж амжаагүй бүхнийг Японы ХИС болон бусад байгууллагууд үргэлжлүүлэн хийж Монголын хүүхдүүдийн амьдралыг сайжруулах бидний үйл хэрэг тасралтгүй үргэлжилнэ гэдэгт би итгэлтэй байна.

Улаанбаатар, 2009 он

ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН МОНГОЛ ДАХЬ ХӨТӨЛБӨР ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЖ БАЙНА

ХИС—гаас Монголын хүүхдүүдийн хөгжил, сайн сайхны төлөө өнгөрсөн 15 жилийн хугацаанд хийсэн ажил, хүрсэн амжилтад биднийг дэмжин, хамтран ажилласан байгууллага, хувь хүмүүсийн оруулсан хувь нэмэр үнэлж баршгүй билээ.

ХИС—тай хамтран ажиллаж, ертөнцийг хүүхдийн нүдээр харахад бидэнд тусалж, Монголын хүүхдүүдийн амьдралд бодит, тогтвортой өөрчлөлтийг хийхийн төлөө өөрсдийн дуу хоолойг нэгтгэн, идэвхтэй байр сууринаас оролцон, хүүхдийн эрхийн төлөө их үйлсэд өөрсдийн хувь нэмрийг оруулсан олон зуун хүүхэд, залуучуудад чин сэтгэлийн талархал илэрхийлж байна.

Хүүхдийн эрхийн талаар нийгмийн ойлголт, хандлагыг өөрчлөх, гэр бүлийн орчин болон сургууль, олон нийтийн түвшинд хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэхийн төлөө бидэнтэй хамтран ажилласан эцэг эхчүүд, олон нийтэд ХИС гүнээ талархаж байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийн төлөө идэвхитэй тэмцэгч Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдүүдийн Эцэг Эхийн Холбоонд тусгайлан талархал дэвшүүлье.

Үндэсний хэмжээнд болон орон нутгийн түвшинд бидэнтэй хамтран ажилласан төрийн болон төрийн бус байгууллагуудын хүндэт хамтран зүтгэгчдэдээ чин сэтгэлийн талархал илэрхийлж байна. Монгол Улсын Шадар сайдын ажлын алба, Хүүхдийн Төлөө Газар, БСШУЯ, НХХЯ болон манай ажлыг дэмжиж хамтран ажиллаж байсан орон нутгийн засаг захиргаанд ХИС тусгайлан талархал илэрхийлж байна. ХИС—гийн хамтрагч, иргэний нийгмийн байгууллагууд, “Боловсрол ба Хүүхдийн Эрх” эвсэл, “Хүүхэд Хамгаалал” эвсэл, хүүхэд хамгааллын сүлжээний байгууллагуудад хүүхдийн эрхийн асуудлаарх бодлого, хууль эрх зүйн өөрчлөлтийн төлөө бидэнтэй хамтран ажиллаж байсанд ХИС гүн талархлаа дэвшүүлж байна.

Бидэнтэй хамтарч, мөн харилцан бие биенээ хурцлан ажиллаж байсан хүүхдийн төлөө болон олон улсын бусад байгууллагуудад хүүхдийн эрхийн төлөө тууштай тэмцэж байдаг нь ХИС талархал илэрхийлж байна.

ХИС—гийн Монгол дахь хөтөлбөрийн чадавхийг бэхжүүлэхийн төлөө бидэнтэй хамтран ажиллаж байсан олон улсын болон үндэсний зөвлөхүүддээ бид чин сэтгэлийн талархлаа дэвшүүлж байна. Мөн Монголын хүүхдүүдтэй ажиллахын төлөө өөрсдийн үнэт цагаа сэтгэл харамгүй зориулж байсан сайн дурын ажилтнууд, тухайлбал Анжелито Менисэс, Сэсил Трафолт, Давид Грин, Рачел Стонесифер болон Сунари Маршал нарт гүнээ талархаж байна.

ХИС—гийн бүсийн захирал Рожер Нютон, Грег Дули, бүсийн менежер Марк Капалди, Дан Колишин, Араяа Дижанипонт, Винсом Хулл болон Бен Боксер нарт өнгөрсөн хугацаанд Монголын хөтөлбөрт удирдлагын болон техникийн дэмжлэг үзүүлэн ажиллаж ирсэнд бид гүн талархлаа дэвшүүлье.

Өнгөрсөн бүх хугацаанд ХИС—гийн Монголын хөтөлбөрийн хамт олны бүрэлдэхүүнд багтан ажиллаж байсан бүх ажилтнууддаа Монголын хүүхдүүдийн төлөө зориулсан чин сэтгэл, хичээл зүтгэлийнх нь төлөө ХИС гүн талархал дэвшүүлж байна. Ийм авьяаслаг, чадварлаг, хичээл зүтгэлтэй хүмүүс ажиллаагүй бол ХИС—гийн Монгол дахь үйл ажиллагаа ийм амжилтанд хүрч чадахгүй байсан билээ. Монгол дахь хөтөлбөр анх нээгдсэн цагаас эхлэн өнөөдрийг хүртэлх бүтэн 15 жилийн хугацаанд Монгол орны өргөн уудам нутгаар биднийг ая тухтай зорчуулж байсан жолооч У.Ганбаатар, Монголын хөтөлбөрийн сүүлийн 13 жилийн хугацааны “санамжийг” тасралтгүй тээж явсан Л. Дулмаа нартаа чин сэтгэлийн талархал илэрхийлье.

ХИС—гийн Монгол дахь хөтөлбөрийг мэргэжлийн удирдлага, манлайллаар ханган ажиллах нэн хариуцлагатай үүргийг хүлээн, Монголын хүүхдүүдийн сайн сайхны төлөө сэтгэл зүтгэлээ зориулсан, ХИС—гийн Монгол дахь захирлын эрхэм албыг хашиж байсан Жон Буклер /1994–1999/, Марк Лапорте /1999–2003/, Карло Пушкирица /2003–2004/, Чулууны Тунгалаг /2005–2007/, Мицуаки Тоёода /2007–2009/ нарт ХИС гүн талархал дэвшүүлж байна.



ХАНДИВЛАГЧ БАЙГУУЛЛАГУУДДАА БАЯРЛАЛАА

ХИС–гийн Монгол дахь үйл ажиллагааг өнгөрсөн хугацаанд сэтгэл харамгүй дэмжиж ирсэн хандивлагч байгууллагууд болон ХИС–гийн Олон Улсын Эвслийн гишүүн байгууллагуудад ХИС чин сэтгэлийн талархал дэвшүүлж байна. Манай хандивлагчдын өгөөмөр хандив, тусламжийн үрээр ХИС–гийн Монгол дахь хөтөлбөрийн жилийн санхүүжилт 1994 оноос 2009 оны хооронд нэг зуун мянган фунт стерлингээс нэг сая фунт стерлинг болон өсч, ХИС өнгөрсөн 15 жилийн хугацаанд нийт 7,8 сая фунт стерлингийн хөрөнгийг Монголын хүүхдүүдийн сайн сайхны төлөө зориулсан билээ. Өөрсдийн сэтгэл харамгүй хандив, дэмжлэгээр ХИС–гийн Монгол дахь хөтөлбөрийн өнгөрсөн 15 жилийн хугацааны санхүүжилтийн дийлэнх хэсгийг бүрдүүлж байсан Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын иргэд, олон нийтэд ХИС гүн талархлаа дэвшүүлж байна.

Мөн Английн хатан хааны эрхэмсэг Элчин сайд, хатагтай Торда Аббот Вотт болон түүний өмнөх Элчин сайдууд, ноён Антони Мори /1991–1993/, Ион Слоне /1994–1997/, Жон Дурам /1997–1999/, хатагтай Кей Кумбс /1999–2001/, ноён Филипп Роус /2001–2004, ноён Ричард Остен /2004–2006/, ноён Кристофер Осборн /2006–2008/ нарт Монголын хүүхдүүдийн сайн сайхны төлөө ХИС–гийн ажлыг байнга дэмжин ажиллаж байсанд нь чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Манай хандивлагч байгууллагууд

Аксенчер, Япон
Азийн Хөгжлийн Банк
Арт Венчер, Сингапур
Аштан траст
Аустин энд Хоуп Пилкингтон сан
Австралийн Олон улсын хөгжлийн Агентлаг
Brook Hospital for Animals, UK
Монгол Улсад суугаа Их Британий Элчин сайдын яам
Канад Сан
Канадын Цирк Де Солей
Клара Е.Бургес Сан, Их Британи
Д.Жонс, Их Британи
Олон улсын хөгжлийн газар, Их Британи
Европын Холбоо
Европын Холбооны Хүмүүнлэгийн тусламжийн байгууллага
Фамэли Март, Япон
Финландын Сан
Дюфресне энд Готье Сан, Канад
Гоу Хэлп сан, Их Британи
Гуэрнсийн олон улсын тусламжийн хороо, Их Британи
Айсл оф Мэн

Японы шуудангийн хадгаламж эзэмшигчдийн олон улсын сайн дурын тусламжийн сан
Японы олон улсын хамтын ажиллагааны Агентлаг (JICA)
Жерсийн олон улсын тусламжийн хороо, Их Британи
ХААН Банк Сан, Монгол
Жон Лэинг тусламжийн сан
МКС Мани Казуо Шино, Япон
Японы Гадаад хэргийн яам
Михира Шокай Корпораци, Япон
Нидерландын Вант Улсын Бээжин дахь Элчин сайдын Яам
Оак Траст
Энх тайвны салхи, Япон
Хүүхдийг Ивээх Сан, Япон
Хүүхдийг Ивээх Сан, Нидерланд
Хүүхдийг Ивээх Сан, Швед
Хүүхдийг Ивээх Сан, Их Британи
Seeds of Light Foundation, Hong Kong
Европын Холбооны техник туслалцааны байгууллага (TACIS)
Уено Корпорац, Япон
НҮБ–ын БШУСБ (UNESCO)
НҮБ–ын Хүүхдийн Сан

ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГААС ХЭВЛЭН ГАРГАСАН НОМЫН ЖАГСААЛТ (2005–2009)

Хүүхэд хамгааллын асуудлаар

2005 он

“Эцсийн хувилбар: Халамжийн газар хүмүүжиж буй хүүхдийн талаар улам ихээр түгшихүй” Эхний хувилбар цувралаас, ИБ ХИС, УБ, 2005

“Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Эрхийн Хорооны 39–р чуулганаас хүүхдийн эрхийн асуудлаар Монгол Улсад өгсөн дүгнэлт, зөвлөмж” ИБ ХИС, УБ, 2005

2006 он

“Монгол Улс дахь Хүүхэд Хамгааллын Тогтолцоо” судалгааны тайлан, Andy West, ИБ ХИС, УБ, 2006

“Хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо яагаад чухал вэ?” НҮБ–ын Ерөнхий Нарийн Бичгийн даргын албанаас зохион байгуулсан хүүхдийн эсрэг хүчирхийллийн тухай судалгаатай холбогдуулан Хүүхдийг Ивээх Сангаас дэвшүүлсэн гол зөвлөмжүүд, ИБ ХИС, УБ, 2006

“Хүнд нөхцөл дэх хүүхдийн амьдрал” судалгааны тайлан, ИБ ХИС, УБ, 2006

Х.Өлзийтунгалаг, Б.Нямсүрэн, “Нийгмийн Ажлын Практик”, ИБ ХИС, УБ, 2006

Мариан Вуудсайд, Трикиа МкКалм, Суанна Ж. Вилсон, “Нийгмийн Ажил: Кейс Менежемент ба үйл явцын тэмдэглэл” Нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага, ИБ ХИС, УБ, 2006

Нарны Цирк, Дэлхийн Цирк, “Хүүхдийг Нийгэмшүүлэх Тоглоомууд” Нийгмийн ажилтан, багш, сурган хүмүүжүүлэгч болон хүүхдүүдэд зориулав. ИБ ХИС, УБ, 2006

2007 он

“Хүүхэд Хамгаалал ба Хүүхэд Хамгааллын Тогтолцоо”, ИБ ХИС, ХТҮГ, ХХХТ, ХЭҮТ, УБ, 2007

Ц.Эрдэнэчимэг, Т.Амаржаргал, “Нийслэлийн Хорооны нийгмийн ажлын өнөөгийн байдал” судалгааны тайлан, ИБ ХИС, УБ, 2007

Шведийн ХИС, “Чиний аюулгүй байдал, Миний аюулгүй байдал”, ИБ ХИС, УБ, 2007

Лоуренс Л. Мартин (Ph.D, MBA, MSW), “Нийгмийн үйлчилгээг гадагш гэрээлэх систем боловсруулах тухай зөвлөмж” ИБ ХИС, УБ, 2007

“Аз жаргалтай амар тайван гэр бүлийг хүснэ...” Хүүхдүүдийн уран бүтээлийн цомог /фото зураг, радио/, ИБ ХИС, УБ, 2007

“Хүүхэд бид заавал бие махбод, сэтгэл санааны шийтгэл амсах ёстой юм гэж үү?” ИБ ХИС, УБ, 2006

“Садан төрөлд нь асран халамжлуулах нь: Гэр бүлдээ амьдрах боломжгүй хүүхдэд аюулгүй, эерэг халамж үзүүлэх нь”, Эхний хувилбар цувралаас, ИБ ХИС, УБ, 2007

“Хүүхэд Хүмүүжүүлэх эерэг аргууд: Эцэг эхэд зориулсан гарын авлага”, ИБ ХИС, ХХХТ, УБ, 2007

“Хүүхэд хамт олны төвд: Эмзэг хүүхдүүдэд халамж, үйлчилгээ үзүүлдэг хамт олны бүлгүүдэд зориулсан гарын авлага”, Эхний хувилбар цувралаас, ИБ ХИС, УБ, 2007



2008 он

Жоан Е. Дюррант, Ph.D, “Хүмүүжлийн Эерэг Аргууд: Юу Яаж”, ИБ ХИС, УБ, 2008

“Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн тухай Монгол Улсын гурав ба дөрөв дэх тайлан илтгэлтэй холбогдуулан Төрийн Бус Байгууллагуудаас НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд илгээх хөндлөнгийн илтгэл” ИБ ХИС, УБ, 2008

“Хүүхэд Хамгаалал-Өнөөдөр” НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд хүүхдүүдийн бичсэн илтгэл”, ИБ ХИС, УБ, 2008

С.Энхтуяа, Д.Олончимэг, Н.Оюут-Эрдэнэ, “Монгол Улс дахь нийгмийн ажлын хөгжил” судалгааны тайлан, ИБ ХИС, УБ, 2008

С.Энхтуяа, “Сургуулийн Нийгмийн ажлын өнөөгийн байдал” судалгааны тайлан, ИБ ХИС, УБ, 2006

“Хүүхэд ба Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл” сэтгүүлчдэд зориулсан гарын авлага, ИБ ХИС, Хэвлэлийн Хүрээлэн, УБ, 2008

2009 он

С.Энхтуяа, Д.Олончимэг, “Хороо, сум, багийн түвшинд хүүхэд хамгааллын үйлчилгээг олон нийтэд түшиглэн хамтарсан багаар үзүүлэх нь: Хамтарсан багийн гишүүд, бүх шатны засаг дарга, бодлого боловсруулагч нарт зориулав” гарын авлага, ИБ ХИС, УБ, 2009

Жэй Вискарвер, Рави Каркара, “Хүүхдийн эрхэд суурилсан арга зүй” сургалтын гарын авлага, ИБ ХИС, УБ, 2009

Хүүхдийг Ивээх Сангийн Олон улсын эвсэл, “Хүүхдийн эрхэд суурилсан арга зүй” Сургалтын гарын авлага”, ИБ ХИС, УБ, 2009

Б.Цоггэрэл, З.Бат-Өлзий, Н.Наранбаатар, “Анараа ба Хүүхдийн Эрх” ИБ ХИС, УБ, 2009

Боловсролын асуудлаар:

2005 он

Н.Энхцэцэг, “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өдөр тутмын амьдралд оролцуулах нь” ИБХИС, УБ, 2005

М.Батбаатар, Ц.Болд, Ж. Маршалл, Д.Оюунцэцэг, Ч.Тамир, Г.Түмэннаст “Шилжих Хөдөлгөөн Хүүхдийн амьдралд: Хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн ба хүүхдийн боловсролын хүртээмж” ИБ ХИС, УБ, 2005

Сандра С. Хуанг, “Казах хүүхдийн боловсролын байдлын дүн шинжилгээ” ИБ ХИС, УБ, 2005

2006 он

ХБХЭЭХ, “Хамтдаа хөгжицгөөе” хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн чуулганы тайлан ИБ ХИС, УБ, 2006

Я.Цэвээнлхазал, Ц.Гэрэлтуяа “Хөгжлийн бэрхшээл тэдгээрийн онцлог” ИБ ХИС, УБ, 2006

А.Ариунболд, Ш.Дэнсмаа, “Тоо тоолол” сургуулийн өмнөх боловсролын багш нарын багц үзүүлэн, ИБ ХИС, УБ, 2006

2007 он

Л.Отгонсүрэн, Г.Монголхатан, З.Болормаа, Ш.Дэнсмаа, Г.Мандухай, Ш.Цэрэннадмид, Ц.Түвшинтөгс. “Хувилбарт болон тэгш хамруулах сургалтын шилдэг туршлагауд” (Сургуулийн өмнөх болон бага боловсрол), ИБ ХИС, УБ, 2007

Л.Отгонсүрэн, “Сургуулийн өмнөх болон бага боловсролын залгамж холбоо” судалгааны тайлан, ИБ ХИС, УБ, 2007

Д.Уранчимэг, А.Болд “Харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд гэр бүл, хамт олны зүгээс үзүүлэх дэмжлэг туслалцаа” ИБ ХИС, УБ, 2007

З.Болормаа, Ч.Баянцэцэг, Я.Отгонжаргал, Ш.Дэнсмаа, А.Ариунболд “Явуулын багшийн сургалтын модуль: 4 настай хүүхэд”, ИБ ХИС, УБ, 2007

2008 он

О.Болор, В.Хажидмаа, Г.Одсүрэн, Д.Нансалмаа, Явуулын багшийн гарын авлага: 3 настай хүүхэд, ИБ ХИС, УБ, 2008

Талын холбоо ассоциаци “Өдөр бүр 20 минутыг хүүхэдтэйгээ” 6 настай хүүхэдтэй эцэг эхчүүдэд зориулсан гарын авлага, ИБ ХИС, УБ, 2008

СӨБББЧСТ баг, Сайн засаглал ТББ “Сургуулийн өмнөх болон бага боловсролын чанарыг сайжруулах нь” багц төслийн хүрээнд хийгдсэн суурь судалгааны хураангуй, ИБ ХИС, УБ, 2008

Г.Монголхатан, З.Болормаа, Л.Дэлгэрмаа, Ц.Оюунцэцэг, Х.Алтанхундага, Б.Цэцэгбал, Ц.Оюунчимэг, Л.Отгонсүрэн “Бага насны хүүхдийн хөгжлийн агуулгатай ном, гарын авлага, сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрт хийсэн шинжилгээний тайлан”, ИБ ХИС, УБ, 2008

Ч.Пүрэв–Очир, “Сургуулийн өмнөх боловсрол–эцэг эх олон нийтийн оролцоо”– үндэсний чуулганы эмхтгэл, ИБ ХИС, УБ, 2008

Д.Түмэндэмбэрэл, Б.Оюун–Эрдэнэ, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд тэгш хамруулан сургах бодлогын хэрэгжилтэд хийсэн судалгааны тайлан, ИБ ХИС, УБ, 2008

О.Нацагдорж, Б.Эрдэнэбилэг, Х.Алтанхундага, Н.Болор, “Дүрслэх урлаг” сургуулийн өмнөх боловсролын багш нарын багц үзүүлэн, ИБ ХИС, УБ, 2008

О. Чулуунцэцэг, С.Нарантуяа. “Математик” бага ангийн багш нарт зориулсан багц үзүүлэн, ИБ ХИС, УБ, 2008

Г.Лхаахүү, С.Нарантуяа “Цагаан толгой” бага ангийн багш нарт зориулсан багц үзүүлэн ИБ ХИС, УБ, 2008

Д.Хишигбуян, Л.Отгонсүрэн “Модуль сургалтын хөтөлбөр, сургагч багшийн гарын авлага” ИБ ХИС, УБ, 2008

СӨБББЧС төслийн баг, ХБХЭЭХ, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” үндэсний бага хурлын эмхтгэл, ИБ ХИС, УБ, 2008

Н.Ганбаатар “Аутизм ба амьдрал” ИБ ХИС, УБ, 2008

Б.Мөнхжаргал, Г.Эрдэнэбат, У.Пагма “Боловсрол ба Хүүхдийн эрх” ИБ ХИС, УБ, 2008



2009 он

А.Жаргал, У.Туяа, Ж.Энхтүвшин “Боловсролын хуулийн нэмэлт өөрчлөлтийн хэрэгжилтийн талаархи сургуулийн удирдах ажилтан, багш нарт зориулсан гарын авлага” ИБ ХИС, УБ, 2009

Ц.Одгэрэл, “ЕБС–д суралцагчдын бие махбодид халдах, хуульд заагаагүй төлбөр хураамж авах, ялгаварлан гадурхалтын байдал” суурь судалгааны тайлан ИБ ХИС, УБ, 2009

А. Канат, “Казах хэл 1”, Багш нарт зориулсан арга зүйн зөвлөмж, ИБ ХИС, УБ, 2009

А. Канат, “Казах ардын үлгэрүүд” (3 цуврал) ИБ ХИС, УБ, 2009

Рачел Стонесифер “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага” ИБ ХИС, УБ, 2009

Софи Ван Дэн Абили “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлийг дэмжих зөвлөгч эцэг эхчүүдийн гарын авлага” ИБ ХИС, УБ, 2009

Ж.Батдэлгэр, О.Болор, С.Сэлэнгэ Гэр бүлийн гарын авлага “Бага насны хүүхдийн хөгжил 3–5 нас”, ИБ ХИС, УБ, 2009

Р.Бумханд, А.Төгсжаргал, Б.Үүлэнсолонго, З.Болормаа “Намайг мэдэх үү?”, 1–3 настай хүүхэдтэй эцэг эхэд зориулсан зөвлөмж, ИБ ХИС, УБ, 2009

Т.Болор, Т.Мөнхцацрал, Б.Пүрэвдолгор, Д.Нарангэрэл, А.Нармандах “Явуулын багшийн гарын авлага: 5 настай хүүхэд”, ИБ ХИС, УБ, 2009

А.Нармандах, Т.Болор, Т.Мөнхцацрал “Бага насны хүүхдийн хөгжил” ИБ ХИС, УБ, 2009

Б.Батхүү “Сургуулийн өмнөх болон бага боловсролын чанарыг сайжруулах нь” багц төслийн дунд хугацааны үнэлгээний тайлан, ИБ ХИС, УБ, 2009

Л.Отгонсүрэн, О.Гончиг, Т.Болор “Хүүхэд төвтэй сургалтын арга зүй” судалгааны тайлан, ИБ ХИС, УБ, 2009

Д.Алтанцэцэг, Ш.Оюунцэцэг, Ерөнхий боловсролын сургуулийн 1–2 ангийн сурах бичигт үнэлгээ хийсэн тайлан, ИБ ХИС, УБ, 2009

ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОН ЦАГИЙН ЗУРАГЛАЛ БА МОНГОЛ УЛСЫН ХОЛБОГДОХ БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ӨӨРЧЛӨЛТҮҮД (1994–2009)

Доорхи хүснэгтэд сүүлийн 15 жилийн хугацаанд Монгол Улсад гарсан хүүхдийн холбогдол бүхий бодлого, хууль эрх зүйн орчны өөрчлөлт, дэвшил болон ХИС–гийн хөтөлбөрийн үүсэл хөгжлийн зарим онцлог үйл явдлуудыг дурьдсан болно. Эдгээр бодлого, хууль эрх зүйн өөрчлөлтөд ХИС ямар нэг үүрэг гүйцэтгэсэн гэсэн үг биш бөгөөд харин ХИС–гийн зорьж, хийж гүйцэтгэсэн ажлууд нь Монгол Улсын төрийн бодлого, хууль эрх зүйн өөрчлөлтүүдтэй хэрхэн уялдаж байсныг харуулахыг хичээсэн юм. Нөгөөтэйгүүр, энэ хугацаанд гарсан Засгийн газрын бодлого, хууль эрх зүйн өөрчлөлтүүдийн талаарх мэдээлэл нь бүрэн бус бөгөөд, зөвхөн ХИС–гийн үйл ажиллагаанд илүү хамаатай өөрчлөлтүүдийг хэсэгчлэн оруулсан болно.

ХИС–гийн хийсэн болон дэмжсэн ажлууд	ОН	Монгол Улсын Засгийн газрын бодлого, хууль эрх зүйн холбогдох өөрчлөлтүүд
<p>ХИС–гийн Монгол дахь төв байгуулагдаж, Монголын хөтөлбөрийн үйл ажиллагаа эхэллээ.</p> <p>Сургуулийн өмнөх боловсролын салбарын нөхцөл байдлын судалгаа хийгдэж, хүүхэд төвтэй бодлогын баримт бичиг гарлаа.</p> <p>ХТҮТ–ийн хүүхдийн ажилтнуудад НҮБ–ын ХЭК–ийг танилцуулах сургалтууд эхэллээ.</p>	1994	Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хууль батлагдлаа.
<p>“Нийгмийн хөгжил дэх оролцооны зарчмууд” болон “Хүүхэд төвтэй хөгжил” сургалтууд орон даяар явагдлаа.</p> <p>Сургуулийн өмнөх боловсрол олгох хувилбарт сургалтын шинэ хэлбэрүүд туршигдаж эхэллээ.</p>	1995	<p>Сургуулийн Өмнөх Боловсролыг Хөгжүүлэх Үндэсний Хөтөлбөр – I /СӨБХҮХ–I, 1995–2000/ хэрэгжиж эхэллээ.</p> <p>Монгол Улсын Засгийн газар НҮБ–ын ХЭК–ийн хэрэгжилтийн талаар анхны илтгэлээ НҮБ–д илгээлээ.</p>

<p>Нийгмийн ажлын үйлчилгээний хэрэгцээ тодорхойлох үнэлгээний ажил хийгдлээ.</p> <p>Монгол Улсад хөгжүүлэх нийгмийн ажлын чиг хандлагыг тодорхойлох үндэсний болон олон улсын зөвлөлдөх семинарууд зохион байгуулагдлаа.</p> <p>Хараа хяналтгүй, гудамжинд амьдардаг хүүхдүүдэд зориулсан “Хот айл” төвүүд байгуулагдлаа.</p> <p>“Хөдөлмөр эрхлэгч хүүхэд” төсөл эхэллээ.</p>	1996	<p>Ядуурлыг Бууруулах Үндэсний Хөтөлбөр /ЯБҮХ, 1996–2000/ хэрэгжиж эхэллээ.</p> <p>ЯБҮХ–ийн Орон нутгийн Хөгжлийн Сангийн дор сургуулийн өмнөх боловсролыг дэмжих дэд сан байгуулагдлаа.</p> <p>Монгол Улсын Шадар сайд хараа хяналтгүй, гудамжинд амьдардаг хүүхдүүдэд туслахыг хүсч олон улсын байгууллагуудад уриалга гаргалаа.</p> <p>Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль батлагдлаа.</p>
<p>УБИС дээр Нийгмийн ажлын сургалт судалгааны арга зүйн төв байгуулагдлаа.</p> <p>Нийгмийн ажлын баклавын анхны хөтөлбөр нээгдлээ.</p> <p>Сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээний загвар хөгжүүлэх туршилтын төслүүд хэрэгжиж эхэллээ.</p> <p>“ЯБҮХ–ийг бэхжүүлэх” техник туслалцааны төслүүд /1997–1999/ хэрэгжиж эхэллээ .</p> <p>Боловсрол Судлалын Сургууль дээр сургуулийн өмнөх боловсролын арга зүйн төв байгуулагдлаа.</p>	1997	
<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ердийн цэцэрлэгт хамруулах туршилтын төслүүд хэрэгжиж эхэллээ.</p>	1998	<p>БШУСЯ дээр Сургуулийн нийгмийн ажлын нэгж байгуулагдлаа.</p>
<p>Сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаанд хүүхэд төвт сургалтын арга зүйг нэвтрүүллээ.</p> <p>Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн “Мандах” холбоо дэмжиж ажиллалаа.</p>	1999	
<p>Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийг боловсролд хамруулах, мэргэжлийн боловсрол олгох ажил эрчимжлээ.</p> <p>Сургуулийн Өмнөх Боловсролыг Хөгжүүлэх Үндэсний Хөтөлбөр – I хэрэгжилтийн үнэлгээ хийгдлээ.</p>	2000	<p>Орон даяар ерөнхий боловсролын бүх сургуулиуд дээр сургуулийн нийгмийн ажилтны орон тоо батлагдлаа.</p>

<p>Зуд болсон орон нутгуудад гамшгийн тусламжийн төслүүдийг хэрэгжүүллээ.</p> <p>Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв дээр Хүүхэд хамгааллын нэгж байгуулагдлаа.</p>	2001	<p>Монгол Улсын Засгийн газар, НҮБХХ олон улсын нийгэмлэгт хандан зудын гамшигт нэрвэгдсэн орон нутагт тусламж хүссэн уриалга гаргалаа.</p> <p>Сургуулийн Өмнөх Боловсролыг Хөгжүүлэх Үндэсний Хөтөлбөр –2 /2001–2007/ хэрэгжиж эхэллээ.</p> <p>ОУХБ–ын “Хүүхдийн хөдөлмөрийг устгах тухай” 182 дугаар Конвенцид нэгдлээ.</p>
<p>Хүүхдийн Төлөө Үндэсний Газрын /ХТҮГ/дунд хугацааны стратеги боловсруулах ажлыг дэмжлээ.</p> <p>“Гудамжны хүүхэд” төслийн үнэлгээ хийгдэж, хараа хяналтгүй хүүхдэд үзүүлэх үйлчилгээний уялдаа холбоо сайжирлаа.</p> <p>Сургуулийн өмнөх боловсрол олгох хувилбарт сургалтуудын үнэлгээ хийгдлээ.</p>	2002	<p>Хүүхдийн Хөгжил, Хамгааллыг Сайжруулах Үндэсний Хөтөлбөр /ХХХСҮХ, 2002–2010/ хэрэгжиж эхэллээ.</p> <p>ОУХБ–ын “Хүүхдийн хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарын тухай” 138 дугаар конвенцид нэгдлээ.</p> <p>Эрүүгийн хуульд орсон өөрчлөлтөөр “Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг” гэсэн бие даасан бүлэг нэмэгдлээ. Хүүхдийг солих, хууль бусаар үрчлэх, хаях, төөрүүлэх, эцэг эх, эхнэр нөхөр, төрүүлсэн буюу үрчилж авсан хүүхдээ тэжээн тэтгэхээс ноцтойгоор зайлсхийх, хүүхдийг албадан хөдөлмөрлүүлэх зэргийг хүүхдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэрэг гэж хуульчиллаа.</p>
<p>Олон нийтэд түшиглэсэн хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний загварыг бий болголоо.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нөхөн сэргээх, олон нийтэд суурилсан үйлчилгээний загварыг бий болгон хөгжүүлээ.</p> <p>Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйлчилгээг турших, нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлээ.</p>	2003	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах хөтөлбөр батлагдан гарлаа.</p> <p>Монгол Улс НҮБ–ын Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг нэмэлт протоколд нэгдлээ.</p>

<p>Монголын ТББ-ууд анх удаа НҮБ-ын ХЭК-ийн хэрэгжилтийн талаар хөндлөнгийн илтгэл бичиж НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд илгээлээ.</p>	<p>2004</p>	<p>НҮБ-ын ХЭК-ийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Засгийн газар хоёр дахь илтгэлээ НҮБ-д илгээлээ.</p> <p>Хүүхдийн Төлөө Үндэсний Газрын /ХТҮГ/ шинэчилсэн чиг үүрэг, дунд хугацааны стратегийг Засгийн газар баталлаа.</p> <p>Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хууль батлагдлаа.</p> <p>Монгол Улс НҮБ-ын Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд ашиглахын эсрэг нэмэлт протоколд нэгдлээ.</p> <p>Бага насны хүүхдийн хөгжлийн цогц бодлого батлагдлаа.</p>
<p>Боловсролын салбарын стратегийн төлөвлөлтөнд мэдээлэл болгох зорилгоор “Шилжих хөдөлгөөн хүүхдийн амьдралд: Хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн ба боловсролын хүртээмж” судалгаа хийлээ.</p> <p>Боловсролын тухай хуулинд хүүхдийн эрхийн үүднээс дүн шинжилгээ хийлээ.</p> <p>Боловсролын тухай хуулинд холбогдох өөрчлөлтүүдийг оруулах нөлөөллийн кампанит ажлыг эхэллээ.</p> <p>“Хүүхдийн эрх ба боловсрол” эвсэл байгуулагдлаа.</p> <p>Сургуулийн өмнөх боловсролын байгуулагын удирлах ажилтнуудыг сургах сургалтын хөтөлбөр боловсрууллаа. Үндэсний болон орон нутгийн хэмжээнд сургалтууд зохион байгууллаа.</p>	<p>2005</p>	<p>Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт орлоо. Нийгмийн эмзэг бүлгийн иргэд, түүний дотор хүнд нөхцөлд байгаа хүүхдэд нийгмийн халамжийн сангаас зөвлөгөө өгөх, ур чадварын сургалтанд хамруулах, хөдөлмөр эрхлэлтэнд зуучлах, холбогдох төсөл, хөтөлбөрүүдэд зуучлан хамруулах зэрэг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэхээр тусгагдлаа.</p> <p>“Бүх нийтийн боловсрол” үнэлгээ хийгдлээ.</p> <p>“Хүүхдийн мөнгө” хөтөлбөр хэрэгжиж эхэллээ.</p> <p>Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр /2005–2015/ хэрэгжиж эхэллээ.</p>

<p>НҮБ–ын ХЭХ–оос НҮБ–ын ХЭК–ийн хэрэгжилтийн талаар Монгол Улсад өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх алхмуудыг орон даяар хэлэлцэх ажлыг дэмжлээ.</p> <p>Казах хүүхдийн боловсролын нөхцөл байдлын судалгаа хийлээ. Үндэсний цөөнхийн хүүхдэд хос хэлээр сурах боломжийг хангах хэрэгцээг гаргаж тавилаа.</p> <p>Дээрх судалгааг НҮБ–ын Арьс Өнгөөр Ялгаварлан Гадуурхахын Эсрэг Хороонд илгээсэн нь Засгийн газрын сүүдэр илтгэлийн үүрэг гүйцэтгэлээ.</p> <p>Казах хүүхдийн боловсрол төсөл хэрэгжиж эхэллээ. Хос хэлээр сурах тухай ойлголтыг нэвтрүүлээ.</p> <p>Сургуулийн болон Сум/Хорооны нийгмийн ажлын үйлчилгээнд үнэлгээ хийлээ. Нийгмийн ажлын үйлчилгээг хөгжүүлэх дүгнэлт зөвлөмж өгч ажлын байрны тодорхойлтыг тодотгох зөвлөмжүүд гарлаа.</p> <p>“Монгол Улс дахь хүүхэд хамгааллын тогтолцоо” судалгаа хийлээ.</p> <p>“Хүүхдэд үзүүлэх халамжийн үйлчилгээний стандарт”–ыг боловсруулан, нөлөөллийн ажил эхэллээ.</p> <p>“Хүнд нөхцөл дэх хүүхэд” судалгааг хүүхдүүд хийлээ.</p>	<p>2006</p>	<p>Боловсролын тухай хуульд өөрчлөлт орлоо. Сургалтын орчинд аливаа хэлбэрийн дарамт, хүчирхийлэл болон бие махбод, сэтгэл санааны шийтгэлийг хориглох, хүүхдээс хуульд заагаагүй янз бүрийн төлбөр хураамж авах замаар эдийн засгийн дарамт үзүүлэхгүй байх, бага ба дунд боловсролыг албан бус боловсролын системээр олгоход төрөөс санхүүжилт олгох зэрэг шинэ заалтууд орлоо.</p> <p>“Боловсролын салбарын мастер төлөвлөгөө” /2006–2012/ батлагдлаа.</p> <p>НҮБ–ын ХЭХ–оос Монгол Улсад өгсөн дүгнэлт, зөвлөмжийн дагуу ХХХСҮХ–ийн 2 дахь шатны хэрэгжилтийн үйл ажиллагааны төлөвлөгөө засгийн газраар батлагдлаа.</p>
<p>Хүчирхийллээс ангид боловсролын системийг дэмжиж төслүүдийг хэрэгжүүлж эхэллээ.</p> <p>Сургуулийн нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтыг боловсруулахад дэмжлэг үзүүлээ.</p> <p>Хүүхэд хамгаалал болон хүүхэд хамгааллын тогтолцооны тухай анхны бодлогын баримт бичиг боловсрогдон гарлаа.</p> <p>Нийгмийн үйлчилгээг ТББ–аар гэрээгээр гүйцэтгүүлэх зөвлөмж, заавар, журам боловсруулан НХХЯ–нд өргөн барилаа.</p>	<p>2007</p>	<p>Монгол Улсад багшийн ёс зүйн дүрэм хэрэгжиж эхэллээ.</p> <p>Бага насны хүүхдийн хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийг үнэллээ.</p> <p>Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр батлагдлаа.</p>

<p>Хүүхэд хамгаалын цогц тогтолцоог хөгжүүлэхийн төлөө нөлөөллийн ажил өрнөж, Хүүхэд Хамгааллын Үндэсний Эвсэл байгуулагдлаа.</p> <p>Монголын ТББ-ууд НҮБ-ын ХЭК-ийн хэрэгжилтийн талаар хоёр дахь удаагийн хөндлөнгийн тайлан илтгэл бичиж НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд илгээлээ.</p> <p>Монголын хүүхдүүд анх удаа НҮБ-ын ХЭК-ийн хэрэгжилтийн талаар хөндлөнгийн илтгэл бичиж НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд илгээлээ.</p>	<p>2008</p>	<p>Казах хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөр /2008–2012/ батлагдан гарлаа.</p> <p>Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль батлагдлаа.</p> <p>ОУХБ-ын 182, 138 дугаар конвенцууд, Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг НҮБ-ын нэмэлт протоколын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын тайлангууд бэлтгэгдэн гарлаа.</p> <p>Насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт шинэчлэн батлагдлаа.</p>
<p>Их Британийн ХИС-гийн Монгол дахь хөтөлбөр үйл ажиллагаагаа дуусгавар болгож, Японы ХИСМонголд үйл ажиллагаагаа эхэллээ.</p>	<p>2009</p>	<p>Хүүхэд хамгааллын үндэсний стратеги /2009–2014/ боловсруулах шатандаа явж байна.</p>



*Хүүхдийг Ивээх Сан:
Монголын хүүхдүүдийн төлөөх 15 жил*

ЗУРГИЙН ЦОМОГ